**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХШҮ-НИЙ ТАЙЛАН**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
**2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС**

2025 оны 01 дүгээр сарын 15 Номгон

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | 2024 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Нэгдсэн дүгнэлт | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | |
| 1 | 1.1.1. Аймгийн нутаг дэвсгэрт коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх, хүн амыг “Ковид-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, салбар дундын зохицуулалт, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангана. | 1. Коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах | 2021 - 2024 | | 100 | Аймгийн Засаг даргын 2023 оны А/253 дугаар захирамжаар тус аймгийн хэмжээнд бүх төрлийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, хариу арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангах, салбар дундын харилцан ажиллагааг шуурхай зохицуулах чиглэлээр албадын бэлтгэл бэлэн байдлыг хангаж хэрэгжилт 100 хувьтай байна. 2024 оны 12 дугаар сарын байдлаар коронавирусийн халдварын цар тахал дахин гараагүй болно. | |
| 2 | | 2. Аймгийн Засаг даргын нэрэмжит бэлтгэл, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах | 2021 - 2024 | Санхүүжилтийг 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний зардлаас 5,0 сая төгрөгийг зарцуулсан. | 100 | Аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг хангаж ажилласан. Энэ хүрээнд Баянхонгор аймгийн Баянлиг, Хүрээмарал сумдад гамшгаас хамгаалах “Иж бүрэн сургууль”, Богд, Жаргалант сумдад “Команд штаб” сургууль, Баян-Өндөр, Галуут сумдад аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах “Бэлэн байдлын үзлэг” тус тус зохион байгуулж, нийт 800 гаруй албан хаагчийг хамруулж ажиллалаа. Гамшгаас хамгаалах “Иж бүрэн” сургалтыг Хүрээмарал сум- 86 хувьтай, Баянбулаг сум 85 хувьтай. “Команд штаб”-ын сургуулийг Жаргалант сум 88 хувь, Богд сум 83 хувь, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Засаг даргын нэрэмжит “Бэлэн байдлын үзлэг”-ийг Галуут сум 90,6 хувь, Баян-Өндөр сум 83 хувьтай тус тус зохион байгуулсан. Бэлтгэл, бэлэн байдлын хангалтын хувь 83- аас дээш хувьтай байна. Санхүүжилтийг 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний зардлаас 5,0 сая төгрөгийг зарцуулсан. | |
| 3 | 1.1.2. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, халдваргүйжүүлэх бодис, тоног төхөөрөмжийн хангалтыг тасралтгүй нэмэгдүүлж, нөөцийг бүрдүүлнэ. | 1. Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөц бүрдүүлэх | 2021 - 2024 | | 95 | Эрүүл мэндийн салбарын эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, нийлүүлэх төлөвлөгөөг батлуулж, 365.439.900 төгрөгийн төсөвт өртөгтэй, 17 багцтай худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, 266.698.600 төгрөгийн гэрээ байгуулан нөөц бүрдүүлсэн. Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотой эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн судалгааг А/211 дүгээр тушаалын дагуу Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт хүргүүлсэн. Аймгийн Онцгой комисст тухай бүрт эм, тариа, урвалж оношлуур, эмнэлгийн хэрэгслийн мэдээг хүргүүлсэн. Улсын их хурлын 2008 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 30 дугаар тогтоолыг хангах зорилгоор эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийн мэдээг 7 хоног бүрийн 2 дахь өдөр Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт хүргүүлж байна. Улсын төсвөөр 2,6 тэрбумын төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл ханган нийлүүлэгдэж, нэгжүүдэд хуваарилан ажилласан. Нөөц бүрдүүлэлт 92 хувьтай байна. | |
| 4 | 1.1.3. Иргэдэд коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн зохион байгуулна. | 1. Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, | 2021 - 2024 | | 90 | Гамшгийн төлөвлөгөөнд тодотголоор Ковидын халдвараас сэргийлэх төлөвлөгөө батлуулан хавсаргаж, гамшгийн хуулийн хэрэгжилтийн хүрээнд тус оны 4 дүгээр сард мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангаж, 24 эрүүл мэндийн албан цугларч, аймгийн онцгой байдлын газрын үнэлгээнд хамрагдан, хангалттай үнэлгээ авсан Аймгийн хэмжээнд Ковид-19 халдварын 8 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 0.3 промиль байгаа нь 2023 оны мөн үеэс (1) 0.2 пр нэмэгдэж, нас баралт 1 бүртгэгдсэн. Тандалт хийж, 8 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтийг хангах | | | | тохиолдлын ойрын хавьтал болох 20 иргэнээс асуумж судалгаа авч, арга зүйн зөвлөгөө өгч, халдварын тархалтаас сэргийлж ажилласан. Жилийн эцсийн байдлаар тусгаарлах эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа хүн байхгүй. Коронавируст халдварын өвчний дэгдэлтийн үед шаардлагатай 26 нэр төрлийн эм бэлдмэл- 6125 ш, 43 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис- 274,142 мг/л, 43 нэр төрлийн багаж, лабораторийн урвалж оношлуур, түргэвчилсэн тест, хувийн хамгаалах хувцас-19369ш нийт 365,439,900 төгрөгийн өртөг бүхий 3 сарын нөөцийг улсын төсвөөр тендер болон ерөнхий гэрээгээр татан авч, бэлэн байдлыг хангасан. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай. | |
| 5 | 1.1.4. "Ковид-19" вирусийн халдварын үеийн орон нутгийн эрсдэлийн үнэлгээг салбар дундын оролцоотой хийж, үр дүнг шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах, эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. "Ковид-19" вирусийн халдварын салбар дундын эрсдэлийн үнэлгээг хийж, үр дүнг тооцох | 2021 - 2024 | | "Бага" | Улс, аймгийн хэмжээнд Ковид-19-ын халдварын тархалт зогсож, ногоон түвшинд шилжсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн байгууллагын шийдвэрээр салбар дундын эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагагүй гэж шийдвэрлсэний дагуу эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй болно. | |
| 6 | | 2. Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабыг байгуулж гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудыг нэгдсэн удирдлагын тогтолцоонд шилжүүлэх | 2021 - 2024 | | 95 | Аймгийн Засаг даргын 2023 оны А/253 дугаар захирамжаар тус аймгийн хэмжээнд бүх төрлийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, хариу арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангах, салбар дундын харилцан ажиллагааг шуурхай зохицуулах зорилгоор "Төв штаб"-ын бүтцийг шуурхай бүлгийн бүтэц бүрэлдэхүүнд шилжүүлж, албадын бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. Мөн 2023-2024 оны өвөлжилт хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны А/27 дугаар захирамжаар аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн, аймгийн Онцгой комиссын даргын 2023 оны 05 дугаар тушаалаар Шуурхай штаб байгуулан ажилласан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бөгөөд 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр татан буулгасан болно. | |
| 2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ | | | | | | | |
| 7 | 2.1.1. Нотолгоонд суурилсан оношлогоо эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, иргэдэд орон нутагтаа нарийн мэргэжлийн оношлогоо, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ. | 1. Анхан шатны 24 нэгжийн эрүүл мэндийн төвийн лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх | 2021 - 2024 | | 100 | Эрүүл мэндийн анхан шатны 20 байгууллагад 2022-2023 онуудад 3 нэр төрлийн нийт 32 лабораторын тоног төхөөрөмж шинээр нийлүүлэгдэж, оношилгоо үйлчилгээг ард иргэдэд цаг алдалгүй үзүүлж байна. 2024 оны эхний 11 сарын байдлаар цусны дэлгэрэнгүй 5845, биохими-2116, шээс-6565, микроскоп-2054 шинжилгээ тус тус хийгдэж, нарийн оношийг тодруулж, нотолгоонд тулгуурласан эмчилгээ үйлчилгээг үзүүлж ажилласан байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд 100 хувь лабораторын тоног төхөөрөмжөөр хангагдсан. | |
| 8 | | 2. Уламжлалт-сэргээн засах төвийг шинээр зохион байгуулан, шаардлагатай багаж хэрэгслээр хангаж, тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 3000 | Уламжлалт, сэргээн засах эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээний чанар хүртээмж, орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх зорилгоор Нэгдсэн эмнэлэг нь 139,600,000 төгрөгний үнэ бүхий уламжлалт, эмийн бус эмчилгээний болон хөдөлгөөн засал эмчилгээний багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан. Шинээр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг эмчилгээ үйлчилгээнд ашиглаж, эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн давхардсан тоогоор 30282 хүнд тусламж үйлчилгээ үзүүлж, тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдол бүртгэгдээгүй байна. Уламжлалт анагаах ухааны эмчилгээг түгээн дэлгэрүүлэх зорилгоор видео шторк бэлтгэж олон нийтэд хүргэж, 625 иргэнд мэдээлэл, сургалт зохион байгуулсан. Японы Өвсний үндэс төсөлд Нэгдсэн эмнэлгийн Уламжлалт эмчилгээ, сэргээн засах төвийг шинээр байгуулах 130.0 сая төгрөгний төслийг бичиж, аймгийн Засаг даргын албан бичгээр хүргүүлсэн. | |
| 9 | | 3. Зүрх судасны эмгэгийн тасаг зохион байгуулан, | 2021 - 2024 | | 16 | Зүрхний шигдээс өвчнөөр тус нэгжид нийт 24 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлж, биеийн байдал сайжирч гарсан 23, нас баралт 1 бүртгэгдсэн. Зүрхний шигдээсийн оношилгоо эмчилгээг сайжруулах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | зүрхний шигдээсийн үеийн эмчилгээг хийж хэвшүүлэх | | | | чиглэлээр УГТЭ-ийн зүрхний эмч нартай хамтран сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 22 эмч нарт чадавхжуулах сургалт, МнКардио программын шинэчлэлийг танилцуулах хэрэглээний сургалтуудыг тус тус зохион байгуулж чадавхижуулсан. Өвчлөл бууралтын түвшин 2024 оноор эцэслэж гараагүй байна. | |
| 10 | | 4. Уушигны дурангийн оношилгооны чиглэлээр хүний нөөцийг бэлтгэн, тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 3.6 | Уушгины өвчин судлалын кабинетаар 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 5074 иргэн эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан. Үүний 350 үйлчлүүлэгчид спирометрийн шинжилгээг хийж, өөрчлөлттэй илэрсэн 25 үйлчлүүлэгчийг хяналтад авч, 2 үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээсэн. 2024 оны эхний 11 сарын байдлаар сүрьеэгийн 30 тохиолдол буюу 10 000 хүн амд 3.4 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1-ээр нэмэгдсэн байна.Эмчийг бэлтгэхээр захиалга өгсөн квот батлагдаагүй байна. | |
| 11 | | 5. Вирус судлалын лабораторийг шинээр нээх | 2022 - 2024 | | 20 | Нэгдсэн эмнэлгийн вирус судлалын лабораторид элэгний B, C, D вирус тоолох шинжилгээ, хүний папилома вирусийн 29 хэв шинжийг илрүүлэх шинжилгээ, бэлгийн замын 14 үүсгэгч илрүүлэх шинжилгээ, амьсгалын замын 11 төрлийн вирус илрүүлэх шинжилгээг хийж байна. Элэгний B, C, D вирус тоолох шинжилгээг 1226, амьсгалын замын үүсгэгч илрүүлэх шинжилгээг 772 3, бэлгийн замын өвчин үүсгэгч шинжилгээ-239, хүний папилома вирус илрүүлэх шинжилгээ 208 хүнд тус тус хийсэн. | |
| 12 | | 6. Элэгний B вирустай эхчүүдээс төрсөн нярай бүрт Гепабиг эмчилгээг нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 200 | Нэгдсэн эмнэлэгт 2024 оны эхний 11 сарын байдлаар элэгний B вирусийн халдвартай 48 эх төрсөн. 2024 онд гепабиг тариа улсын хэмжээнд тасалдал үүсч, 05 дугаар сараас нийлүүлэгдэж эхлэснээс хойш 31 хүүхдэд гепабиг эмчилгээ хийгдсэн байна. B вирустай эхээс төрсөн нярай бүрийг Гепабиг эмчилгээнд бүрэн хамруулах чиглэлээр тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулан ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | 2.1.2. Эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, | 1. Цэргийн насны 18-25 насны эрчүүдийг үзлэг шинжилгээнд хамруулж, өвчлөлийг илрүүлж, эрүүлжүүлэх | 2021 - 2024 | | 250 | Аймгийн хэмжээнд 2024 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагаар нийт 1290 цэргийн насны залуучууд хамрагдсанаас 827 буюу 64,0% нь өвчний учир тэнцээгүй байна. Үзлэгт хамрагдсан эрчүүдээс дараах өвчлөлүүд бүртгэгдсэн. Дотрын өвчлөл – 263, шүдний өвчлөл – 994, мэдрэл,сэтгэц - 177, нүдний өвчлөл – 152, чих хамар хоолойн өвчлөл – 274, мэс засал, гэмтэл – 297, арьс харшлын өөрчлөлт- 247 хүнд тус тус илэрсэн. Нийт өвчлөл давхардсан тоогоор 2404. Өвчлөлийг анхан шатны эрүүл мэндийн төвүүд хяналтадаа авч, эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байна. Хяналтад-873 буюу 67.7 хувьтай, эрүүлжүүлсэн залуучуудын тоо-784 буюу 60.8 хувьтай байна. | |
| 14 | тэдний эрүүл мэнддээ тавих анхаарлыг нэмэгдүүлж, ажиллах боловсон хүчнийг бэлтгэн, төрөлжсөн | 2. Эрэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх кабинетыг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх | 2022 - 2024 | | 500 | Аймгийн нэгдсэн эмнэлэгт урологи-андрологийн кабинетыг байгуулж, үйл ажиллагааг тогтмол явуулж хэвшсэн бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар эрчүүдийн кабинетаар 1567 эрчүүд үйлчлүүлснээс 1100 буюу 70.1 хувьд нь түрүү булчирхайн архаг үрэвсэл илэрч, өвчлөлийг хяналтанд авч, эмчлэн эрүүлжүүлж байна. Үзлэг оношлогоонд хамрагдсан эрчүүдийг эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зөвлөгөөнд бүрэн хамруулсан. | |
| 15 | үйлчилгээ үзүүлэх орчинг бүрдүүлж, “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 3. "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | 2022 - 2024 | | 100 | “Эрүүл чийрэг эр хүн” аяныг Аймгийн Засаг даргын тамгын газрын 6.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн Урологи-Андрологи, Хэт авиан оношилгооний эмч мэргэжилтнүүд болон сумын эрүүл мэндийн төвүүд хамтран 2024 оны 09 дүгээр сарын 23-аас 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд 20 суманд амжилттай зохион байгууллаа. Тус аяны хүрээнд Баянхонгор аймгийн 20 сумын 18-аас дээш насны эрчүүдийг хэт авиан оношилгоо, эрэгтэйчүүдийн эмчийн үзлэг, түргэвчилсэн шинжилгээ, танита аппаратын оношилгоонд хамруулж, эрчүүдэд “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Эрт илрүүлгийн ач холбогдол”- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ын талаар сургалт зохион байгуулж, мэдлэг олгосон. Үзлэгт нийт 1316 эрчүүд хамрагдаж, үүнээс 80 хувь буюу 1047 эрчүүдээс эмгэг, өвчлөл илрүүлсэн бөгөөд 48 хувийг түрүү булчирхайн архаг үрэвсэл /N40/, 18 хувийг түрүү булчирхайн томрол /N41.1/ тус тус эзэлж, илэрсэн эмгэгийг хяналтанд авч, эмчлэн эрүүлжүүлж байна. | |
| 16 | 2.1.3. “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. | 1. Бэлгийн замаар дамжих халдварыг бууруулах | 2021 - 2024 | | 60 | Аймгийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 1158 халдварт өвчин бүртгэгдсэнээс 500 буюу 43.1 хувийг БЗДХ-т өвчин эзэлж байна. Өвчлөл 10 000 хүн амд 56.7 байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.3-р нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Сайн дурын зөвлөгөө шинжилгээний төвөөр 11 сарын байдлаар 1083 иргэн үйлчлүүлснээс тэмбүү зэрэг 43 халдварыг илрүүлж, эмчилгээнд бүрэн хамруулсан. В вирус эргэлзээтэй 28, С вирус эргэлзээтэй 50 тохиолдлыг мэргэжлийн эмчрүү илгээж, зөвлөгөө өгсөн. Үйлчлүүлэгчдэд тав тухтай орчин бүрдүүлэх үүднээс орон нутгийн төсвөөс хүлээлгийн буйдан гадна хаяг, зөөврийн комьпютер, хурууны хээ уншигч, сервер гэх мэт 13.0 сая төгрөгний тоног төхөөрөмж хүлээлгэн өгч ажиллах таатай орчинг бүрдүүлсэн. БЗДХ-н тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулж салбарын удирдлагууд, Өсвөр үеийн Ирээдүйн босго төв, БЗДХ-ын кабинетийн эмч, мэргэжилтэн, сум, өрхийн ЭМТ –ийн төлөөлөл нийт 28 хүн оролцсон. Хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг ЭМГ-н даргын 2024 оны 283 дугаар албан бичгээр нэгжүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг ханган, хяналт тавин ажилласан. "Харамсахгүйн төлөө хамтдаа” аяны хүрээнд бэлтгэгдсэн 6 төрлийн видео шторк болон зөвлөмжийг аймгийн лед дэлгэцээр өдрийн 2-3 удаагийн давтамжтай 2 сарын хугацаанд тогтмол нэвтрүүлж, Номгон телевиз, эрүүл мэндийн газар болон бусад харьяа эрүүл мэндийн байгууллагуудын фэйсбүүк хуудсанд байршуулан 18 удаа хуваалцан, 35 хандалт авсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | | 2. Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | | 3 | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/38 дугаар тушаалын дагуу 24 нэгжид эрсдэлт бүлгийн судалгаа гаргах заавар сэдвээр нийт 24 ажилтанд цахим сургалт зохион байгуулж, эрсдэлт бүлгийн нийт 6069 хүн амын судалгааг авч нэгтгэн шинэчилсэн. Эхний 11 сарын байдлаар 20 сумаас аймгийн сүрьеэгийн диспансерт ирүүлсэн 1046 сорьцоос эерэг 6 тохиолдол илрүүлэн, эмчилгээнд 100 хувь хамруулсан. Сүрьеэгийн 30 тохиолдлын өрхийн хавьтал болох 62 иргэнийг 14 хоногийн дотор үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан. Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг угтан “Их эмч зөвлөж байна” нэвтрүүлэг бэлтгэн Номгон телевизээр нэвтрүүлж, 2300 хандалт авсан. Глобаль сангийн дэмжлэгтэй МСЭМХ-той хамтран 20 сумын эрүүл мэндийн төвийн сүрьеэгийн тусламж үйлчилгээнд удирдлага зохион байгуулалт, сорьц тээвэрлэлтийн бэлэн байдал, сүрьеэгийн өвчлөл, хавьтлын хяналт, сүрьеэ илрүүлэлт, сүрьеэгээс урьдчилан сэргийлэх талаар хийсэн ажлуудад дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажлын байрны сургалт явуулан үйл ажиллагааны тайланг МСЭМХ-нд сум тус бүрээр гарган хүргүүлсэн. | |
| 18 | | 3. Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд хамруулах | 2022 - 2023 | | | Аймгийн хэмжээнд 36400 иргэн эрт илрүүлэг үзлэгт хамрагдаж, 40.9%-д хүрсэн нь өмнөх оноос 5.1% өссөн. Программын шивэлтэд ороогүй дараах үзлэгүүд байна. Улсын 2 дугаар төв эмнэлгийн явуулын багийн үзлэгт 2432 иргэн буюу 4.3 хувь, 0-17 насны 9897 хүүхэд буюу 29.4 хувийн үзлэг хийгдсэн. Эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлж, үзлэг, оношлогоонд хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд: 1. Эрт илрүүлгийн үзлэгийн ач холбогдлын талаар “Эмч зөвлөж байна” нэвтрүүлэг бэлтгэн Номгон телевиз болон цахим хуудсуудаар нэвтрүүлж байна. Хандалт 9100, лайк 60, эерэг сэтгэгдэл 8 байна. 2. Анхан шатны 24 нэгжийн “Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрчимжүүлэх ажлын тайлан танилцуулах” цахим уулзалт хэлэлцүүлэг 3 удаа зохион байгуулж, арга зүйн заавар зөвлөгөө өгсөн. 3. Анхан шатны 24 нэгжэд 2 удаагийн хяналт үнэлгээгээр урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийн чиглэлээр үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлж, урьд оны зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж ажилласан. 4. Улсын II төв эмнэлгийн явуулын багийн 2 удаагийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийг 12 сумд амжилттай зохион байгуулсан. Үзлэгт 18-аас дээш насны 2432 иргэн буюу 4.3 хувь хамрагдсан. | |
| 19 | | 4. Иргэдийг ковидын дараах нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах | 2022 - 2023 | | | Харъяалах нутаг дэвсгэрт Ковидын халдварын тохиолдол багассан. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн горимоор ажиллаж байна. Ковидын дараах нөхөн сэргээх эмчилгээний төрөл нэмэгдээгүй ч амралт сувиллын газраар 2024 онд 11344 иргэн уламжлалт, нөхөн сэргээж эмчилгээнд хамрагдсан. | |
| 20 | 2.1.4. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. Ревматологийн эмчийг бэлтгэх, бодлогоор дэмжих, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах | 2022 - 2024 | | 200 | Ревматологийн эмчийг төрийн сангийн зардлаар бэлтгэж сургахаар Эрүүл мэндийн хөгжлийн төвд санал хүргүүлсэн. Анхан болон хоёрдугаар шатлалд дотрын төрөлжсөн мэргэжлийн 8 эмч үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн хэмжээнд ревматологийн чиглэлээр нийт 4396 хүн тусламж үйлчилгээ авч, зөвлөгөө, эмчилгээ оношлогоонд хамрагдсан. | |
| 21 | | 2. Нярайн зүрхний гажигийг эрт илрүүлэх, скрининг болон сонсголын гажиг илрүүлэх тусламж үйлчилгээг нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 1500 | Нярайн эрт илрүүлэг үзлэгийг төрөх эмнэлэгт байх хугацаанд нь 3 чиглэлээр хийж хэвшсэн. Үүнд: 1.Сонсгол, 2.Улаан гэрлийн рефлекс, 3.Түнхний дутмаг хөгжил. Уг тасаг төрсөн нярайг үнэлэх багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан. Нярайн скрининг 2022 оноос хийгдэж, нийт 4514 нярайд хийгдсэн байна. 2024 оны эхний 11 сарын байдлаар нийт 1308 нярайд хийгдэж үүнээс 2 талдаа сонсгол бууралттай 20, зүүн талдаа 31, баруун талдаа сонсгол бууралттай 19 нярайг илрүүлж, оношлогоо эмчилгээний зорилгоор Эх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхдийн эрүүл мэндийн төвд 3 нярайг илгээж, хяналтад хамруулсан. | |
| 22 | 2.1.5. Анхан шатлалд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийн чирэгдлийг багасгана. | 1. Иргэдийн хүлээгдэл чирэгдэлийг багасгаж, эрүүл мэндийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх | 2021 - 2024 | | 0 | Иргэдийн хүлээгдэл, чирэгдлийг багасгах зорилгоор Нэгдсэн эмнэлгийн амбулаторит үзүүлэх цагийг emongolia, эрүүл мэндийн цаг захиалгын утас 18000119, амбулаторийн суурин 70444039, цахим бүртгэл зэргээс авснаар цаг захилага шуурхай болж чирэгдэл багассан. Emongolia-с жирэмсний хөтөч, дархлаажуулалтын мэдээлэл, эмийн жор, дүрс оношилгооны зураг, дүгнэлт, шинжилгээний хариу зэргийг авах боломж бүрдсэн. Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн хэсэгт хөтөч сувилагчийг орон тоогоор тогтмол ажиллуулж, иргэд үйлчлүүлэгчдийг шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан. Иргэдийн шинжилгээний хариуг хариуцсан эмч рүү нь илгээж, шаардлагатай тохиолдолд Emongolia болон Хурдан төвөөс хэвлүүлэн авах боломжоор хангасан. Жирэмсэн эхчүүдийн шинжилгээний хариуг шинжилгээ өгсөн хэсэгт нь хэвлэн өгдөг болсноор иргэдийн хүлээгдэл, чирэгдэл буурч байна. Дэмжих төвийн хүлээгдэл чирэгдэл бага буюу 1-2 хоногт (70%) бүх тусламж үйлчилгээг авч байна. 2024 онд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой 16 өргөдөл гомдлыг ирсэнийг тухай бүр шийдвэрлэж ажилласан. Энэ нь урьд оноос 8 тохиолдлоор буурсан байна. | |
| 23 | | 2. Багийн эмч нарыг унаажуулах | 2022 | | | Сумдын багийн эмч нарт 2022, 2023 онуудад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 48 ширхэг бүхий 134.8 сая төгрөгний өртөгтэй мотоцикл хүлээлгэн өгсөн. Хөдөөгийн багийн эмч нарын 83 хувийг унаажуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг алслагдсан багийн иргэдэд хурдан шуурхай хүргэж байна | |
| 24 | 2.1.6. Гүйцэтгэлд суурилсан | 1. Өвчтөний түүхийг цахимжуулж, E- | 2021 - 2024 | | 100 | E-health цахим програмын 13 модуль 600 цэсийг аймгийн Нэгдсэн эмнэлэг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж, нийт 331 албан хаагчид өдөр тутмын үйл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | санхүүжилтийн оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Health программыг бүрэн нэвтрүүлэх | | | | ажиллагаандаа 100 хувь ашиглаж байна. Энэ онд e-health программд иммунологи шинжилгээнүүд: үүнд pivka ii, прокалцитонин, pro bnp, rt-pcr цусанд вирусийн халдвар илрүүлэх, амьсгалын пане 20 үзүүлэлтүүд, эмгэг судлалын маягтууд, эмгэг судлалын шинжилгээний протокол, эс-1, эмгэг судлалын микро, эмгэг анатоми сорьц хүлээн авсан тэмдэглэл, амьд сорьцын шинжилгээний хуудас, умайн хүзүүний эсийн шинжилгээний хуудас, бамбай булчирхайн эсийн шинжилгээний хуудсуудыг цахимжуулан ажилласан. Дүрс оношилгоонд цээжний рентген зургийг хиймэл оюун ухааны программд боловсруулж, эмчилгээ үйлчилгээндээ ашиглаж байна. | |
| 25 | | 2. Олон улсын эмнэлзүйн удирдамж Upto date программыг нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 90 | Олон улсын эмнэлзүйн платформ Uptodate программын хэрэглээг ажилтны гэрээнд тусгаж, биелэлтийг хангуулж байна. Ажлын байран дээр очиж платформыг нээх, ашиглалтыг сайжруулах зөвлөгөө өгч ажилласны үр дүнд Нэгдсэн эмнэлгийн 82 их эмчээс 66 эмч буюу 80 хувь, Сум, өрхийн 70 их эмчээс 52 эмч буюу 74 хувь, Хувийн хэвшлийн 44 эмчээс 12 эмч буюу 27 хувь нь тус тус хэрэглэж хэвшсэн. Платформ программ суулгаж ашиглах заавар зөвлөгөөг өгснөөр аймгийн 210 эмчээс 70 хувь нь хэрэглэж байна. Платформын ач холбогдол нь эмч нарын англи хэлний мэдлэг дээшилж, оношилгоо, эмчилгээний чанар сайжирсан. Гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдана. | |
| 26 | 2.1.7. Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг сайжруулж, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлж, | 1. Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр сургалтад хамруулах | 2021 - 2024 | | 1000 | Эрүүл мэндийн салбарын ажилтны ур чадварыг сайжруулах, ёс зүйн харилцаа хандлагыг дээшлүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр 2024 онд ажлын байрны, цахим, танхимын болон мэргэжил дээшлүүлэх нийт 114 удаагийн сургалтад, 3775 албан хаагчийг давхардсан тоогоор хамруулсан байна. Үүнд: Төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад 9 их эмч, төрөлжсөн мэргэшлийн сургалтад их эмч 3, сувилагч 10, дээшлүүлэх сургалтад сувилагч 3 нийт 25 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийгмийн хамгааллыг дэмжинэ. | | | | | эмч мэргэжилтэн хамрагдсан. Гадаад сургалтад 18, ажлын байрны 28 удаагийн сургалтад 409, танхимын 43 удаагийн сургалтад 2059, цахим 25 удаагийн сургалтад 861 эрүүл мэндийн ажилтанг тус тус хамруулж чадавхижуулллаа. | |
| 27 | | 2. Иргэд үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, ёс зүйгээрээ бусдыгаа манлайлсан ажилтнуудыг урамшуулах, алдаршуулах | 2021 - 2024 | | 93 | Эрүүл мэндийн газрын даргын А/21 дугаар тушаалаар хэрэглэгчийн үнэлгээ авах ажлын хэсгийг байгуулж, Нэгдсэн эмнэлэг, 20 сум, 4 өрхийн эрүүл мэндийн төвийн амбулаториор үйлчлүүлсэн 630 иргэнээс хэрэглэгчийн үнэлгээг цаасан хэлбэрээр авч, нэгтгэн үр дүнг тооцон ажилласан. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулах зорилгоор зохион байгуулсан “Бид-Ёс зүйгээр манлайлна” аянд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм, хэмжээг эрхэмлэн, идэвх зүтгэл гарган ажилласан байгууллага, эмнэлгийн мэргэжилтнүүдийг Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны А/50 дугаар тушаалын шалгуураар шилдгүүдээр шалгаруулллаа. Ёс зүйтэй байгууллагаар: Батлагдсан шалгуурыг 96% хангасан “Жаргалант сумын эрүүл мэндийн төв”-ийн хамт олон шалгарч, Хэрэглэгчийн үнэлгээгээр Ёс зүйтэй эмчээр: Наранмандал өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, Ёс зүйтэй тусгай мэргэжилтнээр: Бөмбөгөр сумын эрүүл мэндийн төвийн бага эмч, Ёс зүйтэй сувилагчаар: Оточмандал өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагчид тус тус шалгарч шагнаж урамшууллаа.Эрүүл мэндийн салбарын тусламж үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамжийн эерэг хувь 2024 онд амбулаториор үйлчлүүлэгчид 96%, хэвтэн эмчлүүлэгчийн сэтгэл ханамжийн эерэг хувь 93.5% байна. | |
| 28 | | 3. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг | 2021 - 2024 | | 92 | Салбарын хэмжээнд 2024 оны байдлаар цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардалд нийт 20,0 тэрбум төгрөгийг 961 албан хаагчдад зарцуулахаар батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 871 албан хаагчид | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хангах хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллах | | | | 20,0 тэрбум төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулалд 29.3 сая төгрөг тус тус зарцуулсан. Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дахь заалтаар 185 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 1.2 тэрбум төгрөг, Төрийн албаны тухай хуулийн 60.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 29.2 дахь заалтаар 17 албан хаагчид 580.3 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна. Хүний нөөцийн стратегийн хүрээнд салбарын хэмжээнд 2013-2016 онд хэрэгжүүлсэн “Шинэ зууны эмч” аймгийн дэд хөтөлбөр, мөн 2016-2020 онд хэрэгжүүлсэн “Эрүүл мэндийн ажилтны хөгжил” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд сумдын эмч нар 100 хувь эмчийн орон сууцаар бүрэн хангагдсан. 2024 онд шинэ барилга байгууламж, урсгал засвар үйлчилгээнд зориулж улсын төсөвт нийт 5,4 тэрбум төгрөг суугдсан. Үүнд: Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн өргөтгөлийн барилга 2976.4, Хүрээмарал сумын эрүүл мэндийн төвийн барилга 206.7, Наркалогийн төв эмнэлэг 2314.1 төгрөгийн төсөв батлагдсан. Орон нутгийн 2024 оны төсөвт Нэгдсэн эмнэлгийн эмгэг судлалын байрыг шинээр барих 402.0, Шинэжинст сумын эрүүл мэндийн төвийн засварт 120.0, Бөмбөгөр сумын эрүүл мэндийн төвийн гал тогоонд шаардлагатай тоног төхөөрөмж 20.0, Оточномгон өрхийн эрүүл мэндийн төвийг ашиглалтад оруулах 180.0, Заг сумын эрүүл мэндийн төвийн цэвэр бохир усны систэмд холбох ажлыг хийж гүйцэтгэхэд 70.0, Галуут сумын эрүүл мэндийн халдвартын барилгын гадна талын дулаан, цэвэр бохир усны шугам, цахилгааны ажлыг хийж гүйцэтгэхэд 20.0 нийт 812.0 төгрөгийн төсөв тус тус батлагдаж эмнэлгийн барилга байгууламжийн ашиглалт сайжруулахаар төлөвлөгдсөн. Эрдэнэцогт, Хүрээмарал сумдын эрүүл мэндийн төвийн барилга 2024 оны 3 дугаар сард ашиглалтад орж үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.Албан хаагчдын ажиллах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувьтай байна. | |
| 29 | 2.1.8. Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэнэ. | 1. Амбулаторийн барилгыг шинээр ашиглалтад оруулах | 2021 - 2024 | | 100 | Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтанд нийт 2.976,5 сая төгрөг батлагдаж барилгын ажлын гүйцэтгэл 100 хувьтай, Улсын комисст хүлээлгэн өгсөн. Амбулаторын барилга ашиглалтад орохтой холбоотой тохижилт, төлөвлөлтийн ажил үе шаттай хийгдэж байна. | |
| 30 | | 2. Стандарт шаардлага хангасан хог хаягдлын байгууламжтай болох | 2023 - 2024 | | 100<br>100 | Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай” А/505 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах чиглэлээр: Нэгдсэн эмнэлэг нь 2023 онд эмнэлгийн аюултай хог хаягдлыг устгах байгууламжийг шинээр ашиглалтанд оруулж, эмнэлгээс гарсан халдвартай болон хурц үзүүртэй хог хаягдлыг ариутгах үйл ажиллагаа явуулж байна. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сангийн “Эх, хүүхдийн эрүүл мэнд хөтөлбөр”-ийн хүрээнд ЭМСайдын 2023 оны А/357 дугаар тушаалаар Нэгдсэн эмнэлэгт Promed P-150 маркын 324,727,700 төгрөгний үнэтэй бутлагчтай автоклав нийлүүлэгдснээр эмнэлгээс гарсан аюултай хог хаягдлыг бүрэн халдваргүйжүүлэн, бутлаж аюулгүй болгож байна. Эмнэлгийн аюултай хог хаядлыг устгах байгууламж нь хувийн хэвшлийн 8 эмнэлэгтэй гэрээ байгуулан, гэрээний дагуу халдвартай болон хурц үзүүртэй, иртэй хог хаягдлыг бүрэн халдваргүйжүүлж устгасан. 2024 онд эмнэлгийн үйл ажиллагаанаас гарсан халдвартай - 19237 кг хог хаягдал, хурц үзүүртэй, иртэй - 1695 кг хог хаягдлыг халдваргүйжүүлэн буталж, халдваргүйжүүлж буталсан хог хаягдлыг ЦЭВЭР ХОТ ОНӨЭТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу ачуулж устгуулж байна. Тус байгууламжийн тоног төхөрөмжийн хангалт 95 хувьтай байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 31 | | 3. Эмгэг судлалын барилгыг шинээр барих | 2023 | | | Нэгдсэн эмнэлгийн эмгэг судлалын албаны барилгын гүйцэтгэл 100 хувьтай. Улсын комисст хүлээлгэн өгсөн. Эмгэг судлалын салбар нь эмнэлгийн хамгийн хүнд нөхцөлд үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд шинэ байртай болсноор задлан шинжилгээ хийх, оношийн зөрүү арилах, үнэн бодитой дүгнэлт гаргах, эмч мэргэжилтнүүдийн эмнэл зүйн мэдлэг ур чадварыг сайжруулахад чухал ач холбогдолтой, стандартын шаардлага хангасан ээлтэй орчин нөхцөл бүрдэж байна. | |
| 32 | | 4. Эрчимт эмчилгээ гемодиализын өргөтгөлийн барилга шинээр барих | 2024 | | 100 | Эрүүл мэндийн байгууллагын нэн шаардлагатай барилга байгууламжийг эрэмбэлж, тус барилгыг нэн шаардлагатай биш гэж үзсэн. Үүний үндсэн дээр 2024 оны улсын болон орон нутгийн төсөвд тусгагдаагүй бөгөөд ТЭЗҮ хийгдээгүй болно. | |
| 33 | 2.1.9. Эм, эмнэлэгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, сумдын эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааг сайжруулж, үнийн нэгдсэн бодлогыг бий болгоно. | 1. Антибиотикийг жороор олгосон байдалд хяналт үнэлгээг хийж, хариуцлагатай тогтолцоог бий болгох | 2021 - 2024 | | 6000 | Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн 24 эмийн сангаас сар бүр жорын судалгаа авч, дүгнэлт гаргахад нийт 18 эрүүл мэндийн байгууллагаас 6520 ширхэг жор хүлээн авсан ба үүнээс эмчийн тамгагүй жор 2 хувь, оношын код бичээгүй 3 хувь, антибиотик эмийн жор 32 хувийг эзэлж байна. Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/118 дугаар тушаалаар байгуулагдсан Хяналт-шинжилгээ, үнэлгээний баг сумдын эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Тус тушаалын 4 дүгээр удирдамжийн дагуу аймгийн төвийн эмийн сангуудад хяналт үнэлгээг хийж, дутагдалтай асуудлаар заавар зөвлөмж өгч хамтран ажилласан. | |
| 34 | | 2. Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 90<br>20 | Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор гаргасны дагуу нийслэл, аймаг, сумын эмийн сангууд нэгдсэн нэг үнээр хөнгөлөлттэй эмийг үйлчлүүлэгчид хүргэж | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 87.0 хувьтай, амин чухал эмийн хангамж 92.0 хувьтай байна. Сумдын 20 эмийн сангийн эмийн үнийн зөрүүнд судалгаа хийж, дүгнэлт гаргахад тухайн эмийг үйлдвэрлэсэн улс болгоны эмийн үнэ харилцан адилгүй байдаг тул алслагдсан суманд 20-30 хувийн нэмэгдэлтэй, ойрын суманд 10-20 хувийн нэмэгдэлтэйгээр эм зүйн тусламж үйлчилгээг иргэдэд хүргэж байна. Эмийн үнийн зөрүүн бууралт 90 хувьтай. Сумдын эмийн сангуудтай байгуулсан 2024 оны гэрээний хэрэгжилт 85 хувьтай байна. | |
| 35 | 2.2.1. Спорт цогцолбор бүхий усан бассейныг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна. | 1. Спорт цогцолбор, усан бассейны барилгын ажлыг ашиглалтад хүлээн авах | 2021 - 2022 | | | Усан бассейн бүхийн спорт цогцолборын барилгыг улсын төсвийн 11.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэж 2022 оны 12 сард ашиглалтад оруулсан. Олон улсын уралдааны стандартын таван замтай усан бассейн, спортын дөрвөн заал, оффисын 16 өрөө тасалгаатай, спортын олон төрлөөр хичээллэх, бэлтгэл хийх боломж бүхий томоохон бүтээн байгуулалт болж нийтийн биеийн тамир хөгжих, хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай орчин бүрдсэн. | |
| 36 | | 2. Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, үйл ажиллагааг тогтмолжуулах | 2022 - 2024 | | 80 500 | Спортын хэрэглэл материалыг нийлүүлэх худалдан авалтын сонгон шалгаруулалтанд “Тэнгэрийн-Уул” ХХК шалгарч, нийт 54 нэр төрлийн 569,5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалт хийгдсэн.Аймгийн 20 сумдын биеийн тамирын аргазүйчдэд хүлээлгэн өгсөн. | |
| 37 | 2.2.2. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх | 2022 - 2024 | | 100 | "Эрүүл иргэн – Хонгорын баялаг 2024” ажлын байрны дасгал, хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд зохион байгуулж нийт 34 албан байгууллагын 14,670 албан хаагч дасгал хөдөлгөөнийг хийж хэвшээд байна. Үүнээс эмэгтэй 13,855 албан хаагч байна. Хүн амын идэвхтэй хөдөлгөөн, зөв хооллолт, амьдралын хэв маягийг дэмжих, идэвхтэй амьдралын аж төрөх ёсны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэглээг дэмжсэн сургалтад 29 албан байгууллагын 136 албан хаагч хамрагдсан. | |
| 38 | | 2. Спорт заалуудын ашиглалтыг сайжруулах | 2021 - 2024 | | 30000 | Багийн төвийн спорт заалнуудын ашиглалтыг сайжруулж, нийтийн биеийн тамир, спортын чиглэлээр 43 байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулж, давхардсан тоогоор 53420 иргэд хамрагдсанаас 30702 эмэгтэй оролцсон. | |
| 39 | | 3. Заал, талбайн засвар үйлчилгээ хийж, шинээр ашиглалтад оруулах | 2021 - 2024 | | 1<br>0<br>0 | Эрдэнэмандал 2 дугаар багийн спорт заалны их засварын ажлыг 19 сая төгрөгийн, “Бүргэд” боксын клубийг 19,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй их засварын ажил тус тус хийгдсэн. Шинэжинст суманд 1 тэрбум төгрөгийн өртөгтэй 1 спорт заал шинээр ашиглалтад орж, сумын иргэдийг спортын үйлчилгээгээр хангаж ажиллаж байна. Тайлант онд нийт 2 зааланд засвар тохижилт хийгдэж, 1 заал шинээр ашиглалтад орж, Оготнотой булгийн бүс орчмын спорт талбайд 1,374 тэр бум төгрөгийн 30 гаруй тоглоомыг суурилуулж тохижилт хийгдсэн. | |
| 40 | 2.3.1. “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 2022 - 2024 | | 100 | Сурлагын хоцрогдол нөхөх, арилгахад 13 сургууль тус бүрд нийт 77 дэмжигч, 5 сургууль 38 явуулын, 8 дадлагын багшийг ажиллуулж, зуны сургалтад 219 багш хамрагдсан. Дотуур байрын багшийн үйл ажиллагааг сурагчдын сурлагын хоцрогдлыг арилгахад чиглүүлэн арга зүйн удирдалгаар хангаж ажилласны үр дүнд сургууль завсардах магадлалтай 84 сурагч байсныг сургуульдаа эргэн суралцах боломжоор бүрэн хангаж сургууль завсардалт гараагүй. ЕБС-д 101, СӨБ-д 46, насан туршийн боловсролд 52, “ХБХХөгжүүлэх төв”-д 25 нийт 224 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа нь аймгийн нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 46.5 хувийг эзэлж байна. Үүнээс ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулан хичээллэж байгаа 48 хүүхэд байна. Хоцрогдол арилгаж буй сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор багш солилцоо, сургалтын 10 гаруй үйл ажиллагааг зохион байгуулж, багшийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мэргэжлийн хөгжлийн бүлгээр ажиллах арга зүйгээр хангаж ажилласан. Нийт 15 сургуульд сэтгэл зүйч ажиллаж, хоцрогдол арилгахад эцэг эх, сургуулийн зөвлөлийн үүрэг оролцоог нэмэгдүүлж цахимаар суралцах боломжийг нэмэгдүүлсэн. | |
| 41 | | 2. "Чадварлаг багш" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 100 300 | Чадварлаг багш арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулав. Үүнд: Багшийн тасралтгүй хөгжлийг хангах зорилгоор “Мэргэжлийн бүлгийн зохион байгуулалтаар хамтран ажиллах арга зүй” сургалтыг 1200 гаруй багш ажилтанд зохион байгуулсан. Үүний үр дүнд 130 гаруй мэргэжлийн хөгжлийн бүлэг байгуулагдаж сургалтын үйл ажиллагаанд тулгамдаж байгаа олон асуудлыг шийдвэрлэсэн байна. Энэ бүлгүүдийн сайн туршлага арга зүйг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг 2 удаа зохион байгуулсан. Цахим контент боловсруулах арга зүйн сургалтыг 800 гаруй багшид зохион байгуулснаар 311 цагийн хичээл бүтээж үндэсний цахим санд байршууллаа. Сургалтын байгууллагууд хамтран хөгжих зорилгоор 6 сургууль цэцэрлэгт “Зочин багш арга хэмжээг зохион байгуулж сургалтын үйл ажиллагааны үр дүн туршлагыг түгээн дэлгэрүүлсэн байна. Сургалтын байгууллага, багш, удирдах ажилтны үр дүнд хүрсэн сайн туршлага арга зүйг илрүүлэх, түгээн дэлгэрүүлэх “Сургуулийн менежмент ба шилдэг арга зүй” бүсчилсэн үйл ажиллагааг 2 бүсэд зохион байгуулсан. Энэ үйл ажиллагаанд 60 багш, 75 захирал эрхлэгч хамрагдлаа. | |
| 42 | 2.3.2. Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлнэ. | 1. Тусгай хэрэгцээт боловсролын багш нарыг чадваржуулах сургалтад хамруулах | 2021 - 2024 | | 40 | Ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийг хэрхэн үнэлэх арга зүйн сургалтыг нийт сургалтын менежерүүдэд зохион байгуулан арга зүй олгож хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарт сургалтын хөтөлбөрийг хэрхэн боловсруулах арга зүйн сургалтыг цахимаар 1 удаа танхимаар 3 удаа нийт 4 удаа зохион байгуулан арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Тэгш хамран сургах боловсролын талаарх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үндсэн ойлголтыг нэмэгдүүлэх, дэмжлэгийн багийн үйл ажиллагаанд анхаарах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрхэн боловсруулж үнэлэх зэрэг агуулгаар БЕГ, БШУЯ-тай хамтран Баянхонгор сумын цэцэрлэгийн арга зүйч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, ЕБС-н хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, Насан туршийн төвийн багш нарыг хамруулсан сургалтыг зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх, ХБХ-н хөгжлийн төвийн туршлага танилцуулснаар ажиллах санал санаачилага бий болгох зорилгоор 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр сургууль, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарыг чадваржуулах сургалтыг цахим хэлбэрээр нийт 92 багшийг хамруулан сургалт зохион байгууллаа.Энэ хичээлийн жилд цэцэрлэг 47, ерөнхий боловсролын сургуульд 15, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын төвийн өдрийн үйлчилгээнд 60 ялгаатай хэрэгцээтэй хүүхэд хамрагдан боловсролын үйлчилгээг авч байна. Аймгийн Цэцэрлэг сургууль бүр хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд зориулсан зориулалтын налуу замтай /MNS 6055:2009 стандартад нийцсэн/, тэргэнцэртэй иргэд явахад хүндрэлгүй байна. Аймгийн төвийн 9 сургууль 16 цэцэрлэг бүр хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөөг 1 суултууртай /1,65x1,8м, суултуурын өмнө 1,5x1,5м талбайтай/ тулах, барих тоноглол хийж тохижуулсан байна. | |
| 43 | | 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, орчинг сайжруулах | 2021 - 2024 | | 2 | Хичээлийн жилд цэцэрлэг 48, ерөнхий боловсролын сургуульд 147, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын төвийн өдрийн үйлчилгээнд 60 ялгаатай хэрэгцээтэй хүүхэд хамрагдан боловсролын үйлчилгээг авч байна. Аймгийн Цэцэрлэг сургууль бүр хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд зориулсан зориулалтын налуу замтай /MNS 6055:2009 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 44 | | | | | | стандартад нийцсэн/, тэргэнцэртэй иргэд явахад хүндрэлгүй байна. Аймгийн төвийн 9 сургууль 16 цэцэрлэг бүр хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөөг 1 суултуууртай /1,65х1,8м, суултуурын өмнө 1,5х1,5м талбайтай/ тулах, барих тоноглол хийж тохижуулсан байна. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэд суралцаж байгаа анги бүлгийг дэмжих, багш нарын мэдлэг арга зүйг дээшлүүлэх, хүүхэд бүрийг боловсролд тэгш хамран сургах боломжийг бүрдүүлэхэд анхаарч сургууль цэцэрлэгийн дэмжлэгийн багийн гишүүдийг чадваржуулах сургалтад хамруулан ажилллалаа.Чанартай сургалтын орчинд боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх чиглэлийн хүрээнд сургуулийг олон нийтийн оролцоотойгоор тэгш хамруулах зарчимд суурилан хөгжүүлэх агуулга, арга зүйн дэмжлэгийг үзүүлэх зорилго бүхий НҮБ-ийн Хүүхдийн сантай хамтран Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг хэрэгжүүлдэг “Тэгш хамруулсан-Олон нийтийн оролцоот сургууль” төслийн үйл ажиллагааг 6 сургууль дээр хэрэгжүүлж Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг тохижуулсан байна. Эрдэм, Заг, Галуут, Номгон, Өлзийт, Бөмбөгөр зэрэг сургууль дээр байгуулан тусгай хэрэгцээт хүүхдүүдийн хөгжлийг дэмжих, сэргээн засах, сурч хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлж 6 төвийн үйл ажиллагаа тасралтгүй явагдаж байна. Тус хөгжлийн төвүүдэд нийт 356 хүүхэд хамрагдан хөгжиж байна.Японы Хүүхдийг ивээх сангийн төслөөр "Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь "төсөл хэрэгжиж 16 дугаар цэцэрлэгийг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан. | |
| 44 | 2.3.3. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг | 1. "Бага насны хүүхдийн цогц хөгжил"-ийг дэмжих стратеги | 2021 - 2024 | | 80 | Бөмбөгөр, Эрдэнэцогт, Богд, Өлзийт, Баянговь, Баянбулаг сумд "Бага насны хүүхдийн цогц хөгжил" баг байгуулан ажиллаж байна. "Амьдралын зөв хэв маяг" мэргэжлийн хөгжлийн бүлэг байгуулан 36 цэцэрлэгийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлж, сургалтын орчныг хүүхэд бүрт ээлтэй болгож, багш нарын ур чадварыг нэмэгдүүлнэ. | төлөвлөгөөг хэрэгжүүлэх | | | | 72 удирдах ажилтан, 329 багш, 3698 хүүхэд, 1860 эцэг эхэд нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Цэцэрлэгийн багш, ажилтан, эцэг эхчүүд, хүүхдүүдэд Зөв зохистой хооллолт, эрхтэн тогтолцооны хөгжил алдагдах, бичил тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулж нийт 4987 хүнд эрүүл хооллолтын зөв дадлыг төлөвшүүлэхэд нөлөөлж ажилласан. Бага насны хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ нийгэмшихүйн хөгжил 63%, танин мэдэхүйн хөгжил 72%, бие бялдрын хөгжил 70% үнэлэгдэж аймгийн дундаж 69.2% байна. 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр сургалтын орчин бүрдүүлэлт 88.9%, суралцагчийн хөгжил хамгаалал 89%-тай үнэлэгдсэн нь цэцэрлэгийн орчинд дах хүүхэд хамгаалал сайн байна. Олон улсын Эко-сургууль /цэцэрлэгүүдэд/ зориулсан Ахисан шатны 3 дахь сургалтад Баянхонгор сумын 5,10,13,16-р цэцэрлэг, Шинэжинст, Бууцагаан сумдын цэцэрлэгүүд амжилттай хамрагдсан. "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, аймгийн ногоон хөгжилд суурилсан хэтийн зорилт дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, ногоон хөгжил тогтвортой хөгжлийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд мэргэжил арга зүйгээр хангахад чиглэгдсэн ISO14001 стандартыг сургалтын хөтөлбөртөө тусган ажилласан. Энэ ажлын хүрээнд 7000 гаруй хүүхдэд байгаль дэлхийгээ хайрлах, зөв зохистой хооллолтын талаарх төлөвшлийг олгож дадал хэвшил болгоход анхаарч ажиллаж байна. "Бага насны хүүхдийн цогц хөгжил"-ийг дэмжих төлөвлөгөөг хэрэгжилт 91 хувьтай. | |
| 45 | | 2. Бага насны хүүхдийн хоол | 2021 - 2024 | | 2 | Цэцэрлэгт зориулалтын 37, зориулалтын бус 13, их засвар шаардлагатай 8 гал тогоо байна. Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэг, Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн бохир усны шугамыг засварлаж бага | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлдвэрлэлийн орчны сайжруулах | | | | насны хүүхдийн хоол үйлдвэрлэлийн орчныг сайжруулсан. | |
| 46 | | 3. 5 настай хүүхэд бүрийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах | 2021 - 2024 | | 100 | Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласнаар 5 настай хүүхдийн хамрагдалт 2021 онд 83 хувь, 2022 онд 81 хувь, 2023 онд 85 хувь, 2024 онд 100 хувьтай байна. Нийтдээ 7617 хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд бэлтгэн өгсөн. 2022 оны сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ 75 хувь, 2023 оны сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ 69 хувь ба улсын дундажаас 0.7 хувиар бага байна. Үнэлгээг ахиулахын тулд сургалтын хөтөлбөртөө тохируулга хийж, хүүхдийн хөгжлийн үнэлгээг бодитой хийхэд анхаарч багш нар харилцан туршлага солилцож хүүхдийн ахиц амжилтыг үнэлэх арга барилаа дээшлүүлэн, багш бүр даалгаврын аргачлал боловсруулан нийтдээ 213 хэрэглэгдэхүүний сан бүрдүүлж ажилласан байна. | |
| 47 | | 4. Хүүхэд харах төвийн үйлчилгээг тогтворжуулж, ясли байгуулах асуудлыг судлах | 2021 - 2024 | | 10 | Хүүхэд харах үйлчилгээний хувьсах зардал багасаж, хугацаандаа мөнгө нь орж ирдэггүй, багшлах боловсон хүчин дутмаг байхгүй, стандартын шаардлага хангахгүй орчинд үйлчилгээ явуулах зэргээс шалтгаалан татан буугдаж байна. 2023-2024 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд 3 төв, 6 багш, 30 хүүхэдтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Энэ онд Бууцагаан сумын 90 ортой хуучин цэцэрлэгийг шинээр засварлаж 15 хүүхэд авах яслийн ангийг нээж тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулсан. | |
| 48 | 2.3.4. Сургууль, цэцэрлэгийн барилгын стандарт, норм нормативийг мөрдүүлж, эрүүл, | 1. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчин нөхцлийг сайжруулах | 2021 - 2024 | | 1 | Баяновоо сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Баянхонгор сумын шинэ суурьшлын 640 хүүхдийн суудалтай сургууль, “Номгон” ахлах сургуулийн 440 хүүхдийн өргөтгөл, Баянхонгор сумын 960 хүүхдийн суудалтай сургууль, Гурванбулаг сумын 160 хүүхдийн суудалтай сургуулийн барилга тус тус ашиглалтад орсон. 2023 онд Баацагаан, Богд, Баян-Өндөр, Баянхонгор сумын 5, 11, 12-р цэцэрлэгийн их засвар, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аюулгүй орчин бүрдүүлнэ. | | | | | Баянговь, Заг, Галуут, Баян-Овоо сумын сургуулийн дотуур байрны барилгын их засвар, хийгдэж барилгын стандарт нормыг мөрдөж эрүүл, аюулгүй тав духтай орчныг бүрдүүллээ. Шаргалжуут тосгоны сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьтай. Баянцагаан сумын 320 барилгын ажил 63 хувьтай, Богд сумын 150 хүүхдийн суудалтай дотуур байрны барилгын ажил 60 хувьтай байна. Баянбулаг сумын дотуур байрны ажил 50 хувьтай Заг сумын 160 хүүхдийн суудалтай барилгын ажил 30 хувьтай гүйцэтгэж байна. | |
| 49 | | 2. Нүхэн жорлонг шинэчилж ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 6 | БШУЯ ны хөрөнгө оруулалтаар "Модерн хаус" ХХК Бөмбөгөр сумын 320 хүүхдийн сургууль, 100 хүүхдийн цэцэрлэг, Заг сумын 160 хүүхдийн сургууль, 75 хүүхдийн дотуур байр, 100 хүүхдийн цэцэрлэг, Баян-Өндөр сумын 320 хүүхдийн сургууль, 80 хүүхдийн дотуур байр, Баянбулаг сумын 90 хүүхдийн цэцэрлэгийн байрны барилгад ус ариун цэврийн байгууламжийг шинээр байгуулж 8 объектыг ашиглалтад оруулж үйл ажиллагаанд ашиглаж байна. Нийт 1,220.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. 3 дугаар ээлжийн Гурванбулаг сумын сургууль, цэцэрлэг, Хүрээмарал сумын дотуур байр, цэцэрлэг, Богд сумын сургууль, цэцэрлэг, Жаргалант сумын сургууль, цэцэрлэг, Шинэжинст сумын дотуур байрны ус ариун цэврийн байгууламж 100 хувь ашиглалтад орж үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. | |
| 50 | | 3. Цэцэрлэгийн гадна талбайг стандартын шаардлагын дагуу тохижуулах | 2021 - 2024 | | 2 | Баянхонгор сумын 11,12 дугаар цэцэрлэгийн гадаа талбайн тоглоом нийлүүлэх тендерт "Би би ди эм эм" ХХК шалгарч 26,490,000 төгрөгийн гадаа талбайн тоглоом, биеийн тамирын хэрэгсэл нийлүүлэхээр гэрээ хийгдсэн. Гэрээний дагуу гадна талбайн тоглоомыг 11 дүгээр цэцэрлэгт 12 сая 597 мянган төгрөгийн, 12 дугаар цэцэрлэгт 13 сая 800 мянган төгрөгийн тоглоомыг тус тус нийлүүлсэн. Цэцэрлэгүүд гадна тохижилт хийж тоглоомоо байршуулсан. Богд, Баян-Өндөр сумын цэцэрлэгүүд барилгын их засвар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийснээс гадна тоглоомын талбайг тохижуулж шинэ тоглоомын хэрэгслүүдийг суурилуулсан. | |
| 51 | 2.3.5. Сургуулийн дотуур байр, гал тогоо, спорт болон урлагийн заалны хүртээмжийг нэмэгдүүлж, сургууль бүрт “Үдийн хоол” олгох боломжийг бүрдүүлнэ. | 1. Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөр хангах | 2021 - 2024 | | 90 | Баянхонгор сумын 11,12 дугаар цэцэрлэгийн гадаа талбайг шинэчилж, тоглоом нийлүүлсэн Цэцэрлэгүүд гадна тохижилтод 26,3 сая төгрөг шийдвэрлэсэн. Мөн Богд, Баян-Өндөр сумын цэцэрлэгүүд барилгын их засвар хийснээс гадна тоглоомын талбайг тохижуулж шинэ тоглоомын хэрэгсэлүүдийг суурьлуулсан. 2021 онд байгууллагын төсвийн зохицуулалтаар Галуут сумын сургуульд 17.5 сая , Баянлиг сумын сургуульд 9 сая төгрөгөөр 2-р хоолны тогоо, хөргүүр, дээжийн хөргөгч, 3-н дамжилга, жигнүүр зэрэг гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлсэн. 2022 онд Бууцагаан, Хүрээмарал, Соого-Сейко, Эрдэм, Номгон сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж БШУЯ-наас шийдвэрлэгдсэн. 2024 онд Галуут, Баян-Өндөр сумын сургуулийн гал тогоог засварлаж орон нутгийн төсвөөс 86,5 сая төгрөг зарцуулав. Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулиудын хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хангалт 67,7 хувьтай байна. Мөн Эрдэм сургуулийн 240 хүүхдийн хичээлийн байр, урлагийн болон хоолны заал бүхий барилгын өргөтгөлийг хийхээр төлөвлөж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан гэрээ байгуулсан. Барилгын ажил 2025 оны 2 дугаар улиралд эхэлнэ. | |
| 52 | 2.3.6. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн тасралтгүй | 1. Тэгш хамран сургах дүйцсэн хөтөлбөр, бичиг үсгийн сургалтын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 750 | Тус ажлын хүрээнд НТС төв болон нэгжүүд мэдээлэл технологийн сургалтын 30 цагийн хөтөлбөр боловсруулж 121 удаагийн сургалтыг зохион байгуулж 2065 иргэдийг хамруулсан сургалтын үр дүнд цахим орчинд ажиллах чадвараа дээшлүүлж, өдөр тутамд хэрэглэгддэг апп-ыг хэрэглэхэд суралцсан. Нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд 33 удаагийн сургалтаар 681 хүнд хүрч ажилласан байна. Оролцогчдыг ангилбал: 15-18 нас-373,19-34 нас 402, 35-39 нас 335, 40-50 нас 187, 51-ээс дээш нас-75, Тэтгэвэрт гарсан-44, Зорилтот бүлгээр ангилбал: | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсролыг дээшлүүлнэ. | | | | | Ажилгүй -88, Төрийн албан хаагч-541, Хувийн хэвшил-83, Малчин-225, Ахмад настан-88, Хүүхэд-391 Үндсэн чиглэлийн 14 агуулгын хүрээнд 1273 удаагийн сургалтад 48424 иргэн, 459 нөлөөллийн үйл ажиллагаанд 35264 иргэн тус тус хамрагдаж, нийт давхардсан тоогоор 83688 иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлсэн. Боловсролын үйлчилгээнд хамрагдсан нийт иргэдийн 52711 нь эмэгтэй буюу 64%, хүүхэд 45646 буюу 63%, төрийн албан хаагч 22980 буюу 27%, хувиараа ХЭ 4585 буюу 10%, малчин 5180 буюу 6.1%, ажилгүй 3701 буюу 5%, Тэтгэвэрт гарсан 1600 буюу 1,9%-ийг тус тус эзэлж байна. “Суралцагч хот” төсөлт ажлын хүрээнд Баянхонгор сумын ЗДТГ, Аймгийн ГХУСАЗСЗ-тэй хамтран хэрэгжүүлж 25.000.000 төгрөгний санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Байгууллага хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах замаар иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны цар хүрээ, хүртээмж, үр дүнг нэмэгдүүлэх, иргэдэд хэрэгцээт мэдлэг ойлголт, хандлагыг түгээх, төлөвшүүлэхийг эрхэмлэн ажиллах зорилготойгоор Баянхонгор сумын хэмжээнд “Суралцагч хүүхэд”, “Суралцагч иргэн”, “Суралцагч гэр бүл”, “Суралцагч байгууллага” зэрэг дэд хөтөлбөрүүдийг нийт 35 багц сургалт, нөлөөллийн үйл ажиллагаагаар өрнүүлэн ажиллалаа. Үүнд: 39 байгууллагын 8038 албан хаагч, нөлөөллөөр 48388 (Хууль эрх зүйн постер, шторкийн хандалтын дүн) 9 багийн 135 оролцогч, нөлөөллөөр 3074 иргэн, 45 гэр бүлийн 180 гишүүн, нөлөөллөөр 225 гэр бүл 745 хүнд, 26 клубийн 349 гишүүн, нөлөөллөөр 11087 хүүхэд нийт 18025 иргэнд хүрч ажиллалаа. | |
| 53 | | 2. Насанд хүрэгчдийн боловсролыг | 2021 - 2024 | | 15000 3 | 2024 онд гэр бүл, гоо зүйн мэдрэмж, ёс суртахуун төлөвшил, иргэний боловсрол, амьдрах ухаан, санхүү, ажил мэргэжлийн чиг баримжаа, тогтвортой хөгжил, мэдээлэл харилцааны технологи, монгол бичгийн сургалт, шинжлэх ухаан, гадаад хэл, “Өрхийн хөгжил” | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тасралтгүй дээшлүүлэх | | | | арга хэмжээ, “Нэг нэгж-Нэг брэнд” ажлын хүрээнд буюу нийт 14 чиглэлээр 624 төрлийн сургалтад 18452 иргэнд сургалт зохион байгуулсан. Хүйсийн хувьд ангилбал: Эрэгтэй 6958 Эмэгтэй 11494 Насны ангилал: 2-14 нас 5753 15-18 нас 3017 18-34 нас 3113 35-39 нас 3418 40-50 нас 1980 50-аас дээш нас 821 Тэтгэврийн нас 321 Хөдөлмөр эрхлэлт: Хүүхэд 8693, Төрийн албан хаагч 4588, Хувиараа хөдөлмөр эрхлэгч 1566, Тэтгэвэрт 472, Ажилгүй 1258, Малчин 1793, Цэргийн насны залуучууд 302, Хөгжлийн бэрхшээлтэй 142 Цахим платформ хөгжүүлэлт: Видео хичээл 128, Зурагт хуудас 247, Богино хэмжээний бичлэг 85, Олон нийтэд мэдээллэсэн 195 Нөлөөллийн үйл ажиллагаа: Зохион байгуулсан арга хэмжээ 136, Хамрагдсан иргэд 12002, Эрэгтэй 35% эрэгтэй, 65% эмэгтэй Захиалгат сургалт: Аймгийн төвийн төрийн 21 байгууллагатай хамтран захиалгат сургалтыг 38 сэдвийн хүрээнд зохион байгуулж, 1462 албан хаагчид хамрагдлаа. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт: Тус сургалтыг Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Политехник коллеж, төрийн бус байгууллагуудтай хамтран 18 төрлийн сургалт зохион байгуулж, гэрчилгээ авч баталгаажсан. Тус сургалтад нийт 197 иргэн хамрагдаж хүйсийн хувьд 44% эрэгтэй, 56% эмэгтэй эзэлж байна. Үүнд: Оёдолчин 8, Гуталчин 3,Тариаланч 13, Үсчин 9, Тогооч 16, Мужаан 4, Гагнуурчин 3, Дундын хадгаламжийн бүлэг 3, Авто засвар 3, Ойжуулалт 12, Хөгжимчин 4, Жолооны курс 67, Өрлөгчин 11, Нярав, Утас засварчин, Бичиг хэргийн ажилтан, Цахилгаанчин тус бүр 1, Малчин 37 БШУ-ны сайд, Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээнд тусгагдсан орон нутгийн иргэдийг цахим ур чадварт сургах ажлын хүрээнд Насан туршийн суралцахуйн төв болон нэгжүүд мэдээлэл технологийн чиглэлээр 30 цагийн хөтөлбөр боловсруулж 40 төрлийн 71 удаагийн сургалтыг зохион байгуулсан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 54 | 2.3.7. Орон нутагт эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэнэ. | 1. Эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэй ажилтанг бэлтгэж, ажлын байраар хангах | 2021 - 2023 | | 400 | Эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэй ажилтанг бэлтгэж, ажлын байраар хангах хүрээнд 2,5 жилтэй 13 мэргэжлийн 246 суралцагч төгсөж үүнээс 53,5 % нь ажлын байраар хангагдаж үүнээс барилгын салбарт /БӨУ, БЗЧ, Мужаан, Сан, Цахилгаан/ 18.2 хувь, үйлчилгээний салбарт /Үсчин, Авто, Хоол үйлдвэрлэл, Ардын гоцлол хөгжим/ 19,9 хувь, Хөнгөн үйлдвэрлэлийн салбар /Оёдол/-5.2 хувь байна. 4, 5 сард 45 хоногийн түр сургалтыг Баянхонгор аймгийн ХХҮГ-тай хамтран зохион байгуулж 8 мэргэжлээр 145 хүн хамруулан үнэмлэх олгосон үүнээс 75% нь ажлын байраар хангагдсан. Мэргэжлийн боловсролын 1 жилтэй 6 мэргэжлийн 90 суралцагч төгссөн үүнээс 70,5 хувь, техникийн боловсролын 3 болон 1,5 жилтэй 7 мэргэжлээр 68 оюутан төгссөн. Нийт 404 төгсөгчөөс 65.0 хувь нь ажлын байраар хангагдсан. | |
| 55 | 2.3.8. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах боломжоор хангах, сургуулийн орчны нэвтрэлт бүртгэлийн системийг шинээр нэвтрүүлнэ. | 1. "Онлайн кабинет" төсөл хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 5 | Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах боломжийг нэмэгдүүлж 642.0 сая төгрөгийн санхүүжилтээр Дижитал ангийг Баянхонгор сумын Номгон, Эрдэнэмандал, Эрдэм, Соого сейкео, Гэгээн сумади сургууль, Бууцагаан, Өлзийт, Бөмбөгөр, Жаргалант зэрэг 9 сургуульд байгуулсан. Ухаалаг самбарыг ЕБС-д байршуулж сургалтын орчныг бүрдүүлсэн.Цахимаар суралцах орчныг бүрдүүлэх зорилгоор сургууль, цэцэрлэг тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлаар боловсролын нэгдсэн сүлжээнд холбогдоогүй ерөнхий боловсролын хичээлийн байр 5, дотуур байр 22, цэцэрлэгийн 6 байрыг UTP болон шилэн кабелиар интернэтэд холбосоноор аймгийн нийт 30 сургуулийн хичээлийн байр дотуур байр бүгд боловсролын нэгдсэн сүлжээнд холбогдсон. Дээрх байранд дотоод сүлжээ, утасгүй интернэтийн орчныг сайжруулж дууссан. Интернэтийн урсгалын хурдыг 10Mbps-аас 1Gbps хүртэл нэмэгдүүлсэн буюу газарзүйн байршлаас хамаарч 4-100 дахин өссөн. 78 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ухаалаг самбар 149 хромбүүк, 892 зөөврийн компьютер, 25 мэдээлэл зүйн танхим, 258 таблет, 201 суурин компьютер, 85 ухаалаг телевизийг ашиглаж байна. Цахим танхимд сурагч хэрэглэх 1775 ширхэг Таблет, Хромбүүк, Whale book, Lenovo зэрэг төхөөрөмжийг хэрэглэж суралцагч бүр орон зай цаг хугацаанаас үл хамааран сургалтын үндэсний нэгдсэн платформыг ашиглан суралцах тэгш боломж бүрдүүлж хот хөдөөгийн боловсролын чанарын ялгааг арилгах тал дээр ажиллаж байна. Medle.mn-нд сургалтын платформд 14 сургуулийн боловсруулсан судлагдахуун тус бүрээр Математикийн 109, Иргэний ёс зүйн боловсролын 68, Монгол хэлний 61, Физикийн 50, Эрүүл мэндийн 22, Орос хэлний 8, Биологийн 5, Англи хэлний 10, Газарзүй 6, нийт 335 ээлжит хичээл бэлтгэн байршуулснаар багш сурагчид платформоос хичээл сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Сургалтын нэгдсэн платформыг ашиглах, суралцах талаар багш нар сурагчдад заавар зөвлөмж мэдээлэл бэлтгэж хүргэснээр сургалтын medle.mn платформыг хичээл сургалтдаа тогтмол ашиглаж хэвшсэн байна. | |
| 56 | | 2. Багш нарыг компьютер, таблетаар хангах | 2021 - 2024 | | 300 | УИХ-ын дарга асан Г.Занданшатарын санаачилсан “Багш бүрд компьютер” хөтөлбөр амжилттай хэрэгжиж төрийн өмчийн бүх сургууль, цэцэрлэгийн багш нарыг 100% буюу 1140 багшид компьютер олгосон. | |
| 57 | 2.4.1. Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн үйл ажиллагааг сайжруулна. | 1. Сургалтын орчныг сайжруулж, боловсон хүчнийг чадавхжуулах | 2021 - 2024 | | 200 | Аймаг орон нутагт “Менежментийн хөтөлбөр”-өөр боловсон хүчин бэлтгэхэд хамтран ажиллаж 32 мэргэжилтэн бэлтгэгдэж, төгсөх курст суралцаж 2023-2024 оны хичээлийн жилд төгсөнө. Шинэ суурьшлын бүс 9-р багийн нутагт ХААИС-ийн Баянхонгор аймаг дахь салбар сургуульд 29780м.кв газрыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэх гэрчилгээ олгож, газартай болоход дэмжлэг үзүүллээ. Тус эзэмшил газарт ХААИС-ийн салбар сургуулийн шинэ цогцолбор баригдах бөгөөд 300 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн барилга барих зураг төсөв болох 200 сая | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгийг орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлэхээр дэмжиж ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар зураг кадастрын түвшинд явж байна. | |
| 58 | 2.4.2. "Бизнесээ эхэл-Бизнесээ хөгжүүл" сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, жижиг дунд үйлдэрлэл эрхлэгчдийг дэмжинэ. | 1. Аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулах | 2021 - 2024 | | 100 | "Бизнесээ эхэл-Бизнесээ хөгжүүл" сургалтыг 320 иргэн, аж ахуй нэгжид зээл олгохын өмнө болон дараа 2 удаа зохион байгуулж, чадавхжуулсан. Үүний үр дүнд хувиараа хөдөлмөр эрхлэгч 57 иргэнд 500.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй, хүүхэд, иргэн асардаг хувиараа хөдөлмөр эрхлэгч 29 иргэнд 128.0 сая төгрөг, хувиараа хөдөлмөр эрхлэгч 76 ахмад настанд 320.0 сая төгрөг, арилжааны банкаар дамжин бизнес эрхлэгч 3 аж ахуйн нэгж, 2 хоршоо, 14 иргэнд 340.0 сая төгрөг, нийт 5 аж ахуйн нэгж, 176 иргэнд 1.2 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | |
| 59 | 2.4.3. Шинэ мэдлэг, патент гаргасан эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн судалгааг гарган бүртгэлжүүлж, урамшуулна. | 1. Эрдэм шинжилгээний багийг байгуулж, шинэ мэдлэг патентийг бий болгох | 2022 - 2024 | | 6 | Аймгийн Засаг даргын "Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, зөвлөлийн дүрэм батлах тухай" 2023 оны А/196 захирамжаар байгуулсан. Аймгийн Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэн, 2024 оны төлөвлөгөөгөө хэлэлцэн баталж, 2024 оны төлөвлөгөөнд 20 ажил тусган баталгаажуулж, 3 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай 4,061.8 төгрөгийн төсвийг Баянхонгор аймгийн “Хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал”-аас санхүүжүүлсэн. МОН Х хөтөлбөрт шалгарч 20.0 сая төгрөгийн грант авсан шилдэг инновац шингэсэн “Шингэн бордоо” төсөл бүтээгдэхүүнээ үйлдвэрлэн, үхэр тэжээхэд туршин гантиг мах боловсруулаад байна.. | |
| 60 | 2.5.1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, | 1. Аймгийн бүтээн байгуулалтын ажилд ажлын байр бий болгох, ажил | 2021 - 2024 | | 500 | Аймгийн бүтээн байгуулалтын хүрээнд шинээр 1312 ажлын байр бий болсон. Үүнээс 832 буюу 63.4 хувь нь байнгын ажлын байр байна. “Эрдэнэ монгол” ХХК-ий бүтээн байгуулалтаар 213 иргэн, ноос, ноолууран хувцас залгаж оёх кителийн үйлдвэрт 15 иргэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | иргэдийн амьдралаа авч явах дадал, хэвшлийг дээшлүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулна. | хайгч бүртгэлтэй иргэдийг хамруулах | | | | байнгын, Баянхонгор сумын шинэ хорооллын хамгаалалтын ногоон байгууламж тариалах ажлын хүрээнд 123 иргэн түр ажлын байраар хангагдаж 48.0 сая төгрөг, Нийтийг хамарсан ажил арга хэмжээний хүрээнд байгалийн давагдашгүй хүчин зүйл болох өвлийн зудад зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг устгах ажилд 445 иргэн хамрагдаж 160.0 сая төгрөгийг зарцуулж түр ажлын байраар хангагдсан. Ажилгүй иргэний тоо 2023 онд 2771 байсан бол 2024 онд 2721 иргэн болж ажилгүй иргэний тоо 50 иргэнээр буюу 1.9 хувиар буурсан байна. Ажилгүйдлийн түвшин 2024 оны жилийн эцсийн байдлаар 7.7 хувь болж өмнөх оноос 0.8 хувиар, ажиллах хүчний оролцооны түвшин 76.8 хувь болж 1.6 хувиар өссөн. | |
| 61 | 2.5.2. Өрхийн болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 250 | “Хөдөлмөр эрхлэлт - 2024” өдөрлөг”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян/, “Баянхонгорт үйлдвэрлэв” бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, “Намрын ногоон өдрүүд-Шилмэл мал 2024” зэрэг 4 арга хэмжээ, сургалт 18, нийт 22 удаагийн томоохон арга хэмжээг зохион байгуулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд 351 өрхийн хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнд 2.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож 604 ажлын байр бий болсон. | |
| 62 | 2.5.3. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангана. | 1. Иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээний ач холбогдлыг таниулж, нийгмийн баталгааг хангах | 2021 - 2024 | | 8150 | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор сумдын Засаг дарга нартай гурвалсан гэрээ байгуулж ажиллалаа. Иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээний ач холбогдлыг таниулах сургалт нөлөөллийн ажлыг 19 удаа зохион байгуулж 6650 хүн хамруулсан. Сайн дурын 7493 даатгуулагч сайн дурын даатгалд хамрагдсан. Үүнээс 0-3 настай хүүхдээ асарч байгаа эх- 1018, малчид – 3952, хувиараа хөдөлмөр эрхлэгч- 2325, 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг/эх -157, бусад – 41 даатгуулагч байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 63 | 2.5.4. Нийгмийн халамжийн бодлогын хүрээнд амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 1. Хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг нийтийг хамарсан ажилд хамруулах | 2021 - 2024 | | 200 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Баянхонгор сумын шинэ хорооллын хамгаалалтын ногоон байгууламж тариалах ажлын хүрээнд 123 иргэн түр ажлын байраар хангагдаж 48.0 сая төгрөг, нийтийг хамарсан ажил арга хэмжээний хүрээнд зудад зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг устгах ажилд 445 иргэн хамрагдаж түр ажлын байраар хангагдан, 160.0 сая төгрөг зарцуулсан. Нийт 568 иргэн түр ажлын байраар хангагдаж, 208.0 сая төгрөг зарцуулсан. | |
| 64 | 2.5.5. Иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх замаар хуримтлалтай болгох арга зүйд сургаж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадвартай болгон “Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. "Хүүхэд бүрт хүүхэд хөгжлийн карт олгож, сар бүр тус картад хүүхдийн хөгжилд зарцуулах дэмжлэг олгох" | 2022 - 2024 | | 15000 | Монгол улсын Засгийн газрын 2023 оны 06 сарын 21-ний өдрийн 236-р тогтоолоор Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам шинэчлэгдэж хүсэлт гаргасан хүүхэд бүрт олгохоор шийдвэрлэсний дагуу аймгийн хэмжээнд тайлант оны 11 сарын гүйцэтгэлээр нийт 0-18 хүртэлх насны 35523 хүүхдэд 37,636.8 сая төгрөгийг хугацаанд нь олгож ажилласан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 65 | 2.6.1. Түүх соёлын дурсгал, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлэн сурталчилна. | 1. Түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах | 2021 - 2024 | | 6 | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын хадгалалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр 115 дурсгалын гурвалсан гэрээг дүгнэж, гэрээг сунган 1.568.500 мянган төгрөгийн урамшуулал олгосон. Нийт 15 дурсгалт газрын орчны цэвэрлэгээ болон хадгалалт хамгаалалтыг сайжруулан хайс хамгаалалтад 3.5 сая төгрөгийн төсөв зарцуулсан. | |
| 66 | | 2. Иргэдийн гар дээр байгаа баримтат өвийг бүртгэх | 2021 - 2024 | | 60 | Соёлын баримтат өвийг бүртгэн баримтжуулах ажлын хүрээнд 19 сумын иргэдийн гар дээр хадгалагдаж буй соёлын баримтат өвд хамаарах 42 ширхэг өвийг бүртгэн баримтжуулалт хийж, өвийн талаар арга зүйн зөвлөгөө сургалтыг зохион байгуулж ажилласан. | |
| 67 | | 3. Биет бус өвийг хамгаалан түгээн дэлгэрүүлэх сургалт, уралдаан тэмцээн зохион байгуулах | 2022 - 2024 | | 5 | Соёлын биет бус өвийг хамгаалан түгээн дэлгэрүүлэх сургалт, уралдаан тэмцээн зэрэг 25 арга хэмжээ зохион байгуулж, Өлзийт, Баянцагаан сумдын морин хуурын дугуйлангийн сурагчдын тоглолт 2 удаа зохион байгуулж нийт 750 гаруй хүүхэд багачууд, болон насанд хүрэгчид хамрагдаж 480,000 төгрөг зарцуулсан байна. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 48 хүнд 2.500.000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн сурталчлан алдаршуулаж, 31 арга хэмжээ зохион байгуулан 2573 хүнийг хамруулсан. | |
| 68 | 2.6.2. Соёл урлагийн салбарыг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, тэдний ур чадвар, ажиллах орчин нөхцлийг сайжруулна. | 1. Мэргэжлийн урлагийн байгууллага, соёлын төвүүдийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах | 2021 - 2024 | | 80<br>190 | 2024 онд 8 сумыг соёлын өвийн ажилтантай болгосон. Мэргэжлийн бус албан хаагчдаа мэргэшүүлэх зорилгоор Соёл Урлагийн Их сургуультай хамтран соёл судлал, номын сан судлал, багш -хөгжмийн боловсрол, багш-бүжгийн боловсрол, соёлын менежмент бакалаврын эчнээ хөтөлбөрт соёлын 5 чиглэлээр нийт 50 албан хаагчийг 2,5 жилийн хугацаатайгаар СУИС-тай 20 хувийн хөнгөлөлттэй суралцах гэрээ байгуулан суралцуулж байна. Мөн 2024 оны Соёлын тевийн хегжмийн багш нарыг видео монтаж, эвлүүлгийн программ ашиглах чадварт сургах 2 едрийн сургалтад Жаргалант, Баян-Өндөр, Эрдэнэцогт, Хүрээмарал сумдын хегжмийн багш нар хамрагдсан. Соёл, спорт, аялал жуулчлал, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | залуучуудын яамнаас Соёл Урлагийн Их сургуультай хамтран "Соёлын төв" ордны дуу, гэрлийн техникчдийн чадавхыг бэхжүүлэх, мэргэшүүлэх" кредит тооцох сургалтад Хөгжимт драмын театр, Галуут сум, Бөмбөгөр сум, Өлзийт сум, Богд сумдын 4 техникийн ажилчид суралцаж төгссөн. | |
| 69 | | 2. Соёлын төвийн бүтэц орон тоог нэмэгдүүлэн соёлын өвийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх | 2022 - 2023 | | 8 | Баянговь, Жаргалант, Баянцагаан, Баацагаан, Өлзийт, Баянлиг, Богд, Шинэжинст, Заг 9 сумдын Соёлын төвийн өвийн ажилтаны орон тоог Соёлын яамтай зөвшилцөн бүтэн 6 орон тоогоор шийдвэрлэж 09 дүгээр сарын төсөвт цалин нэмэгдэл 68215.1 мян төгрөгийг бүрэн шийдвэрлэсэн. Ингэснээр аймгийн хэмжээнд нийт 19 сумын Соёлын төв Музейн сан хөмрөгч буюу өвийн ажилтантай болсон. Мөн Соёлын төв, соёлын ордон, Орчин ба үйлчилгээ MNS 6981:2022 стандартын Е хавсралтад заасны дагуу техникчийн 6 орон тоог Соёлын төвүүдэд батлагдсан төсөвтөө багтаан авч ажиллуулж байна. | |
| 70 | 2.6.3. “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. "Соёлтой Баянхонгорчууд" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх | 2022 - 2024 | | 100 | "Соёлтой Баянхонгорчууд" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж 31 арга хэмжээнээс 18 арга хэмжээг 100 хувьтай хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 58 хувьтай. Орон нутаг болон байгууллагаас 13,7 сая төгрөгийн төсөв зарцуулсан. | |
| 71 | 2.6.4. Соёлын төвүүдийн орчин нөхцлийг сайжруулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 1. Соёлын төвүүдийн барилгыг шинэчлэх, иргэдийг соёлын боловсролын судалгааг хийх | 2021 - 2024 | | 0<br>50 | Соёлын сайдын 2023 оны А/390 тушаалаар батлагдсан “Үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал” тооцох журмын дагуу Соёлын байгууллагуудын 2022 оны ажлыг дүгнэж 23 соёлын байгууллагад 206558.7 мян төгрөгийн үр дүнгийн гүйцэтгэлээр санхүүжилтийг олгосон бөгөөд журмын дагуу 40 хувь буюу 82623.5 мян төгрөгийг байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалтад зарцуулан үр дүнг тооцон ажилласан. 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинэ соёлын төвийн барилгатай болохоор Баян-Өндөр сумын соёлын төв Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хандан хөрөнгө оруулалтыг оруулсан байна. Орон нутгийн хөгжлийн сангаас Заг сумын соёлын төв 10.0 сая төгрөгийн урсгал засвар, 30.0 сая төгрөгийн гадна тохижилт, Гурванбулаг сумын соёлын төв 2.0 сая төгрөгийн засвар, Баянцагаан сумын соёлын төв 35.0 сая төгрөгөөр ариун цэврийн байгууламж, Бөмбөгөр сумын соёлын төв 10.0 сая төгрөгөөр орон нутаг судлах танхимын тохижилт, Баян-Өндөр сумын соёлын төв орон нутаг судлах танхимын тохижилт 12.5 сая төгрөг, ногоон байгууламжийн хайс 8.0 сая төгрөг, машины зогсоолын тохижилт 20.0 сая төгрөг нийт 40.5 сая төгрөгийн санхүүжилтийг хийж ажиллагаагаа өргөтгөжээ. | |
| 72 | | 2. Зарим сумдын соёлын төвийн орон нутаг судлах танхимыг өргөжүүлэх | 2022 - 2023 | | | Аймгийн хэмжээд 18 сумын соёлын төв орон нутгийн судлах төвтэй болж үйл ажиллагаа жигдэрсэн. Баян-Овоо сумын Музейн барилгын ажил 2022 онд орон нутгийн хөгжлийн сангаас 298,0 сая төгргийн санхүүжилтээр шийдэгдэж 2024 оны 10 дугаар сарын 01-нд барилгыг улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан. | |
| 73 | | 3. Соёлын төв, мэргэжлийн урлагын байгууллагын тоног төхөөрөмжийг сайжруулах | 2021 - 2024 | | 5 | ССАЖЗЯамны хөрөнгө оруулалтаар харьяа байгууллагуудад нийт 21 нэр төрлийн 155,802,1 мянган төгрөгийн 328ш тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг шийдвэрлүүлэн хүлээн авч байгууллагуудад хүлээлгэн өгсөн. Мөн 2025 онд улсын төсөв болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх зайлшгүй шаардлагатай байгаа барилга байгууламж, ажил үйлчилгээ, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил болох нийт 727,634,5 мянган төгрөгийн судалгааг авч нэгтгэн ажилласан. | |
| 74 | 2.6.5. Иргэн бүрийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлж, сумдын номын | 1. Иргэдийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлэх арга | 2021 - 2024 | | 95 2 | Нийтийн номын сан болон 19 соёлын төвийн номын сангийн уншигчдын тоо танхимаар 19027, цахимаар 39, номын фондыг 28,7 сая төгрөгийн 3581 ширхэг номоор баяжуулсан. Зөөврийн номын сангийн үйлчилгээнд 6570 иргэн, явуулын номын сангийн үйлчилгээнд 6573 иргэн хамрагдаж уншлагын хүртээмжийг нэмэгдүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сангийн үйлчилгээг өргөжүүлж, үйл ажиллагааг сайжруулна. | хэмжээ зохион байгуулах | | | | “Соёлын төвийн номын санчдын дунд зохион байгуулах ажил мэргэжил, ур чадварын уралдаан”-ыг дүгнэж ажилласан. | |
| 75 | 2.6.6. Аймгийн түүхийн музейн барилгыг барьж биет болон биет бус өвийн мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулна. | 1. Хөдлөх дурсгалын мэдээллийн санг баяжуулах | 2021 - 2024 | | 800 | Музейн сан хөмрөгт иргэдээс бэлэг, хандиваар 997.000 төгрөгийн үнэлгээтэй 19 үзмэрээр сан хөмрөгөөр баяжуулан үзмэр эд өлгийн зүйлийг бүртгэлийн ерөнхий дэвтэрт бүртгэн авч ажиллалаа. | |
| 76 | | 2. Биет бус өвийн мэдээллийн санг баяжуулах | 2021 - 2024 | | 11 | Соёлын биет бус өвийн мэдээллийн санг баяжуулах ажлын хүрээнд нийт 35 иргэнийг бүртгэн баримтжуулж ажилласан байна. | |
| 77 | 2.7.1. Хүүхдийн хөгжил, төлөвшлийг сайжруулж, монгол өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг иргэн болгож, эцэг, эхийн үүрэг оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлнэ. | 1. "Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгааллалд хамтдаа" зорилтот төсөл хэрэгжүүлэх | 2022 - 2024 | | 6000 | Аймгийн хэмжээнд 2021-2024 оны хичээлийн жилд 32 ерөнхий боловсролын сургууль, 43 сургуулийн өмнөх боловсролын байгууллага сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгууллаа. Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийг суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтан, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, тэдний оролцоог хангах зорилгоор олон талт нөлөөллийн дараах ажлуудаар дамжуулан зохион байгууллаа. Эцэг эх асран хамгаалагч нарт /БЕХ-ийн 40 дүгээр зүйл/ Эцэг эхийн нэг өдөр Эцэг эх асран хамгаалагчдын оролцоо өдөрлөг Эцэг эх танд бид хүрч очъё Зочинтой өдөрлөг гэх мэт. Тус арга хэмжээгээр дамжуулан нийт 16832 эцэг эхэд танхимаар, алсагдсан малчин эцэг эхчүүдэд 16 видео контент, гарын авлага брошур 2000 ширхгийг хэвлэн хүргүүлж ажиллалаа. Анги удирдсан багшаар дамжуулан 4-12 дугаар ангийн 13449 суралцагчдад БЕХ-ийг /10 зүйл/ суталчилах ажлын хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулах | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | танилцуулгыг хийж, цахим хэлбэрээр ангиудын групп чат, цахим хуудсанд байршуулсан.Цэцэрлэг Ерөнхий боловсролын сургуулийн багш ажилтнуудад хууль сурталчлах 14 хоногийн аян өрнүүлэн 100% хамруулсан. 4. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд хөгжил хамгааллын газартай хамтран 2021-2024 онуудад “Эцэг эх асран хамгаалагч танд бид хүрч очъё” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 16000.000 эцэг эхэд хүрч ажиллан хүүхдийн хүмүүжлийн эерэг арга, хууль тогтоомжийн сан, сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл, ахуйн хүрээний осол гэмтлээс урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг хүргэн ажиллалаа. | |
| 78 | | 2. Эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах | 2021 - 2024 | | 3000 | Аймгийн ГХУСЗЗ-тэй хамтран “Эцэг эх, асран хамгаалагч таньд бид хүрч очьё” арга хэмжээг Баянхонгор сумын хэмжээнд 2 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Мөн “Анги удирдсан багшаар дамжуулан эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх”, “Төлбөр хураамж, хандивын зааг”, Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг үе шаттайгаар зохион байгууллаа. Эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт зохион байгуулж нийт 12800 эцэг эх хамруулж мэдээлэл хүргэлээ. | |
| 79 | | 3. Аймгийн хүүхдийн нэгдсэн чуулган зохион байгуулах | 2021 - 2024 | | 70 | Аймгийн хүүхдийн нэгдсэн чуулганыг “Оролцъё-Хөгжье-Хамгаалагдъя” уриан дор зохион байгуулж, 18 сумын 30 ерөнхий боловсролын сургуулийн 260 хүүхэд, 37 үүрэг хүлээгчид оролцсон. Чуулган зохион байгуулсны үр дүнд хүүхэд нийгмийн амьдралд оролцох, хөгжих эрхээ хэрэгжүүлэн, хүүхэд бүрийн оролцоог ханган ажилласан төдийгүй хүүхдүүд орчин тойрондоо тулгамдаж буй асуудлаа тодорхойлон шийдвэр гаргагч түвшний хүмүүст хандан асуудал шийдлийн талаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлсэн. Чуулганы төлөөлөгч хүүхдүүдээс гарсан 29 саналыг шийдвэр гаргагч түвшний хүмүүс сонсож 2025 оны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх боломжтой асуудлуудыг шийдвэрлэхээ илэрхийлсэн. 2023 оны чуулганаас гарсан саналын шийдвэрлэлт 78 хувьтай. | |
| 80 | | 4. "Хамтдаа шийдье" төсөл хэрэгжүүлэх | 2021 - 2022 | | | Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар "Хамтдаа шийдье" төсөлт арга хэмжээг мэргэжлийн удирдлага арга зүйгээр ханган НҮБ-ын хүүхдийн сан, аймгийн Засаг даргын тамгын газар,Нийгмийн бодлогын хэлтэс, сумдын ЗДТГ, Жаргалтай амьдрал төвтэй хамтран хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд нийт 20 сумын 10623 өрхөд бага насны хүүхдийн цогц хөгжил, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, архидалтаас урьдчилан сэргийлэх нь сэдвээр сургалт зохион байгуулан, эрсдэлийн үнэлгээ хийсэн. Төслийн үр дүнд: Сургуулийн өмнөх боловсролоос завсардсан 1168, сургууль завсардсан 12, өсөлт хөгжлийн хоцрогдолтой 4 хүүхэд, архины хамааралтай 8 иргэн, гэр бүлийн хүчирхийллийн 14 кейс нийт 154 кейсийг илрүүлж сумдын хамтарсан баг, Жаргалтай амьдрал төвд холбон зуучилсан. Сумдын хамтарсан багийн 316 албан хаагчийг сургагч багшаар бэлтгэж мэдлэг, чадварыг нэмэгдүүлсэн.Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөг 196 иргэнд өгч, хүүхдийн мөнгөний 19 өргөдлийг шийдвэрлэсэн. Явцын хяналт, шинжилгээ зөвлөн туслах үйл ажиллагааг бодлогын хэлтээс 2 удаа зохион байгуулсан. Шинээр 7423 өрхийг хамруулсан. | |
| 81 | | 5. 4 настай хүүхэдтэй аавуудад чиглэсэн зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 50 | "Сайн аав" төсөлт арга хэмжээг Зэвсэгт хүчний 339 дүгээр цэргийн ангийн бие бүрэлдэхүүн, хугацаат цэргийн албан хаагчдыг түшиглэн хэрэгжүүлж 200 хүнд гэр бүлийн боловсрол олгосон ба 4 настай хүүхэдтэй 100 аавд чиглэсэн сургалт болон "Аав, Ээж, Би" гэр бүлийн тэмцээнийг зохион байгуулж 4 настай хүүхэдтэй 26 гэр бүл оролцсон. | |
| 82 | 2.8.1. Гэр бүлийн боловсролыг бүх | 1. "Хонгорын гэр бүл" зорилтот арга | 2021 - 2024 | | 80 | "Хонгорын гэр бүл" арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг 2 зорилт 15 арга хэмжээтэйгээр боловсруулан, хэрэгжүүлж ажиллалаа. Гэр бүлд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | насны хүмүүст амьдралын мөчлөг, насны онцлогт тохирсон байдлаар олгоно. | хэмжээг хэрэгжүүлэх. | | | | зориулсан үйлчилгээг хөгжүүлж дэмжих зорилтын хүрээнд “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх арга техник” сургалтад сургуулийн нийгмийн ажилтан, нийгмийн бодлогын мэргэжилтэн, сэтгэл зүйч нар нийт 90 хүнийг хамруулан бэлтгэж, “Гэр бүлд зөвлөгөө өгөх” төвөөр 43 хүнд хосын болон ганцаарчилсан зөвлөгөө өгсөн. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгээр Богд, Жаргалант, Бууцагаан суманд “Хамгаалах байр” байгуулж, тохижуулан үйл ажиллагааг нь эхлүүлсэн. Гэрлэх ёслолын үйлчилгээний журмыг аймгийн ИТХ-ын 2023 оны 16/51 тогтоолоор батлуулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. “Сайн аав” төсөлт арга хэмжээг Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн нийт бие бүрэлдэхүүн, хугацаад цэргийн алба хаагчдад хэрэгжүүлж, 19 удаагийн сургалт, 3 удаагийн лекц, 14 удаагийн бүжгийн хичээл орсон. Гэр бүлийн боловсрол олгох зорилтын хүрээнд 8 модуль сургалтыг бүх насны иргэдэд амьдралын мөчлөг, насны онцлогт нь тохирсон байдлаар үе шаттайгаар зохион байгуулж, 1170 хүн хамрагдсан. Хүйсээр ангилвал 668 эрэгтэй, 502 эмэгтэй байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай. | |
| 83 | | 2. Хувь хүн, гэр бүлтэй ажиллах хүний нөөцийг бэлтгэх, ажлын байраар хангах, тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлэх | 2022 | | | Гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтын сургагч багш бэлтгэх сургалтыг танхимын хэлбэрээр зохион байгуулж нийгмийн бодлогын мэргэжилтэн-16, насан туршийн боловсролын нэгжийн менежер-33, багийн нийгмийн ажилтан -10, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар нийт 90 хүнийг хамруулсан. Олон Улсын Улаанбатар Их сургуультай хамтран “Гэр бүл судлал”-ын магистрын ангид орон нутагтаа 30 хувийн хөнгөлөлттэй суралцах боломжийг бүрдүүлж магистрын ангид 8 сумын 25 оюутан элсэн орж амжилттай суралцаж байна. Мэргэжлийн холбоодтой хамтран "Сэтгэл зүйн клуб" байгуулж сумдад зөвлөн туслах ажлыг 1 удаа зохион байгууллаа. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 84 | | 1. Хуримын ордныг ашиглалтад оруулах | 2021 - 2022 | | | Хуримын ордныг ашиглалтад оруулж төлбөртэй хурим 63, хөнгөлөлттэй хурим 7 нийт 70 хуримын ёслолыг зохион байгуулсан. Гэрлэх ёслолоо хийж буй 52 гэр бүлийн 104 хосуудад гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг зохион байгуулж гэр бүлийн үүрэг хариуцлага, гэр бүлийн хүчирхийлэл, угийн бичиг хөтлөх арга зүй, хүмүүжлийн эерэг арга, гэр бүл төлөвлөлт, өрхийн төсвийн талаар мэдлэг олгосон. Нийт 70 хуримын ёслолын 68 нь залуу хосын хурим, 1 нь алтан хурим, 1 нь мөнгөн хурим байна. Гэрлэх ёслолоо хийж буй хосуудын харьяалалыг авч үзвэл Улаанбаатар хотоос 7, Төв аймгаас 1, Өмнөговь аймгаас-1, Баянхонгор аймгийн сумдаас-17, аймгийн төвөөс 44 байна. | |
| 85 | 2.8.2. Хуримын ордныг ашиглалтад оруулж, гэр бүлд чиглэсэн үйлчилгээний төрлийг өргөжүүлж, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг сайжруулна. | 2. Хуримын ордныг түшиглэсэн гэр бүлийн зөвлөгөө өгөх төв, сумдад загвар төв байгуулах | 2022 - 2024 | | 3 450 | "Гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-өөр дамжуулан 219 хүнд сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн. Зөвлөгөө авахаар ирсэн иргэдийн 121 буюу 55.2 хувь нь гэр бүлийн харилцаа, зөрчил, гэр бүл цуцлалтын талаарх зөвлөгөө мэдээлэл авсан бол 98 буюу 44.8 хувь нь хүүхэдтэй холбоотой асуудлаар зөвлөгөө мэдээлэл авсан. Гэр бүлээ цуцлуулахаар шүүхэд хандсан иргэдийн эвлэрүүлэн зуучлах үйлчилгээнд хамтран ажиллахаар болж 2 гэр бүлд бүлгийн зөвлөгөө өгч хосын карт ажиллуулсан. Аймгийн хэмжээнд 29 хамтарсан багийн нийгмийн ажилтан ажиллаж байгаагаас 16 нь /65.5 хувь/ хохирогчтой ганцаарчлан уулзах боломжтой, мөн Баянхонгор сумын II, III, IX багууд, Богд, Баянлиг, Баянговь, Баянцагаан, Баацагаан, Бууцагаан, Хүрээмарал, Гурванбулаг, Заг, Баян-Овоо, Эрдэнэцогт сумдад "Зөвлөгөө өгөх төв"-, хамгаалах байр ажиллаж байна. Зөвлөгөө өгөх төвтэй сум 15, үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 219 байна. | |
| 86 | | 3. Монголын гэр бүл судлаачид, нийгмийн ажилтан, | 2021 - 2024 | | 200 | Гэр бүл судлалын мэргэжлийн холбоо, орон нутагт бэлтгэгдсэн гэр бүл судлалын магиструудтай хамтын ажиллагаа өргөжүүлэн ажиллаж байна. Ажлын хүрээнд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сэтгэл зүйчдийн мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагааг өргөжүүлж техникийн туслалцааны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | | | | гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг бүх насны иргэдэд амьдралын мөчлөг, насны онцлогт нь тохирсон байдлаар үе шаттайгаар зохион байгуулсан. Сургалтад 1174 иргэн хамрагдаж, ойлголт мэдлэгтэй болсон. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, гэр бүлийн боловсрол, гэр бүлийн харилцаа хандлага, гэр бүл цуцлалтын хор уршгийн асуудлаар зөвлөгөө мэдээллийг өгч 4 иргэнийг өмгөөллийн үйлчилгээнд, 2 иргэнийг хамгаалах байранд холбон зуучилсан. Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс иргүүлсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдаж байгаа 13 гэр бүлийн 26 хүнд ганцаарчилсан болон хосын сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл өгөхөөс гадна гэр бүлийн боловсрол, гэр бүл цуцлалт хүүхдэд хэрхэн нөлөөлөх нь сургалтуудыг үе шаттайгаар зохион байгууллаа. Үүний үр дүн 13 гэр бүлийн 3 хос буюу 23.1 хувь нь эвлэрсэн. | |
| 87 | 2.8.3. Залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжсэн хөтөлбөрт арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2021 - 2022 | | | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, шинэ технологи, инновац бүхий шинэлэг санаа, санаачилга гаргаж, аж ахуй эрхлэх төсөл боловсруулж, бизнесээ эхлүүлэх, гарааны дэмжлэг олгох, бизнесээ тогтвортой эрхлэхийг дэмжих зорилгоор 75 залууд гарааны бизнесийн сургалт зохион байгуулж, 7.8 сая төгрөг зарцуулсан. Шилдэг гарааны бизнес эрхлэгч залуу болон залуучуудын багийг өрсөлдөөний зарчмаар шалгаруулж, 1 шилдэг гарааны бизнесийн багт 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 2 шинэ ажлын байр бий болсон. Залуучуудын эрүүл мэнд, өсвөр насныхны эрүүл мэнд болоод боловсролд чиглэсэн үзлэг, сургалт, өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд давхардсан тоогоор 14771 залуучууд хамрагдаж 8451 буюу 57.2 хувиас өвчлөл илэрч илэрсэн эмгэгийг эмчлэн эрүүлжүүлж байна. “Эрчүүдийн эрүүлд мэнд, сэтгэлзүйн онцлог”,”Өсвөр үеийн эрүүл мэнд” сэдвийн хүрээнд 87.5 цагийн 27 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | удаагийн багц сургалтуудыг 6139 залуучуудад хийж сургалтын дараах мэдлэг 75 хувиар өссөн үр дүнтэй. Аймгийн Засаг даргын 2022 оны А/196 дугаар захирамжаар Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Жил бүр гишүүдийн санал зөвлөмжийг тусган үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг тусган батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласан. Төлөвлөгөөний биелэлтийн дундаж 96 хувьтай. Үндэсний хөтөлбөр хэрэгжиж хугацаа дууссан. | |
| 88 | | 2. "Хариуцлагатай 100 залуу элч"- ийг бэлтгэх | 2021 - 2024 | | 10000 | "Тэгш боломжийн төлөө залуучуудын манлайлал" болон амьдрах ухааны 11 модуль сургалтыг 730 залучуудад зохион байгуулсан. Залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжих ажлын хүрээнд оюутны эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг сайжруулах, эрүүл мэндийн даатгалын сайн дурын сургагч бэлтгэх ажлуудыг хэрэгжүүлж хариуцлагатай 104 залуу элчийг бэлтгэсэн. | |
| 89 | 2.8.4. Жендэр ба хөгжил хандлагыг төлөвшүүлнэ. | 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2021 - 2022 | | | "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөг 2023-2026 онд хэрэгжүүлж, 2024 оны төлөвлөгөөнд 80 ажил, арга хэмжээ тусган батлуулж, төрийн байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтийг хангаж ажилласан. Аймгийн Жендэрийн салбар хороо, Хууль эрх зүйн хэлтэс хамтран “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”, "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2023-2026 он/"-ний хэрэгжилтэд үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн. "Гэр бүл ба жендэр" сургалт, нөлөөллийн арга хэмжээг аймгийн Дугуйн холбоотой хамтран зохион байгуулж, тус холбооны гишүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, дугуйн аялал зохион байгуулан жендэр, гэр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүл төлөвлөлт, халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгосон. Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 71 дүгээр захирамжаар батлагдсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Жендэрийн үндэсний хорооноос танилцуулж, сургалт хийлээ. Сургалтад аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Баянхонгор сумын төрийн 31 байгууллага, 20 сумын Засаг даргын Тамгын газрын төлөөллөөс бүрдсэн 200 гаруй албан хаагч цахимаар болон танхимаар хамрагдав. Сургалт, уулзалтаар эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон цаашид хэрхэн хэрэгжүүлэх гарц, шийдлийн талаар мэдээлэл авсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 75 хувьтай . | |
| 90 | | 2. Жендэрийн салбар хороо, дэд хороодын гишүүдийн чадавхийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 85 | Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хууль эрх зүйн хэлтэс хамтран 2024 оны 1 дүгээр сард “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого төлөвлөлт, төсөвлөлт” сэдэвт явуулын сургалтыг Өлзийт, Баян-Овоо сумдын Засаг даргын тамгын газар, төрийн байгууллагууд, Баянхонгор аймгийн Цагдаагийн газар, Боловсрол шинжлэх ухааны газрын албан хаагчдад амжилттай зохион байгууллаа. Сургалтад нийт 212 төрийн албан хаагчдыг хамруулж, 6 модуль хичээлээр жендэрийн талаарх анхан, дунд шатны мэдлэг олгосон. Аймгийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Жендэрийн салбар хорооны гишүүд, Нийгмийн бодлогын хэлтэс, Цагдаагийн газар хамтран "Охид эмэгтэйчүүд хаана ч аюулгүй-Шалтаг бүү тооч" аяны нээлтийг 11 дүгээр сарын 25-ны өдөр Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын танхимд зохион байгуулж, Эрдэм ахлах сургуулийн 60 гаруй сурагчдыг хамруулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нээлтийн үйл ажиллагааг Баянхонгор аймгийн Номгон телевиз мэдээлэл бэлдэж олон нийтэд хүргэсэн. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Баянхонгор аймгийн Номгон телевиз цахим хуудаст тус тус сурталчилж ажилласан. Хандалтын тоо 2.5к байна. Аяны хүрээнд төрийн байгууллагын ажилтан, албан хаагчид 66 хүнд “Гэр бүл дэх жендэрийн харилцаа” сургалтыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын Захиргаа, хүний нөөцийн асуудал харицсан ахлах мэргэжилтэн Ч.Баярдалай, “Гэр бүл дэх хүүхдийн хүмүүжил” сургалтыг Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Батцэнгэл, “Хувь хүний хөгжил” сургалтыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Залуучуудын хөгжлийн төвийн мэргэжилтэн Г.Очгэрэл нар хамтран зохион байгуулав. Сургалтад оролцогчдод “Охид эмэгтэйчүүд хаана ч аюулгүй шалтаг бүү тооч” уриаг хэвлүүлсэн балыг тарааж, аяныг үйл ажиллагааг сурталчилсан. Нийт 4 удаагийн сургалтад 230 хүн хамрагдаж, мэдлэгээ нэмэгдүүлсэн байна. Төлөвлөгөөний биелэлт 85 хувьтай. | |
| 91 | 2.8.5. Өвгөнжаргалант зусланг орчин үеийн хүүхдийн зуслангийн жишигт нийцүүлж, сум бүрт хөдөлмөр зуслан байгуулж, хүүхдийг монгол ахуйд сургана. | 1. Зуслангийн хөгжлийн хөтөлбөрт хүүхдүүдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 1000 | “Өвгөнжаргалант” хүүхдийн зуслангийн хөгжлийн хөтөлбөрийг батлуулж, зуслангийн 2024 оны ээлжийн хуваарийг гарган ажилласан. Зуслангийн үйл ажиллагаа Ерөнхий шаардлага MNS5633:2023 стандартыг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох материалыг бүрдүүлж, тохирлын гэрчилгээ авсан. Тайлант онд 7 ээлжид өөрийн аймгаас гадна Улаанбаатар, Ховд, Говь-Алтай аймгийн 1015 амрагч хүүхэд хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан. Батлан хамгаалах яамны сургалтын албатай хамтран “Байгальд дасан амьдрах ухаан” хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлсэн нь амрагч хүүхдүүдийн сайшаалыг хүртсэн. “Өвгөнжаргалант” зусланг түшиглэн амьдрах ухааны хөдөлмөр зуслангийн 2 ээлжийг зохион байгуулж 5 сумын 125 хүүхэд хамрагдаж, Монгол ёс заншил уламжлалт арга ухаан, мал маллах, сүү цагаан | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | идээ боловсруулах, сур элдэх зэрэг амьдрах ухаанд суралцсан. Үйл ажиллагаанд Хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийн зардал, амрагч хүүхдүүдийн төлбөр 130.0 сая төгрөг зарцуулсан. | |
| 92 | | 2. Хөдөлмөр зусланг ажиллуулах | 2021 - 2024 | | 3 | | “Өвгөнжаргалант” зусланг түшиглэн амьдрах ухааны хөдөлмөр зуслангийн 2 ээлжийг зохион байгуулж 5 сумын 125 хүүхэд хамрагдаж, Монгол ёс заншил уламжлалт арга ухаан, мал маллах, сүү цагаан идээ боловсруулах, сур элдэх зэрэг амьдрах ухаанд суралцсан. | |
| 93 | | 3. Өвгөнжаргалант зусланг орчин үеийн хүүхдийн зуслангийн жишигт нийцүүлэн тохижуулах | 2021 - 2024 | | 50 | | Хүүхдийн авьяас чадвар, бие бялдар, ур чадварыг хөгжүүлэх, үндэсний өв соёлыг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сантай гэрээ байгуулж, 25.0 сая төгрөгний санхүүжилтийг авснаар Хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн сайжруулж, зуслангийн хөгжлийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн. Үүнд: Морин хуур-10, Лимбэ-2, Шанз-2, Ёочин-2, Хуучир-2, Ятга-2, Мандолин-10, Гитар-10, Гар бөмбөг-5, Сагсан бөмбөг-5, Хөл бөмбөг-3, Теннисний ширээ-2, Волейболын тор-2, Аркет-4, Танин мэдэхүйн тоглоом-10, Монгол гэр угсардаг тоглоом-10, Номын сан байгуулах ном-180 ширхгийг тус тус шинээр авсан. Зуслангийн 5 бүлэг, 2 гал тогоо, соёлын төв, цагдаагийн байр, теннисний өрөөний дотор болон гадна талыг будаж засварлах, зусланг тойруулан хашаа хийх, 3 газарт хаалга хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Өвгөнжаргалант зусланг орчин үеийн хүүхдийн зуслангийн жишигт нийцүүлэх зорилгоор тохижилтын ажил 70 хувьтай хийгдсэн. “Өвгөнжаргалант” хүүхдийн зусланд шинээр спорт цогцолбор байгуулах зураг төсвийг хийж, 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 130.0 сая төгрөг тусган батлуулсан. Эрчим хүчний төвлөрсөн системд холбуулахаар зураг төсвийг НҮБ-ын Хүүхдийн сан, Сангийн яаманд хүсэлтийг хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 94 | 2.8.6. Хүүхдийн эрхийг дээдлэн “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг хэрэгжүүлж, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дарамтад өртсөн иргэнийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны үйл ажиллагааг өргөжүүлнэ. | 1. "Хүүхдэд ээлтэй орон нутаг" хөтөлбөрийн удирдлагын болон хэрэгжүүлэгч багуудын ажлын уялдаа холбоог сайжруулах | 2021 - 2022 | | | Ерөнхий боловсролын сургуульд 2021-2024 онд хүүхдийн өөрийн удирдлагын 87 байгууллага үйл ажиллагаагаа тасралгүй явуулж хүүхдүүдэд нөлөөлөн ажиллаж байна. ХӨУБ-н хүүхдүүдээс улс, бүсийн арга хэмжээнүүдэд тасралтгүй оролцож байна. Хүүхдийн оролцооны үндэсний чуулганд-23 хүүхэд, Монголын хүүхдийн зөвлөлийн майхант цугларалтад-9, Теен хуралдайд-2, “Өсвөрийн парламент-2024” хөтөлбөрт-4, нийт 34 хүүхдийг улсын хэмжээний хурал чуулганд оролцуулснаар хүүхэд өөрийн мэдлэгийн хүрээгээ тэлж, илтгэх, ярих, багаар ажиллах чадваруудад суралцаж чадавхажсан. Хүүхдийн оролцооны байгууллагаас санаачилсан 9 төрлийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж арга хэмжээнүүдэд 467 хүүхэд оролцсон. Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан Илтгэлийн тэмцээн зохион байгуулж 20 хүүхэд, Сургуулиудын хүүхдийн зөвлөл болон ХӨУБ-уудын гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулж 98 хүүхэд,” Найз байя” аянд 2800 хүүхэд, Охидын өдөрлөг-310 охин, Сэтгэлийн гал арга хэмжээнд 20 хүүхэд, Мартагдашгүй март, “Бидний манлайлал” охидын өдрийн арга хэмжээнд нийт 57, “ Movie night” кино хэлэлцүүлэг-35 хүүхэд, Өсвөр насны сурагчдын дунд мэтгэлцээний тэмцээн-40 нийт 3390 хүүхэд хамрагдсан. Хүүхдүүдийн санаачилсан ажлыг дэмжин ажилласны үр дүнд оролцооны байгууллагуудын үйл ажиллагаа тогтмолжиж, гишүүдийн идэвх оролцоо сайжирч багаараа нөлөөллийн аян, арга хэмжээнүүдийг хамтран хэрэгжүүлж, хүүхэд хүүхдэдээ нөлөөлж, оролцооны байгууллагын гишүүний үүргээ нэр төртэй биелүүлэн манлайлан оролцож байна. "Хүүхдэд ээлтэй орон нутаг" хөтөлбөрийн хэрэгжилт 90 хувьтай. | |
| 95 | | 2. Хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагуудын | 2021 - 2024 | | 10 | Аймгийн Хүүхдийн Нэгдсэн Зөвлөл болон бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ХОӨУБ-уудтай хамтран 16 ажил, арга хэмжээг зохион байгуулж 1027 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйл ажиллагааг идэвхжүүлэх | | | | хүүхэд хамрагдсан. Хүүхдийн оролцооны өөрийн удирдлагын байгууллагын гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2 удаа танхимаар зохион байгуулж, 1027 хүүхэд хамрагдсан. Сумдын хүүхдийн оролцооны байгууллагын гишүүдийг чадавхжуулах сургалтыг цахимаар 1 удаа зохион байгуулж, 60 сурагч хамрагдсан. Ерөнхий боловсролын сургуулийн “Эко клуб”-ын гишүүдийг чадавхжуулах сургалтыг танхимаар 1 удаа зохион байгуулж, 30 хүүхэд хамрагдсан. Аймгийн хүүхдийн зөвлөл, Лидер сурагч академи, Өсвөрийн парламент зэрэг оролцооны байгууллагуудын санаачилсан 7 ажил арга хэмжээг дэмжин хамтран ажилласан. “Даймонд майнд” академитай хамтран Хүүхдийн оролцооны өөрийн удирдлагын байгууллагын төлөөлөл 30 хүүхдийг 7 хоногийн цахим сургалтад хамруулж, “Өсвөрийн сургагч багш”-аар бэлтгэн сертификат олгосон. | |
| 96 | | 3. Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах | 2021 - 2024 | | 40 , 90 | Хамтарсан багт зөвлөн туслах ажлыг 3 удаа зохион байгуулж 30 хамтарсан багийн 373 гишүүнийг хамруулж чадавхжуулсан. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас Жинст сумд 870.000, Баянцагаан сумд 2.000.000, Баацагаан сумд 5.000.000, Богд сумд 3.000.000, Бууцагаан сумд 3.000.000, Баянговь сумд 1.000.000, нийт 14.870.000 төгрөгийн санхүүжилт олгосон. Сумдын Хамтарсан багууд сургалт, чуулган, зөвлөгөөн зохион байгуулж, 5841 хүүхэд, 11254 насанд хүрэгчдэд хүрч ажиллалаа. Хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, гишүүдийг чадавхжуулахад аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 12.7 сая төгрөг, Хүүхэд хамгааллын зардал 32.2 сая төгрөг тус тус зарцуулсан. Хүүхдийн тусламжийн 108 утаснаас шилжин ирсэн кейс 139, шийдвэрлэлт 94.0 хувьтай байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 97 | 2.8.7. Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, өрх бүр угийн бичиг хөтөлж, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлсэн байна. | 1. Угийн бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 70 | “Угийн бичиг хөтлөх арга зүй” сургалтыг Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн, хугацаат цэргийн алба хаагч 211 хүн, иргэд, төрийн албан хаагчид 7600, нийт 56 удаагийн сургалтаар 7811 хүн хамрагдсан. Нийт өрхийн 35.1 хувь нь угийн бичиг хөтөлж, өмнөх оноос 10 хувиар өссөн. | |
| 98 | 2.8.8. Сайн дурын үйл ажиллагааг дэмжин ажиллана. Сайн дурын үйл ажиллагаа эрхлэх иргэд, ААН-үүдийг хооронд нь холбох, үнэлэх системийг сайжруулна. | 1. Сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах | 2021 - 2024 | | 100 | Тайлант оны байдаар 10 аж ахуйн нэгж, албан байгууллага 10 сайн дурын ажлыг санаачлан зохион байгуулсныг бүртгэж баталгаажуулсан. Сайн дурын ажилтнаар 127 сурагчийг бэлтгэн, “Малчдаа дэмжих аян”-ы үйл ажиллагааг цахимаар зохион байгуулж 30 байгууллага, 3600 иргэн хандивт нэгдэж, аймгийн Онцгой комисст 31.0 сая төгрөгийн хандив хүлээлгэн өгсөн. Сайн дурын үзэл санааг залуучуудад төлөвшүүлэх зорилготой “Нэг хамт олон -Нэг сайн дурын ажил” нөлөөллийн аян өрнүүлж 30 аж ахуй нэгж, албан байгууллага нийгэмд тустай 50 гаруй төрлийн сайн дурын ажил гүйцэтгэж 3600 иргэн хамрагдсан. Нөлөөллийн аян зохион байгуулснаар аж ахуйн нэгж, байгууллагуудыг нэг хамт олон болгон нийгэмшүүлэх, сайн дурын ажилд иргэд, албан хаагчдыг идэвхжүүлсэн үр дүнтэй ажил болсон. | |
| 3. ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| 99 | 3.1.1. Татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилган | 1. Төрийн бусад байгууллагуудтай хамтран хөрөнгийн татвар төлөгчдийн бүртгэл | 2021 - 2024 | | 1200 | 1.Бүртгэлтэй галт зэсвгийг цагдаагийн нэгдсэн сангийн бүртгэлтэй тулгалт хийж 21 галт зэвсэг шинээр бүртгэж, эзэн холбогдогч нь давхардсан 79 галт зэвсгийн хасалтыг хийсэн. 2.Орон нутагт шинээр баригдаж ашиглалтад орсон зочид буудал, ресторан, худалдаа үйлчилгээний төвийн 11 үл хөдлөх эд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | татвар төлөгчдийг бүрэн хамруулж татварын орлогын суурийг нэмэгдүүлнэ. | мэдээллийн зөрүүг арилган бүртгэлд хамрагдаагүй татвар төлөгчдийг хамруулах | | | | хөрөнгийг шинээр татварын удирдлагын нэгдсэн системд бүртгэж үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын нэхэмжлэхийг үүсгэж, татварын бааз суурийг нэмэгдүүлсэн. 3. 2024 оны жилийн эцсийн мэдээгээр авто тээврийн хэрэгслийн албан татвараар 650.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 726.5 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 111.8 хувь, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараар 658.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 688.7 сая төгрөг төвлөрүүлж, биелэлт 105.0 хувь, галт зэвсгийн албан татвараар 76.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 82.9 сая төгрөг төвлөрүүлж 109.0 хувиар давуулан биелүүлсэн байна. | |
| 100 | | 2. Газрын төлбөр ногдуулалт нэхэмжлэлийг 100% хийж дуусгах, шугам сүлжээнээс газрын төлбөр авч татварт хамрагдаагүй татвар төлөгчдийг бүрэн хамруулж бааз суурийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 420 | 2024 оны 1 дүгээр улиралд 22377 нэгж талбарт 690,9 сая төгрөгийн нэхэмжлэлийг үүсгэсэн. Газар эзэмшигч, өмчлөгч иргэн нас барж өвлөх эрхийн гэрчилгээгээ нээгээгүй, татвар төлөгчөөр бүртгүүлээгүй, хилийн гадна олгогдсон, гэрээний хугацаа дууссан гэх мэт шалтгаантай 2256 нэгж талбарт болон газар дээрх болон доорхи шугам сүлжээний газар нь Газрын удирдлагын нэгдсэн системд гүйцэтгэлийн зургаар орж баталгаажуулаагүй тул газрын төлбөр ногдуулах боломжгүй байна. Газрын кадастрын мэдээллийн системээс дутуу татагдаж, татварын орлогын мэдээтэй зөрсөн зөрчил бүрийг нэг бүрчлэн шалгаж жилийн эцэст 1857 нэгж талбарт нэмж ногдуулалт хийж 24234 нэгж талбарт 773,3 сая төгрөгийн нэхэмжлэлийг үүсгэсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар 767.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 752.4 сая төгрөг буюу 98 хувийн биелэлттэй байна. | |
| 101 | 3.1.2. Аймгийн Засаг даргын нэрэмжит санхүүгийн нэгдсэн шалгалтыг | 1. Эрсдэл өндөртэй төсөвт байгууллагуудад санхүүгийн хяналт шалгалт, үзлэг зохион байгуулах | 2021 - 2024 | | 0 | Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 218 дугаар захирамжаар томилогдсон аймгийн Засаг даргын нэрэмжит хяналт шалгалтын ажлын хэсэг харьяа агентлагуудын нийт 11 албан хаагчид Богд, Жинст, Баянцагаан, Шинэжинст сумын Санхүүгийн албанд очиж ажиллаа. Тус ажлын хүрээнд санхүүгийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн тусалж, заавар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сумдад зохион байгуулна. | | | | | зөвлөмжийг хүргүүлж хэрэгжилтийг хангуулж ажиллав. Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний сумдын төсөвт 81 байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэл өндөртэй үнэлэгдсэн 4 сумын 24 байгууллагын санхүүгийн ажиллагаанд хяналт шалгалтыг хийхээр аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын хорооны хурлаар баталсан. Үнэлгээний үр дүнгээр эрсдэл өндөртэй Баянбулаг, Богд, Шинэжинст, Баянцагаан сумдын санхүүгийн үйл ажиллагаанд Засаг даргын нэрэмжит санхүүгийн хяналт шалгалт, санхүүгийн үзлэгийг зохион байгуулж нийт 687,222,453 төгрөгийн зөрчил илрүүлж 140,580,000 төгрөгийн албан шаардлага бичиж, 30,177,061 төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 292,913,714 төгрөгийн зөвлөмж өгч, санхүүгийн үйл ажиллагааны эрсдэлийг 28 хувиар бууруулан, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажиллалаа. Нийт 4 сумын төсөвт 24 байгууллагад санхүүгийн нэгдсэн хяналт шалгалт, үзлэгийг зохион байгуулж эрсдэл өндөртэй байгууллагын тоог 9 болгож бууруулан төсвийн үр ашгийг 170,757,061 төгрөгөөр нэмэгдүүлсэн. | |
| 102 | | 2. Аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, алдаа дүгнэлтийг байгууллага тус бүр дээр хэлэлцүүлж, залруулах арга хэмжээ авах | 2021 - 2024 | | 0 | Аймгийн засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн авч цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажилласан. Баянхонгор аймаг дахь Төрийн аудитаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт нь 2024 оны 12-р сарын 20-ний өдрийн байдлаар 89.5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. | |
| 103 | 3.1.3. Хуримтлалтай хонгорчууд | 1. Хуримтлалын бүлгийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 143 | Нийт 10 сумын 110 хуримтлалын бүлэг зохион байгууллалтад орж үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 69.079 хадгаламж эзэмшигчдийн дансанд 210.6 тэрбум төгрөг байршиж байгаа бөгөөд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | | | | | урьд оны эцсээс 19,0 хувиар буюу 29.9 тэрбум төгргөөөр өссөн үзүүлэлттэй байгаа нь иргэд олон нийтийн санхүүгийн мэдлэг нэмэгдсний илэрхийлэл юм. | |
| 104 | | 2. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, иргэдэд санхүүгийн мэдлэг олгох | 2021 - 2024 | | 6 | Санхүүгийн боловсрол олгох чиглэлээр Монголбанк, арилжааны банкнууд, Баянхонгор аймгийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран 2024 онд нийт 190 орчим удаагийн сургалтаар 127,773 иргэдэд танхим, цахим хэлбэрээр 677 мэдээ, мэдээллийг 185,908 хүн хүргэн ажилласан байна. | |
| 105 | 3.1.4. Тунгалаг санхүү хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1. “Жишиг санхүүгийн алба” үзүүлэх сургалт” зохион байгуулах | 2021 - 2024 | | 18 | 2024 оны 7/1458 дугаартай албан бичгийн дагуу 20 сумын санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн нарыг хуваарийн дагуу Санхүү, төрийн сангийн хэлтэст дуудаж "Жишиг санхүгийн алба" үзүүлэх сургууль зохион байгууллаа, Тус сумдын Эрхийн бүртгэлийн санд бүртгэлтэй дансны баримт бичгийн тохиргоо, баталгаажуулах албан тушаалтны хавсралтын үнэн зөв байдал, төрийн сангийн удирдлагын цахим системд хийгдсэн гүйлгээнд анхан шатны баримтын бүрдүүлэлт зэрэгт хяналт хийж, зөвлөмж өгч ажиллав. Илэрсэн алдаа зөрчлийг ажлын 2 өдөрт багтаан залруулж чадсан нь гол үр дүн байлаа. Ажлын байрны дадлага, сургалт зөвлөгөөг ганцаарчлан өгсөн, ажил сайжруулах талаар ярилцлагын цаг гарган хэлтсийн даргатай зөвлөлдсөн ач холбогдол, үр дүнтэй ажил болсон. | |
| 106 | | 2. Аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд санхүүгийн тайлагналт, баталгаажуулалтын хувийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 85 | Нийт тайлан ирүүлэх 2023 оны 1717 аж ахуйн нэгж байгууллагаас тайлан ирүүлээгүй 309 аж ахуйн нэгж, 1408 аж ахуйн нэгж байгууллага тайлан ирүүлж, тайлангийн ирц 82 хувьтай байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 107 | | 3. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд ашиглаж болох энгийн ойлгомжтой санхүүгийн тайлангийн программыг нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 60 | Шинээр үүсэн байгуулагдаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад Сангийн яамны зөвшөөрөлтэй санхүүгийн программ ашиглахыг зөвлөж, арга зүйн зөвлөгөө өгч, аж ахуйн нэгж байгууллагуудыг төрөлжүүлэн сургалт зохион байгуулан программын судалгаа авч нийт 223 аж ахуйн нэгж байгууллага хамрагдав | |
| 108 | 3.1.5. Бүртгэлээр тавих хяналтыг нэмэгдүүлэх, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулна. | 1. Төсөвт байгууллагуудын дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн ашиглалт, хамгаалалттай холбоотой зөрчлийг арилгах | 2021 - 2024 | | 0 | 2023 оны санхүүгийн тайлангаар 784 нэрийн 13,3 тэрбум төгрөгийн тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна. Орон нутгийн өмчит эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг тооллогоор илэрсэн 90 тээврийн хэрэгсэл зөрчилтэй байснаас 52 тээврийн хэрэгслийг авто тээврийн нэгдсэн сангаас хасуулсан. Мөн маргаантай 1 тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулан балансаас балансад шилжүүлж, зөрчлийг 70 хувиар бууруулсан. Дутагдуулсан Богд сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй гинжин тракторыг хуулийн байгууллагад шилжүүлсэн бөгөөд шийдвэр гараагүй шалгагдаж байна. 2024 онд төсөвт байгууллага шинээр худалдан авсан 69 тээврийн хэрэгслийг нэр дээр шилжүүлж, улсын дугаар олгуулахаар албан бичиг Авто тээврийн төвд хүргүүлсэн. | |
| 109 | | 2. Бүртгэлээр тавих хяналтыг нэмэгдүүлэх, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, коджуулах | 2021 - 2024 | | 15 | Аймгийн Засаг даргын 2024 оны А/218 дугаар захирамжийн дагуу нэгдсэн шалгалтаар Богд, Баянцагаан сумын 12 төсөвт байгууллагын 17,2 тэрбум төгрөгийн хөрөнгийг нүд үзэн тоолж, 87,8 сая төгрөгийн хөрөнгийн зөрчил илрүүлснийг залруулах 21 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн. Жаргалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв, Оточ номгон өрхийн эрүүл мэндийн төв, Соёл, урлагийн газар, Цагдаагийн газар, Баянхонгор Тохижилт үйлчилгээ ААТҮГазрын Баянхонгор эрчим хүч цахилгаан түгээх ХХК, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын эд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөрөнгөд хяналтын тооллого хийж, нийт 38,684,6 сая төгрөгийн хөрөнгийг нүд үзэн тоолж, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг өгч ажилласан. 2024 онд төсөвт болон орон нутгийн өмчит нийтдээ 19 байгууллагын эд хөрөнгийг бүрэн коджуулсан. | |
| 110 | 3.2.1. Төсөл хөтөлбөрүүдийг судалж гадаад харилцааг идэвхижүүлж оновчтой хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана. | 1. Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх санал хүргүүлэх, уулзалт зохион байгуулах | 2021 - 2024 | | 1 | Гадаад харилцааны яамны Олон улсын хамтын ажиллагааны газарт сум, байгууллагуудаас ирүүлсэн 21 төслийн саналыг хүргүүлж, Хүүхдийг ивээх сан Япон улсын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр "Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төсөл Баянхонгор аймагт 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаанд шинээр хэрэгжиж байна. Тайлант онд ХАА, байгаль орчин, хүүхдийн хөгжил, эрүүл мэндийн боловсролын салбарын 7 төсөл хөтөлбөр Баянхонгор аймагт хэрэгжиж байна. | |
| 111 | 3.3.1. Орон нутагт уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдтэй байгуулах гэрээнд төр, иргэдийн оролцоог хангаж ажиллана. | 1. Ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн гэрээний хэрэгжилтийг хангуулах | 2021 - 2024 | | 75 | Ашигт малтмалын тухай хуулийн дагуу 2021 онд уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 15 аж ахуйн нэгжтэй 9,130.0 сая төгрөг, 2022 онд уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 12 аж ахуйн нэгжтэй 3,570.0 сая төгрөг, 2023 онд уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 9 аж ахуйн нэгжтэй 2,990.0 сая төгрөг, 2024 онд уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 7 аж ахуйн нэгжтэй 2,690.0 сая төгрөг нийт 18 аж ахуйн нэгжтэй 18,380.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын гэрээг байгуулсан байна. Үүнээс 11,415.0 сая төгрөг буюу хөрөнгө оруулалтын 62,1% аймгийн төсөвт, 6,965.0 сая төгрөг буюу 37,9% холбогдох сумдын төсөвт төвлөрөхөөр байгуулагдсан. Гэрээг олон нийтэд мэдээлж, гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор www.shilendans.gov.mn, www.bayanhongor.gov.mn цахим хуудсуудад тухай бүр байршуулсан. Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2022 онд 2020- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2021 онд уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс орон нутагт төвлөрсөн орлого, гэрээний хэрэгжилтэд, 2024 онд уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс орон нутагт төвлөрсөн орлого, гэрээний хэрэгжилтэд тус тус гүйцэтгэлийн аудит хийгдсэн ба 14 аж ахуйн нэгжийн гэрээг дунджаар 95,5%-тай дүгнэж, гэрээний хэрэгжилтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 2024 оны 1а/732 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |
| 112 | 3.3.2. "Хариуцлагатай уул уурхай-Эдийн засгийн үндэс" сургалтыг уул уурхай бүхий сумдын иргэдэд зохион байгуулна. | 1. Уул уурхай бүхий сумдын иргэдэд сургалт зохион байгуулах | 2021 - 2024 | | 11 | "Хариуцлагатай уул уурхай" сургалтыг уул уурхай бүхий Өлзийт, Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан, Заг, Галуут сумдын иргэдэд 2023 онд зохион байгуулсан. Сургалтаар "Эрдэс баялгийн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл ба төрөөс баримталж буй бодлого", "Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт", "Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс 2021-2022 онд төвлөрсөн хандив дэмжлэг", "Хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагааг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч буй арга хэмжээ", "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам", "Уул уурхай дахь байгаль орчны салбарын бодлого" зэрэг нийт 6 сэдвээр 6 сумын 200 гаруй иргэдэд мэдлэг олгож аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлсэн. Энэ оны 03 дугаар сарын 17, 18, 12 дугаар сарын 22-ны өдрүүдэд аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан уул уурхай бүхий Шинэжинст, Баян-Өндөр сумын 200 гаруй иргэдтэй уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. | |
| 113 | 3.3.3. "Баялагийн сан" байгуулж, олон нийтийн хяналтан дор байгаль хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн | 1. Баялагын сан байгуулж, төсөл хөтөлбөрийг иргэдийн оролцоотойгооор хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 20 | "Баянхонгор сан"-г байгуулж, сан бүрдүүлэх захиран зарцуулах, түүнд хяналт тавих журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 8/07 дугаар тогтоолоор баталсан. Тус журмыг Хууль зүй, дотоод хэргийн яам руу хүргүүлсэн. Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан ба нэмэлт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжтэй төсөл хөтөлбөрийг иргэдийн оролцоотойгоор хийж хэрэгжүүлнэ. | | | | | өөрчлөлтийн дагуу уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний дагуу 3,515.0 сая төгрөгийн хандивыг орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлсэн. Иргэдээс ирүүлсэн саналын дагуу орон нутгийн хөгжлийн сангийн 10,664.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 91 арга хэмжээ, 12,107.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 79 төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн. | |
| 114 | 3.3.4. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг бичил уурхай эрхлэгчдийг дэмжиж ажиллана. | 1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч нөхөрлөл, хоршоо болон иргэдэд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулах. | 2021 - 2024 | | 25 | “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн дэд ажлын хэсэг уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн хууль бусаар ашигт малтмал олборлохоос урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтыг тогтмол зохион байгуулсан. Мөн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, орхигдсон газруудад техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг зохион байгуулав. Байгаль орчны газар, Цагдаагийн газрын Экологийн албатай хамтран хууль бус ашигт малтмал олборлохоос урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулсны үр дүнд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 2021 онд 43, 2022 онд 17, 2023 онд 12, 2024 онд 7 болон буурсан эерэг үзүүлэлттэй байна. | |
| 115 | | 2. Бичил уурхай эрхлэгчдийг хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлж, хяналт тавих | 2021 - 2023 | | 2 | Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох" журам батлагдаж бичил уурхай эрхлэгчид хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа эрхлэх боломжтой болсон. Журмын дагуу 2023 онд Бууцагаан суманд 1, Бөмбөгөр суманд 3 талбайд дүгнэлт гарсан ба энэ онд үйл ажиллагаа явуулаагүй. Хууль бусаар ашигт малтмал эрэн хайсан 125 зөрчлийн хэргийг бүртгэж, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн. Өмнөх онтой | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | харьцуулахад энэ төрлийн зөрчил 10 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна. | |
| 116 | 3.3.5. Эвдэрсэн газрын тооллого судалгаан дээр үндэслэн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана. | 1. Аймгийн хэмжээний эвдэрсэн газрын тооллого, судалгаанд үндэслэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах | 2021 - 2024 | | 20 | Аймгийн Засаг даргын 2023 оны “Эвдэрсэн газрын хяналтын тооллого зохион байгуулах тухай” А/317 дугаар захирамжийн дагуу хяналтын тооллогыг 2023 оны 06 дугаар сарын 10-24-ний өдрүүдэд зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд нийт 17 сумын 224 нэгж талбарт 729,4 га эвдрэлд орсон байна. Үүнээс 2021-2022 онд 174,4 га, 2023 онд 43,98 га, 2024 онд 68,86 га талбайд нийт 287,24 га талбайд нөхөн сэргээлтийг хийсэн буюу нийт эвдэрч орхигдсон талбайн 39 хувьд нь техникийн нөхөн сэргээлтийг хийсэн үр дүнтэй байна. | |
| 117 | 3.4.1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборыг бий болгоно. | 1. Хөдөө аж ахуйн кластерийн хүрээнд шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлж, үйлдвэрлэлийг байгуулах | 2021 - 2024 | | | Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах Нийт төсөвт өртөг 13,755 тэрбум төгрөг. - Багц 1 – Ингэний сүүний үйлдвэрлэлийн барилгын ажлыг Базардарь ХХК шалгарч гүйцэтгэхээр 4,853 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. 2024 оны байдлаар барилгын ажлыг барьж, тоног төхөөрөмжийг суурилуулж дууссан. Авах санхүүжилтээс 3,848 тэрбум төгрөгийг авсан. 1,005 тэрбум төгрөгийг 2025 оны төсөвт суулган санхүүжүүлэхээр байна. Багц 2 – Ногоон тэжээлийн үйлдвэрийн ажил буюу өвлийн хүлэмжийн барилгын ажилд Бэнжцэс ХХК шалгарч 2,585 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. Нийт 3 хүлэмж барьж ашиглалтад оруулсан. Багц 3 Мах, ногооны 1000 тн-ы зоорийн барилга, бойны газрын барилгын ажилд Сань-Өндөр ХХК шалгарч 4,869 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж барилгын ажлыг бүрэн дуусган ашиглалтад оруулахад бэлэн болсон ба 3,074 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, 794,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Ингэний сүүний үйлдвэр болон өвлийн хүлэмж, мах ногооны 1000 тн-ны зоорийг хувьчлах асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Багц 4 – Шинэ суурьшлын бүсийн гадна холбооны шугамын ажилд Нью бэст хаус ХХК шалгарсан. Нийт 808 сая төгрөгийн гэрээ байгуулан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлыг бүрэн дуусч хүлээлгэн өгсөн. Үлдэгдэл санхүүжилт байхгүй. Багц 5 – Цэвэрлэх байгууламжийн ажилд Алтай эколос ХХК шалгаран 450 сая төгрөгийн гэрээ байгуулсан ба ажлыг бүрэн дуусган хүлээлгэн өгсөн, үлдэгдэл санхүүжилт байхгүй. Багц 6 – Шинэ суурьшлын бүсийн цахилгааны эх үүсвэрийн ажлыг Эн Ди Эм ХХК шалгаран 1,195 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгэсэн ба үлдэгдэл санхүүжилт байхгүй, ажлыг бүрэн дуусган хүлээлгэн өгсөн. | |
| 118 | 3.4.2. Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ. | 1. Хөдөө аж ахуйн загвар хоршоо байгуулах | 2022 - 2024 | | 1 | Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний дэд хөтөлбөр 3-ыг 98.89 хувьтай хэрэгжүүлж ажилласан. Монгол Улсын Засгийн газраас "Шинэ хоршоо чинээлэг малчин" хөдөлгөөний танилцуулга мэдээлэл, зээл олголтын мэдээг 20 сумд 66 хүний бүрэлдэхүүнтэй 20 ажлын хэсэг өгч ажилласан. Ажлын хэсгүүд сумдын малчид, хоршоологчдод хоршоо байгуулах, хоршиж ажиллах мөн чанар төрөөс олгогдох хөнгөлөлттэй зээлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. Энэхүү ажлын хүрээнд 20 сумын 12951 малчин, хоршооны төлөөлөлд мэдээлэл хүргээд байна. Тайлант оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар арилжааны банкуудаар дамжуулан 256 хоршооны 1277 малчдад 36.9 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. Аймгийн хэмжээнд Францын Улсын хөрөнгө оруулалттай AVSF төслийн хүрээнд байгуулагдсан 7 хоршооны "Ээлтэй баялаг" дундын хоршоо, BODIOS группын Баянговь сумын Цагаан ямаат Баянговь зэрэг хоршоонууд нь Загвар болон хөгжиж үйл ажиллагаагаа тэлсээр байна. | |
| 119 | 3.5.1. “Бизнес инкубатор”-ийн бодлогыг эрчимжүүлж, гарааны бизнесийг | 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас гарааны бизнес | 2022 - 2024 | | 30 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас нийт 23 аж ахуй нэгжид 2,6 тэрбум төгрөгийн зээл олгосон бол орон нутгийн дэмжлэгтэйгээр Баянхонгор үйлдвэржилт, хөгжлийн корпорациар дамжуулан 108 иргэн, аж ахуй нэгжид 1,3 тэрбум төгрөгийн зээл олгон 107 байнгын ажлын байр нэмэгдсэн. Мөн 2023 онд олон улсын BEST хөтөлбөрөөс 4 иргэн, ААН-д 34.4 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгож хамтарч | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дэмжиж бойжуулна. | эрхлэгчдийг дэмжиж, бойжуулах | | | | ажилласан. Хоршоог хөгжүүлэх сангаас 2023-2024 онд нийт 19 сумын 55 хоршоонд 1,4 тэрбум төгрөгийн зээл олгож 49 ажлын байрыг хадгалж, шинээр 40 ажлын байрыг нэмэгдүүлсэн байна. 2024 онд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" хөдөлгөөний хүрээнд 256 хоршооны 1277 малчин 36.9 тэрбум төгрөгийн зээл авсан. Эдгээр эх үүсвэртэй зээлүүдэд аймгийн хэмжээнд шинээр 7 жижиг үйлдвэр бий болж, 14 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаагаа өргөжүүлснээр шинээр байнгын 71 ажлын байр бий болсон. Үйлдвэр үйлчилгээний ажилсаг төвд 27 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж 98 байнгын ажлын байрыг, ахуй үйлчилгээний төвд 16 түрээслэгч үйл ажиллагаа явуулж 39 ажлын байрыг хадгалж гарааны бизнес эрхэлэгчдийг дэмжиж, бойжуулж байна. | |
| 120 | 3.5.2. Хүн амын хүнсний хэрэгцээний нөөцийн махыг хувийн хэвшлүүдээр бэлдүүлж дэмжлэг олгоно. | 1. Махны нөөцийг бүрдүүлж, үнийг тогтворжуулах | 2021 - 2024 | | 200 | Хүн амын махны нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд жил бүр 150-200 тн махны нөөц бүрдүүлэн Баянхонгор хотын 13 дэлгүүр, цэгээр жижиглэнгээр болон гулуузаар хөнгөлөлттэй үнээр худалдаалдаг. Нөөцийн махны үнийн хувьд ямаа /1кг/ 7000, хонь /1кг/ 8500, үхэр /1кг/ 10500 төгрөгөөр тус тус худалдаалан, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй нөхцөлийг ханган ажиллаж, зах зээлийн үнээс 1000-1500 төгрөгийн доогуур ханштайгаар иргэдэд хүргэдэг. 2024 оны хувьд орон нутгийн төсвөөс махны нөөц бүрдүүлэхээр баталсан хөрөнгийг өвөлжилтийн нөхцөл хүндэрсэнтэй холбоотойгоор өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэхэд зарцуулж хувийн ААН болох "Дэвжих өлзий хишиг" ХХК нь нөөцөд 10 тн үхэр, 4 тн ямаа, Баянхонгор констракшны "Мах март" ХХК нь нөөцөд 300 тн махыг тус тус бэлтгэж иргэдийн хэрэгцээнд нийлүүлсэн. Худалдаанд ямаа-6000, хонь-10000, үхэр-12500 төгрөгийн ханштай байгааг зах зээлийн ханштай харьцуулахад кг тутам 3000-5000 төгрөгийн хямд борлуулагдсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 121 | 3.6.1. Мал сүргийн шилэн сонголтын ажлыг сайжруулж, малын ашиг шимийн түвшинг нэмэгдүүлж, малчдын мэдлэгийг дээшлүүлнэ. | 1. Малын шилэн сонголтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулж орон нутгийн онцлогт тохирсон үүлдэр, омгийн малыг сайжруулагчаар ашиглан ашиг шимийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 80 | Манай аймаг хонин сүргийг Баянбулаг хониор, ямаан сүргийг Бөмбөгөрийн улаан омог, Залаажинст-Эдрэн үүлдрээр сайжруулах, Тэмээн сүргийг Ламын гэгээний улаан тэмээ үржлийн хэсгээр, адуу, үхрийг өөр дотор нь сонгон үржүүлэх бодлого барьж ажиллаж байна. Сүргийн бүтцэд хонин сүргийн эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилгоор монгол оронд дасан зохицсон баталгаажсан Баяд үүлдрийн 100 толгой 2-3 настай эм хонь худалдан авч цөм сүргийн нэгжийг Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын харьяанд бий болгосон. 2023 онд Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын санаачилгаар хэрэгжүүлж байгаа Малын чанар сайжруулах ’’ Шинэ хөдөө’’ төслийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянбулаг омгийн өсвөр хээлтүүлэгч-500, хээлтэгч-400, Сэлэнгэ үүлдрийн Бухан бяруу-20, үржлийн хээлтэгч -43, Сарлагийн бухан бяруу-6 авч сумдад хүлээлгэн өгсөн. 2021-2024 онд улс, аймаг, сум орон нутгийн хөрөнгөөр нийт 127,0 мянган толгой малд үзлэг ангилалт хийж ашиг, шимийн үзүүлэлтийг тодорхойлсон. Ангилалтаар амьдын жингийн үзүүлэлт аймгийн дунджаар өсвөр хуц 33 кг, бүдүүн хуц 55 кг, өсвөр ухна 22 кг, бүдүүн ухна 41 кг амьдын жинтэй байгаа нь тухайн төрлийн малын амьдын жингийн стандартыг хангаж байна. | |
| 122 | | 2. Бог малын хээлтүүлэгчийг мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагын хяналтад ялган төвлөрүүлэх | 2021 - 2024 | | 80 | Аймгийн хэмжээнд өнгөрсөн онд мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний 12 нэгж тоологдсон бөгөөд энэ онд “Элит түмэн тэмээ” ХХК шинээр нэмэгдэн 13 аж ахуйн нэгж бүртгэгдсэн. Нийт 20 сумын 55 багийн 55 суурьт хуц 4465, ухна 7479 бүгд 11944 буюу нийт хээлтүүлэгчийн 70.8 хувийг ялган төвлөрүүлсэн. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ялган төвлөрүүлэлт 8.6 хувиар буурсан байна. Энэ нь цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан өвөлжилт хаваржилт хүндрэх эрсдэлийг тооцоолон Улаанбаатар хот болон бусад 16 аймагт 110 өрхийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 26.1 мянган мал оторлож эдгээр өрхүүдийн хээлтүүлэгч ялган төвлөрүүлэлтэд хамрагдаагүй. | |
| 123 | | 3. Малчдын мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлж, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах | 2022 - 2024 | | 100 | 2022 онд Сумын Засаг даргын тамгын газар, Хөдөө аж ахуйн тасгаар дамжуулан 20 сумын давхардсан тоогоор 5858 малчинд салбарын болон цаг үеийн мэдээлэл сургалт хүргэж, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан. Мөн 9,10,11,12 дугаар ангийн 890 гаруй сурагчдад малын эмч мэргэжил болон зорилгодоо хэрхэн хүрэх, талаар сургалтыг амжилттай зохион байгуулсан. 2023 онд НҮБ-тай хамтран нийт 13 сумын 390 малчин өрхөд ядарч доройтсон малыг хэрхэн тэнхрүүлэх, бэлчээрийг хэрхэн зүй зохистой ашиглах, малыг хэрхэн тэжээх зэрэг сэдвээр сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. Мөн улс, аймгийн хэмжээнд анх удаа 20 сумын 105 багийн мянган малчныг нэг дор цуглуулж "Эрдэнэт сүргийн эзэд-1000" малчдын чуулга уулзалтыг амжилттай зохион байгуулж урлаг, спортын төрлөөр нөхөрсөг тэмцээн амжилттай зохион байгууллаа. Чуулганы үеэр урлагийн 11 төрөл, спортын 7 төрлөөр урлаг, спортын наадмыг амжилттай зохион байгуулж, оролцогчдын ур чадвар, оролцооны байдал, сахилга хариуцлагыг харгалзан дүнг нэгтэн шилдгүүдийг тодрууллаа. Шилдгийн шилдэг сумаар Баянлиг сум шалгарч 20,0 сая₮, хоёрдугаар байранд Бууцагаан сум шалгарч - 15,0 сая₮, гуравдугаар байранд Бөмбөгөр сум шалгарч – 10,0 сая₮, дөрөвдүгээр байранд Баянговь сум шалгарч – 5,0 сая₮, тавдугаар байранд Хүрээмарал сум шалгарч – 5,0 сая₮-ийг тус тус гардан авлаа. Аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хуралтай хамтарч "Төлөөлөгчийн нэг өдөр" арга хэмжээний үеэр 20 сумын 10,000 гаруй малчдад цаг үеийн мэдээ, мэдээллийг хүргэх ажлыг амжилттай зохион байгууллаа. 2024 онд иргэд олон нийтэд чиглэсэн 36 сэдвийн хүрээнд цахим болон танхимын хэлбэрээр сургалт, мэдээлэл, зөвлөн туслах, дадлагажуулах арга | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээг зохион байгуулж, 13191 хүнийг хамруулж, улсын болон төсөл хөтөлбөрийн төсвөөс 73.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс малчдын мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлээр танхимын 6 сургалтаар 7993 иргэнийг хамруулсан. | |
| 124 | 3.6.2. Мал эмнэлгийн чанар хүртээмжийг сайжруулж, эрүүл бүс статусаа бататгана. | 1. Малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, угаалга туулгалтад мал сүргийг хамруулах | 2021 - 2024 | | 2 | 2021-2024 онд орон нутагт зонхилон гардаг мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 6,1 сая толгой малыг хамруулсан. Мөн Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх масс дархлаажуулалтад нийт 1.9 сая толгой мал, амьтныг хамруулсан. Дээрх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулснаар мал, амьтны гоц халдварт өвчингүй, ногоон бүс болсон. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 20 сумын 8,4 сая толгой малыг хамруулж малын халдварт өвчний гаралт, тархалт 56 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | |
| 125 | | 2. Мал эмнэлгийн бүртгэл мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулж, мал болон малын гаралтай бүтээгдэхүүнд хяналт тавих | 2021 - 2024 | | 8000 | 2020 оноос хойш Мал эмнэлгийн нэгдсэн системд мал эмнэлгийн үйлчилгээний 51 нэгж малын гаралтай мах, түүхий эд бүтээгдэхүүн болон шаардлагатай борлуулах амьд мал, амьтныг зургаар баталгаажуулан замын дамжин өнгөрөх улсын мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын пост, Өвөрхангай аймгийн “Нарийн тээлийн пост, Төв аймгийн Лүнгийн пост, Сонгино хайрхан дүүргийн 22 товчооны” хяналтын постуудаар шалгуулж Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 17–ны өдрийн 43-р тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2021-2024 онд мал эмнэлгийн нэгдсэн системд малчид, мал бүхий иргэдийн хүсэлтээр нийт 25972 гарал үүслийн гэрчилгээ баталгаажуулж үүнээс 2024 онд 6677 гэрчилгээ баталгаажуулж ажилласан. Уг системээр дамжуулан мал, малын гаралтай бүтээгдэхүүний тээвэрлэлт, шилжилт хөдөлгөөн, отор нүүдэл болон малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд хяналт тавьж ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 126 | | 3. Гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор шаардлагатай эм, бэлдмэл, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх | 2021 - 2024 | | 20 | Аймгийн хэмжээнд 2021-2024 онд халдвар хамгааллын иж бүрэн хувцас 800 ширхэг, нүдний шил 800ш, маск 800ш, хормогч 800ш, улавч 800ш, халдваргүйтгэлийн бодис болох Hi-cop 600кг, Han-con 250кг, гипохлорт кальци 200кг, супер килл 20кг, спирт76 градус 10л, спирт 96 градус 80л бэлтгэн нөөцийг бүрдүүлж ажилласан. Аймгийн мал эмнэлгийн газарт халдваргүйтгэлийн дук авто машин 1, хөдөөгийн 19 сумд тус бүр 1 нийт 19 дүк машин халдваргүйтгэлийн ажлыг гүйцэтгэж байна. 20 сумын Мал эмнэлгийн тасгийн албан хаагч нарт шуурхай дуудлага үйлчилгээний 20 мотоцикл олгож мал эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулсан. | |
| 127 | | 4. Шаардлагатай автомашин, зөөврийн тоног төхөөрөмжийг авч мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах | 2021 | | | Аймгийн мал эмнэлгийн газарт халдвартгүйтгэлийн дук авто машин 1, хөдөөгийн 19 сумд тус бүр 1 нийт 19 дүк машин халдваргүйтгэлийн ажлыг гүйцэтгэж байна. байна. 20 сумын Мал эмнэлгийн тасгийн албан хаагч нарт шуурхай дуудлага үйлчилгээний 20 мотоцикл олгож мал эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулсан. | |
| 128 | 3.6.3. Бэлчээр менежментийг сайжруулах зорилгоор шаардлагатай цэгүүдэд уст цэг шинээр гаргах, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулна. | 1. Худаг уст цэг гаргах, шаардлагатай цэгүүдэд уст цэгийн хайгуул хийх | 2021 - 2024 | | 5 | 2021-2024 онд улсын төсвийн хөрөнгөөр 8, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 14, гадаадын төсөл хөтөлбөрөөр 1, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 32, сумдын малчид өөрсдийн санаачилгаар 6 сум нийт 61 худаг шинээр гаргаж, засварласан нь 91,5 мянган га талбай бэлчээрийг усжуулж, 100 гаруй өрхийн 124,0 мянган толгой мал, амьтан усаар хангагдлаа. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр уст цэгийн хайгуулыг 20 сумын 61 цэгт хийсэн. | |
| 129 | | 2. Аймгийн хэмжээнд дэвшилтэт аргаар | 2021 - 2024 | | 20 | 2021-2024 онд улсын төсвийн 601,4 сая, аймгийн ОНХС-ийн 28,0 сая, сумын ОНХС-ийн 91,7 сая төгрөгийн хөрөнгөөр Өлзийт, Эрдэнэцогт, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг, Гурванбулаг, Заг, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх | | | | Жаргалант, Баян-Овоо, Галуут сумдын нийт 170,8 мянган га талбайд энгийн болон микробиологийн аргаар бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулж 90-92,3%-ийн үр дүнтэйгээр дүгнүүлсэн. | |
| 130 | 3.6.4. Аймаг, сумдын аюулгүй нөөцийн өвс тэжээлийг зохих түвшинд бэлтгэнэ. | 1. Аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг зохих түвшинд бэлтгэх | 2021 - 2024 | | 200 , 50 | 2021 онд аймгийн аюулгүйн нөөцөд 120 тн ногоон тэжээл, 35 тн хорголжин тэжээл, 2022 онд аймгийн аюулгүйн нөөцөд 300 тн өвс, 95 тн хорголжин, улаан хивэг, 2023-2024 онд аймгийн аюулгүйн нөөцөд 500 тн өвс, 36,6 тн хивэг нөөцөлж эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан. | |
| 131 | 3.6.5. Техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэн газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүн амын төмс, хүнсний ногооны хангамжийг өсгөнө. | 1. Стандартын шаардлага хангасан 1000тн-ы төмс, хүнсний ногоо, махны зоорьтой болох | 2021 - 2023 | | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Мах, ногооны 1000 тн-ийн зоорь баригдан ашиглалтад ороход бэлэн болсон. Энэхүү зоорь нь 6 павилон бүхий, гүн хөлдөөх хэсэгтэй, смарт хөргүүртэй орчин үеийн технологийн шийдэлтэй аймгийн газар тариалан эрхлэгчид, малчид зориулалтын стандарт зооринд мах, ногоо, түүхий эд удаан хугацаанд хадгалах боломж бүрдсэн. Дээрхи зоорийг хувьчлах ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. | |
| 132 | | 2. Тариалалтад ашиглах техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, дундын үйлчилгээний нэгж байгуулах | 2022 - 2024 | | 100 | 2021 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын дэмжлэгээр 32 м2-ийн 5 ширхэг хүлэмж, төмс хүнсний ногооны иж бүрэн мотоболок, төмс хураагч зэрэг техник тоног төхөөрөмжийг хүлээн авч Хот тохижилт ОНӨААТҮГазарт олгосон. 2022 онд Тариалалтад ашиглах техник тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Баянхонгор Политехникийн коллежийн 1, ХХААГ-ын 1, Сум дундын ойн ангийн 2, Өлзийт ХААМСҮТ-ийн 1 нийт 5 трактор тоног төхөөрөмжийг түрээсээр ашиглуулах боломжийг хангаж хамтран ажилласнаар 23 иргэн, аж ахуй нэгжийн нийт 130 га талбайд хөрс боловсруулалтын ажлыг хөнгөлөлттэй үнээр хийж дундын үйлчилгээг үзүүлсэн. 2023 онд Сум дундын ойн анги 130 морины хүчин чадалтай 2 трактор, хадлангийн иж бүрэн 1 тоног төхөөрөмж, Баян-өсөх агро ОНӨАТҮГ 130 морины хүчтэй 2 трактор, хүнсний ногооны иж бүрдэл 1, үр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тарианы үрлэгч 1, Баянхонгор Политехникийн коллеж 110 морины хүчтэй 1 трактор, Жимсний плантацийн төвд 50 морины хүчтэй 1 трактор, 3 агрегат, Хүнс, хөдөө аж ахуйн газарт Шинэ хөдөө төслийн хүрээнд 2 ширхэг төмс хураагч дүүжин машин тус тус шинээр олгож ашигласан. 2024 онд Шинэ хөдөө төслийн нийт 737.8 сая төгрөгийн санхүүжилтээр 15 ширхэг хүлэмжийн иж бүрдэл, 30 морины хүчтэй трактор 6ш, 90 морины хүчтэй трактор 6, мотоболок 6ш, анжис үрлүүр 6ш гэх мэт тоног төхөөрөмжүүдийг авч 13 сумд, "Мал аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж" төслийн 800.0 сая төгрөгийн санхүүжилтээр 80 морины хүчин чадал бүхий 10 трактор тус тус нийлүүлэгдсэн. Ингэснээр 20 сумын хэмжээнд шинэ трактор тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаж тариалалт ургац хураалтын болон хадлан бэлтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх техникийн хангамж 45.6 хувьтай болж өмнөх оны мөн үеийнхээс 20.5 хувиар нэмэгдсэн. Мөн "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ 3, "Сум дундын ойн анги" 3, Хүнс, хөдөө аж ахуйн газар 2, Баянхонгор Политехникийн коллеж 2 нийт 10 иж бүрдэл трактор түрээсээр ажиллаж тариаланчдад дэмжлэг үзүүлсэн. | |
| 133 | | 3. Хүнсний нарийн ногооны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор өвөл, зуны хүлэмжийн парк аж ахуй бий болгох | 2021 - 2024 | | 25 , 0 | 2022-2023 онд өвөл зуны хүлэмж, зоорь агуулахыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хүлэмжийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулснаар 55.5 сая төгрөгийн үнэ бүхий 42 хүлэмжийг 40 гаруй иргэд, аж ахуй нэгж өөрсдийн хөрөнгөөр худалдан авч, компанийн зүгээс 3.5 сая төгрөгийн үнэ бүхий 27 ширхэг усалтын системийг үнэ төлбөргүйгээр олгосон. Мөн ЖДҮХ сангаас Баянхонгор сумд өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах 2 төсөлд, ОНТөсвийн санхүүжилтээр 3 иргэнд хүлэмжийн аж ахуйн төсөл, Хоршоог хөгжүүлэх сангийн 87.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 300 м2-ийн 2 өвлийн хүлэмж байгуулах төслийг тус тус олгож дэмжлэг үзүүлсэн.Мөн орон нутгийн төсвийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөрөнгө оруулалтаар 60 ширхэг 6*10 хэмжээтэй зуны нийлэг хальсан хүлэмж, ХХААХҮЯ-ны хөрөнгө оруулалтаар 6*10 хэмжээтэй 21, 4*8 хэмжээтэй 21 нийт 42 ширхэг хүлэмжийг нийлүүлэн 100 хүлэмжийн агропаркийг байгуулах ажил амжилттай хэрэгжсэн. Нийт 6060 м,кв талбайд 50 иргэн тариалалт хийсэн. 2024 онд хүн амын хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн кластер төлсийн хүрээнд 2400 м2 бүхий 3 улирлын хүлэмжийг барьж ашиглалтад оруулсан тариаланч иргэдэд нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмаар олгож менежментийн гэрээгээр ашиглуулахаар шийдвэрлэн зар мэдээллийг түгээн ажиллаж байна. Хөдөө аж ахуйн кластер-Малын тэжээл дэд төслийн хүрээнд 500 м2 талбайтай 4 ширхэг 3 улирлын хүлэмжийг барьж байгуулах ажлыг эхлүүлж барилгын ажлыг хийж байна. Зуны хүлэмжийн цогцолбор аж ахуйг нэмэгдүүлэх чиглэлээр анхаарч "Шинэ хөдөө" төслийн санхүүжилтээр 15 сумд тус бүр нь 120 м2 талбайтай нийлэг хальсан хүлэмжийг олгож тариалалтад ашиглаж байна. Мөн Хятад улсын Гансу мужийн хамтын ажиллагааны хүрээнд Баянхонгор сумд байгуулагдсан нийт 220 м.кв талбай бүхий 2 ширхэг 3 улирлын нарлаг хүлэмжийг “Цэвэр хөрсний үр шим” ТББ хариуцан тариалалт хийж 3 тн өргөст хэмхийг хураан авч борлуулалтад гаргасан. | |
| 134 | | 4. Аймгийн хэмжээний услалтын системүүдээс бага зардлаар боломжит үр ашиг өгөх услалтын системийг | 2021 | | 80 , 20 | Аймгийн хэмжээнд бүртгэлтэй 9 сумын 12 услалтын систем байдаг бөгөөд нийт төслийн хүчин чадал нь 732 га талбайг услах боломжтой хэдий ч эвдрэл гэмтлийн улмаас энэ оны эхний хагас жилийн байдлаар 595.4 га талбайд төмс хүнсний ногоо тэжээлийн ургамал тариалан 81.4 хувийн ашиглалттай явж байна. Бумбатын услалтын системийн зураг төсвийг шинэчлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх ажлын санал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | шинэчлэн засварлаж тариалалтыг нэмэгдүүлэн хангамжийг өсгөх | | | | хүргүүлсэн хэдий ч дэмжигдээгүй хүлээгдсээр байна. Баянцагаан сумын Цагдуултайн услалтын системийг сайжруулан талбайн хөрсний онцлогт тохирсон тэжээлийн ургамал тариалах төслийг хэрэгжүүлж 25 га талбайд тэжээлийн ургамал тариалах үрийн дэмжлэгийг төслөөс олгож, хашаа хамгаалалтыг сэргээн засварлах бэлтгэл ажлыг бүрэн хангаж тариалалтыг эхлүүлээд байна.Хөдөө аж ахуйн кластер төслийн хүрээнд "Баян-Өсөх Агро" ОНӨААТҮГ-т шинэ технологийн ВАРША фомф, өндөр хүчин чадлаар 100 га талбайг услах носос бүхий зөөврийн услалтын систем нийлүүлсэн. Баянлиг сум услалтын системийн нуураа сэргээн засварлаж тариалалтын талбайгаа нэмэгдүүлэн төмс хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалж усалгаагаар хангах нөхцөлийг бүрдүүлснээр инженерийн хийцтэй услалтын системүүдийн ашиглалтыг 15 хувиар нэмэгдүүлсэн. | |
| 135 | 3.7.1. Гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | 1. Эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах | 2021 - 2024 | | 5 , 7000 | Монголын тэмээн сүргийн үүлдэр угсааг сайжруулах, too толгойг өсгөх, тэмээчид, малчдын туршлага солилцуулах, тэдний хөдөлмөрийг үнэлэх, алдаршуулах, гадаад дотоодын жуулчдыг татах зорилгоор "Монголын тэмээн соёл" улсын зөвлөгөөн, баяр наадмыг 2024 оны 01 дүгээр сарын 21, 22, 23-ны өдрүүдэд Баянхонгор хотноо зохион байгуулсан. Уг зөвлөгөөнд УИХ-ын дарга Г.Занданшатар, ХХААХҮЯ-ны төлөөлөл, Монголын тэмээчдийн холбоо, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говь-алтай, Өвөрхангай, Ховд, Завхан, Сүхбаатар, Баян-Өлгий зэрэг нийт 10 аймгийн 240 гаруй тэмээчид оролцон, 100 гаруй тэмээний парад, гурван насны хурдан тэмээний уралдаан, шилмэл буур – шилмэл ингэ, сайхан тэмээтэй ганган хос, буйл зорох – бурантаг томох төрлөөр аваргуудыг тодруулж, тэмээний гаралтай бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, соёл урлагийн цогц арга хэмжээг зохион байгуулсан. Мөн Олон улсын "Торгоны зам" | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | автомашины ралли уралдаан 2024 оны 07 дугаар сарын 08-15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ба манай аймаг олон улсын ралли уралдааныг саадгүй хэвийн үргэлжлэх нөхцлөөр ханган хамтран ажилласан. Тус уралдааны хүрээнд 13 орны 100 гаруй зохион байгуулагч, 900 гаруй тамирчин хүрэлцэн ирсэн. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал, арга хэмжээг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Баянхонгор аймгийн Жинст сумын нутаг Уу булан багийн Хавцгайтын хөндийн Малчин айлыг түшиглэн зохион байгуулав. Сургалтад нийт 20 гаруй гэр бүл, залуучууд оролцсон.Баянхонгор аймагт 2024 онд нийт 51950 жуулчид ирсэн. Үүнээс гадаадын жуулчид 750, нийт 51200 жуулчид ирсэн байна. | |
| 136 | | 2. Аялал жуулчлалын видео контент нэвтрүүлэг бэлтгэх | 2021 - 2023 | | | Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн “Үзэсгэлэнт Баянхонгор-2” төсөл хэрэгжүүлэх тухай А/199 дүгээр захирамжийн дагуу аймгийн түүх соёлын дурсгал, байгалийн үзэсгэлэнт газар, ахуй амьдрал, нийгэм эдийн засаг, спорт, боловсрол, урлаг соёл, ан амьтдыг илэрхийлсэн багц видео-5, Аяллын цуврал нэвтрүүлэг-3, Сумдын онцлог, байгаль, ан амьтан, хууч домог, яриа, тоглоом наадгай, үндэсний уламжлалт эдлэл хэрэглэл хийх өв соёлыг илэрхийлсэн нэвтрүүлэг, Хангайн чиглэлийн хадны сүг зураг сонирхох аялал, Байгаль хамгаалагч, байцаагч нарын хээрийн судалгааны аялал, Байгаль нуурын аялал, Их Богдын аялал, Дугуйн аялал, жийлт, аймгийн Баяр наадам болон аймгийн Түүх соёл, байгалийн үзэсгэлэнт газруудын талаарх видео, зургаар Рийл болон видео хийж олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгууллаа. Нийт 80 орчим контент бэлтгэж хүргэсэн байна.Тус видео контентуудыг "Нээлттэй засаг-Нэг баянхонгор", "Үзэсгэлэн Баянхонгор" пэйж хуудсуудаар дамжуулан иргэдэд сурталчилсан иргэд, олон нийт, зочид төлөөлөгчдөд аймгийг бүрэн сурталчилсан. Хандалтын Дунджаар 1.517.000 үзсэн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна<br><br>Хавсралт : 2 файл | |
| 137 | | 3. Төрийн болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын тохижилтийг үе шаттайгаар хийж гүйцэтгэх | 2021 - 2024 | | 1 | Төрийн болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудыг тохижуулах ажлын хүрээнд 2021 онд Цагаан агуй, Бичигт хад, Галуут сумын Өргөөтийн рашаанд тохижилтын ажил хийгдсэн ба 2022 онд Их Богдын Байгалийн цогцолборт газрын Төрийн тахилгат Их Богд уулын Цонж хайрханыг түшиглэн аялал жуулчлалын отоглох цэг байгуулсан. Энэ онд Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төслийн хүрээнд Шинэжинст сумын нутаг "Тооройтын хөх уул" орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хил хязгаарын тэмдэглэгээг тавих, танилцах самбарыг байрлуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Тэмдэг тэмдэглэгээ хийгдсэнээр ГИДЦГ, Тост, Тосонбумбын нурууны холбоос нутагт хамаарах газрыг тэмдэгжүүлэх, мэдээллээр хангах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, биологийн төрөл зүйл, түүх соёлын дурсгалт зүйлсийн хамгаалалтын үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлэх болно. | |
| 138 | 3.8.1. Аймгийн төв доторх шаардлагатай газруудад хатуу хучилттай авто зам, явган зам, унадаг дугуйн зам барих, нөхөх, нийтийн эзэмшлийн зам талбайд зогсоол, тэмдэг | 1. Шаардлагатай газруудад хатуу хучилттай авто зам шинээр барих, нөхөөс хийх, нийтийн эзэмшлийн зам талбайд зогсоол хийх | 2021 - 2023 | | | 2021 онд Аймгийн замын сангийн 46,0 сая төгрөгийн хөрөнгөөр 880 м2 хатуу хучилттай автозамын нөхөөс, 514,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Есөн эрдэнэ” захын баруун талаас Хонгор хотхоны ар тал хүртэлх 1.2 км замын барилгын ажил, түүнчлэн Эрдэнэцогт-Баянхонгор чиглэлийн 1,7км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг тус тус гүйцэтгэсэн. Шинэ суурьшлын бүсийн 10 км хатуу хучилттай автозамын барилгын ажлын зураг төсвийг хийлгэсэн. 2022 онд 2.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий тухайн онд 1.5 тэрбум төгрөгөөр санхүүжих 15 төсөл арга хэмжээг бүрэн хийж гүйцэтгэсэн. Тухайлбал 1,2 км зам дагуу явган хүний зам, аймгийн төв доторх 1800м2 талбайн нөхөөс, аймгийн төв доторх 1,65 км авто зам, 55 машины авто зогсоол, сургууль орчмын бүсийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэмдэглэгээ хийж автозамын аюулгүй байдлыг хангана. | | | | | стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулах, аймгийн төв доторх уулзвар гарцуудыг засварлах, аймгийн төв доторх асфальтан хучилттай 25000 у/м замд авто замын хэвтээ тэмдэглэгээний засвар, шинэчлэлт хийх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2023 онд аймгийн төв доторх эвдэрсэн зам талбайд замын нөхөөс хийх ажлыг Баянхонгор сумруу эрх шилжүүлж тендэр сонгон шалгаруулалтыг зарлан "Их богд зам" ХХК шалгарч Замын сангийн 80,0 сая төгрөгөөр 1500м2 эвдэрсэн зам талбайд нөхөөсний ажлыг хийж гүйцэтгэсэн . Эрдэнэмандал хайрханы өвөрт авто зогсоол байгуулах ажлыг ОНХСангийн 70,0 сая төгрөгөөр “Унага трейд“ ХХК хийж гүйцэтгэсэн. Тайлант онд Замын сангийн 432.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Урагшлах үе" ХХК Дунд захын уулзвараас доод захын уулзвар хүртэлх 0.5км авто зам, Арван мянгатын 4 замын уулзвараас Цагдаагийн газар хүртэлх 0.45км хатуу хучилттай авто замыг шинэчлэх ажлуудыг хийж гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Мөн 3 дугаар сургуулийн баруун урд уулзвараас Арван мянгатын бетон зам хүртэлх 1.3км автозамын ажлын зураг төсвийг боловсруулж батлуулсан ба 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд Замын сангийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна. | |
| 139 | | 2. Аймгийн төв доторх хатуу хучилттай зам дагуу явган зам, унадаг дугуйн зам барих, шинэчлэх | 2021 - 2023 | | | 2021 онд Оготнотой булгийн зам дагуу 600м унадаг дугуйн зам, 2022 онд Эрүүл мэндийн газрын хойд гэрлэн дохионы уулзвараас аймгийн Засаг даргын Тамгын газар хүртэл 697,8 м2 явган зам, Угалз багийн нийтийн орон сууцны 200 дугаар байрны хойд тал, замын зүүн талаар 139,5 м2 явган зам, 200 дугаар байрнаас Оготнотой булаг хүртэлх замын урд талаар 633,15м2 дугуйн болон явган зам, Хүнс, хөдөө аж ахуйн газрын замын 2 талаар 2100м2 явган зам, “Цэлмэг өглөө” захаас 4 дүгээр цэцэрлэг хүртэл- 900, “Чандмань –Баянхонгор” ХК-с Шөнийн зах хүртэл- 600, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Их богд” авто засвараас “Мэргэжлийн хяналтын газар” хүртэл-700, “Мал эмнэлэг”-ээс Модерингийн уулзвар хүртэл- 1500, Баянхонгор их дэлгүүрээс хүүхдийн Тэмүүжин театр хүртэл- 500 нийт 4200м2 талбайд явган зам барьж ашиглалтад оруулсан. Тоосжилт бууруулах чиглэлээр орон сууцны болон төв зам дагуух шороон хөрсийг эко хавтангаар хучилт хийх ажлыг эхлүүлж “Хаш шоо” -1070, “Голомт банк”-1000, “Эрдэнэт хивс”-530, “Жаргалант парк” баруун тал-3500 нийт 6370м2 талбайд тус тус хийж тоосжилтыг бууруулсан. 2023 онд Онцгой байдлын газрын уулзвараас баруун талын Петровисын уулзвар хүртэлх автозам дагуу явган хүний зам барих ажлыг “Тэнгэрийн уул“ ХХК замын сангийн 219,9.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2816м2 явган замын ажил, мөн энэ чиглэлд замын сангийн 220,0 сая төгрөгөөр "Унага трейд" ХХК 1850м урт дугуйн замын ажлыг хийж гүйцэтгэсэн. Соого сейко сургуулийн арын уулзвараас арван мянгатын хатуу хучилттай зам дагуу явган хүний зам барих ажлыг замын сангийн 222.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Буян аривжих од“ ХХК 2100м2 явган замын ажил, аймгийн төвийн тойрог орчмын тохижилтын ажлыг "Их буянт" ХХК-тай 196,3.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж 2500м2 эко хавтан, 500м2 явган замын ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн. Тайлант онд замын сангийн 145.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хонгор хотхоноос Арван мянгатын 4 замын уулзвар хүртэлх 1095м2 явган замын ажлыг "Буян арвижих од" ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн. | |
| 140 | | 3. Замын хөдөлгөөн зохион байгуулах хурд саарууулагч, замын тэмдэг, | 2021 - 2023 | | | 2021 онд Замын сангийн 21,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Хурд саарууулагч” нийт 16 ширхэг, 50сая төгрөгийн хөрөнгөөр 25000 у/м замд авто замын хэвтээ тэмдэглэгээ, 90 сая төгрөгийн хөрөнгөөр 1800 м2 талбайд замын нөхөөс, 163,0 сая төгрөгийн хөрөнгөөр арван мянгатын 1,2 км авто зам дагуух явган хүний зам | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тэмдэглэл, гэрлэн дохио хийх | | | | барих босоо бордюр, 515,2 сая төгрөгийн хөрөнгөөр Есөн-Эрдэнэ захаас Хонгор хотхон хүртэлх 1,2км хатуу хучилттай замд хучилт, 499,7 сая төгрөгийн хөрөнгөөр Нэгдсэн эмнэлгийн баруун хойд уулзвараас аюулгүйн тойрог хүртэлх 900м хатуу хучилттай авто замын шинэчлэл, 451 сая төгрөгийн хөрөнгөөр Онцгой байдлын газрын уулзвараас Хүнс, хөдөө аж ахуйн газрын уулзвар хүртэлх 750 м талбайд хатуу хучилттай авто зам барих, 40 сая төгрөгийн хөрөнгөөр Оготнотой булаг орчмын тоглоомын талбайн 55 машины зогсоолын газар шорооны ажил, 30,0 сая төгрөгийн хөрөнгөөр Эрдэнэмандал сургуулийн сургууль орчмын бүсийг стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулах зэрэг ажлыг тус тус гүйцэтгэсэн. 2023 онд аймгийн төвд стандартын шаардлага хангасан хурд сааруулагч байршуулах ажлыг Замын сангийн 20,0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр "БМБЖБ" ХХК-тай шууд гэрээ байгуулж Баянхонгор сумын 10 байршилд хурд сааруулагч байршуулсан. Номундалай цогцолбор сургууль, 5-р сургууль болон Номгон сургуулиудын сургууль орчмын бүсийг стандартын дагуу тохижуулах ажлуудыг гүйцэтгэгч компаниуд болох "Гурван мандал хайрхан" ХХК, "Мандай груп" ХХК мөн "Танан хишиг" ХХКомпаниудтай 20.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж гадна зам талбайн тохижилт, явган замын гарц өргөсгөх, босоо тэмдэг тэмдэглэгээ суурьлуулуах, хэвтээ тэмдэглэгээ, хурд сааруулагч байршуулах, гадна камер суурьлуулах зэрэг ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн. Тайлант онд Замын сангийн 82.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Аймгийн төвд 1000м2 хэвтээ тэмдэг тэмдэглэгээ мөн Замын сангийн 20.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 97ш босоо тэмдэг тэмдэглэгээний ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 141 | 3.8.2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор томоохон голуудад төмөр бетонон гүүр барина. | 1. Томоохон голуудад төмөр бетонон гүүр барих | 2021 - 2024 | | 2 | 2021 онд Галуут сумын Мандалын голын 62 у/м төмөр бетон гүүрийн ажлыг “ Эвт уул” ХХК, Галуут сумын Өлзийт голын төмөр бетон гүүрийн ажлыг “Их богд зам “ ХХК тус тус гүйцэтгэн байнгын ашиглалтад оруулсан. 2024 оны жилийн эцсийн байдлаар Богд сумын Түйн гол дээгүүр төмөр бетон гүүр барих ажлын тендэр сонгон шалгаруулалтыг Зам, тээврийн хөгжлийн яамнаас зарлаж "Их богд зам" ХХК шалггарсан бөгөөд тус ажлыг 100% гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн. | | |
| 142 | 3.8.3. Нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, тээврийн нэгдсэн тогтолцоог хангуулж иргэдийг аюулгүй, ая тухтай зорчих нөхцлийг хангана. | 1. Эко автобусыг нэвтрүүлж, аймгийн нийтийн тээвэрт явуулах | 2021 | | | 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн Баянхонгор сумын ИТХ-ын шийдвэрээр Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацаас 6ш цахилгаан автобусыг Цэвэр хот ОНӨААТҮГ-т шилжүүлэн өгсөн. Тус автобуснуудыг балансаас балансад шилжүүлсэн ба шаардлагатай засварын ажил байгаа тул хараахан тээвэрлэлт явуулж эхлээгүй байна. | | |
| 143 | 3.8.4. Аймгийн Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг олон улсын | 1. Аймгийн Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг олон улсын стандартад хүргэх | 2021 - 2024 | | 2 | "Aeromongolia" ХХК нь 2021 оны байдлаар долоо хоногт 1 удаа нислэг үйлддэг байсан ба Улаанбаатар-Баянхонгор, Баянхонгор-Улаанбаатар чиглэлд 24 нислэг үйлдсэн. Нисэх буудлын хэмжээнд нийт 54 нислэг хийсэн байна. Коронавирусын цар тахал болон нисэх буудлын барилгын засвартай холбоотойгоор 2021 оны 6-р сард нислэгийн үйл ажиллагааг зогсоосон. 2022 онд шатахууны нэмэгдэлтэй холбоотойгоор нислэг хийгээгүй. 2024 оны жилийн эцсийн байдлаар Баянхонгор аймгийн Нисэх буудлын аэродромын зорчих хэсгийн 21800м2 талбайг засварлах ажил дээр гүйцэтгэгч сонгон шалгаруулах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | стандартад хүргэнэ. | | | | | тендэр зарлаж "Их богд зам" ХХК шалгарч аэродромын нөхөөсний ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн. | |
| 144 | 3.9.1. Төвлөрсөн хот сум, суурин газарт дулааны эх үүсвэр шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж дулаан хангамжийн чанар хүртээмж, ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг сайжруулна. | 1. Баянхонгор аймагт 35МВт хүчин чадалтай дулааны станц барьж, ашиглалтад оруулах | 2021 - 2024 | | 80 | Монгол Улсын Засгийн газраас 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хот суурин газрын дулаан хангамжийн хүртээмж чанарыг сайжруулах зорилгоор Баянхонгор аймгийн төвд дулааны станц , дулаан дамжуулах шугам сүлжээ барих төслийг БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан гэрээний хүрээнд хэрэгжүүлж байна. Тус дулааны станцын төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНСУ-ын “Бьюксан Инженеринг” ХХК болон “МЭЗ” ХХК нар хамтран ажиллаж байна. Тайлант онд гурван зуухны угсралтын ажил 89%-ийн гүйцэтгэлтэй, өрлөг, дулаалгын ажил болон бүдүүн нарийн үнсний бункер, уутат фильтер зэрэг угсралтын ажил хийгдсэн. Аймгийн Засаг даргын "Дулааны станц барих ажлын явцад хяналт тавьж ажиллах ажлын хэсэг байгуулах тухай" 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/165 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Барилга угсралтын гүйцэтгэгч компаний холбогдох мэргэжилтэнгүүдтэй хамтран ажлын явцын талаар хуралдаж, дулааны станцын 1-р хэлхээ явах трасс, ус дулаан дамжуулах төв байрлах газар нь зарим байршилд иргэн, аж ахуй нэгжийн газар дайрч байгааг холбогдох орон нутгийн удирдлагуудад танилцуулан Газрын эзэмшигч нартай 3 удаа хуралдаж, тухайн ус дулаан дамжуулах төв байрлах хэсгийн талбайг цэвэрлэж, чөлөөлж өгөхөөр шийдвэрлэсэн. | |
| 145 | | 2. Баянхонгор аймгийн төвийн 2 дугаар хэлхээний | 2023 - 2024 | | 100 | Баянхонгор аймгийн төвийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний ажлын зурагт төслийг 2020 онд "Ричвелл" ХХК хийж батлуулсан. Тус 2 дугаар хэлхээний шугам | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | инженерийн шугам сүлжээг шинэчлэх | | | | сүлжээний ажлын төсөв нийт 52.6 тэрбум төгрөг бөгөөд 2025 онд улсын төсөвт 3 тэрбум төгрөгийг суулгасан. | |
| 146 | | 3. Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэх | 2021 - 2023 | | | Баянхонгор сумын “Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр “ГАЛ ХОНГОР” ХХК шалгарсан бөгөөд 2022.07.25-ны өдөр 6,961,146,399 төгрөгийн төсөвтэй 2022/137 дугаар гэрээ байгуулсан. Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах ажлыг “ДНТ” ХХК, инженер геологийн судалгааг “ЖОНШТ УУЛ” ХХК” гүйцэтгэсэн. Магадлалын ерөнхий дүгнэлт дугаар/огноо: 0127/2021, 2021.02.10, барилга угсралтын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн дугаар 2022.10.07, Бх2022/15. Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажил нь: гадна дулааны шугам нийт 1258 м, ариутгах татуургын шугам 1320 м хийгдсэн. Тайлант онд захиалагчийн техникийн хяналтыг нийт 14 удаа хийж, тухай бүрд ажлын улаан дэвтэрт шаардлага, зөвлөмж өгсөн.Тус ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна | |
| 147 | | 4. Залуус хороололд инженерийн шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэх | 2022 - 2024 | | 50 | Баянхонгор хотын "Шинэ суурьшлын бүс"-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор Амины орон сууцны хороолол байгуулах ажлын хэсгийг Аймгийн засаг даргын 2022 оны 12 сарын 01-ны А/725 дугаар захирамжаар байгуулж энэ оны 7 дугаар сарын 17-нд тус шинэ суурьшлын бүсийн 7 га газарт нийт 144 айлын амины орон сууц байгуулах төсөл сонгон шалгаруулалтыг явуулж "Оломгарам" ХХК төслийг хэрэгжүүлэхээр шалгарсан бөгөөд бүтээн байгуулалтын ажил 2025 оны 4 дүгээр сард эхлүүлнэ. | |
| 148 | 3.9.2. Зарим сумдад "Сумын хөгжил" арга | 1. "Сумын төвийн шинэчлэл" төслийг хэрэгжүүлэх | 2021 - 2023 | | | Эрдэнэцогт сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр “Бридж бюлдинг” ХХК хийж гүйцэтгэн 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр ашиглалтад оруулсан.. Тус ажлын хүрээнд 60-70 м3 хүчин чадалтай “Эколос”-ын бага оврын цэвэрлэх байгууламж, төрийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | 5 байгууллагад шинээр стандартын ариун цэврийн өрөө, Гадна тохижилтын ажил, Тоглоомын талбай, Спорт талбай, Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, 800м урттай дугуйн зам, 2.5 км авто зам, 2.5 км урттай бохирын шугам, Цэвэрлэх байгууламж ажилуулах цахилгааны дэд станц, камержуулалтын ажлууд тус тус хийгдсэн. Галуут сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр “Алегротовер констракшин” ХХК-тай гэрээ байгуулсан. Тус төслийн хүрээнд 2 км авто зам /гэрэлтүүлэг, камер, ногоон байгууламжтай/ 2 км дугуйн зам, 2 км явган зам, Бохирын шугам 2 км, 60м3 багтаамжтай цэвэрлэх байгууламж, Цэвэр усны эх үүсвэрийн гүний худаг, 60м3 багтаамжтай нөөцийн сав, 2км урттай цэвэр болон дулааны шугмын ажлууд хийгдсэн. 100м*70м, 90м*60м талбайтай 2 цэцэрлэгт хүрээлэн, Албан байгууллагуудын ариун цэврийн өрөө шинээр хийх /6 байгууллагын барилгад 12 нойлын өрөө/ ажлууд хийгдэнэ. Тус ажлын гүйцэтгэл 80 хувьтай 2025 оны 2 дугаар улиралд ашиглалтад орно. Баацагаан сумын СУМЫН ТӨВИЙН ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ-ийн гүйцэтгэгчээр “Рино инженеринг” ХХК гэрээ байгуулан ажлыг энэ онд эхлүүлсэн. Тус ажлын гүйцэтгэл 60 хувьтай 2025 оны 03 дугаар улиралд ашиглалтад орно. | |
| 149 | | 2. Сумын төвүүдийг цэвэрлэх байгууламжтай болох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх | 2021 - 2024 | | 1 | Сумын төвд цэвэрлэх байгууламжтай болох ажлын хүрээнд инженерийн дэд бүтцийн хангамжийн ашиглалт үйлчилгээг нэгдсэн байдлаар ”Шинэ сум төсөл”-өөр Баянлиг, Бууцагаан сумд 2016 онд, Өлзийт сумд 2019 онд хэрэгжүүлж, “Сумын төвийн шинэчлэл”-ийн төслийг Эрдэнэцогт сумд 2023 онд, Баацагаан, Галуут сумдад энэ онд хэрэгжүүлж байна. Тус төслийн хүрээнд Баацагаан сумд 60м.куб хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, Галуут сум 60м3 хүчин чадалтай “Эколос” цэвэрлэх байгууламжийг суурилуулахаар захиалга өгсөн. Жаргалант, Гурванбулаг, Хүрээмарал, Шинэжинст, Богд сумдын цэцэрлэг, сургууль, дотуур | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлыг “Сайрын харгана” ХХК гүйцэтгэсэн бөгөөд 2024 оны 11 сарын 19-22-ны өдрийн хооронд Улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан. | |
| 150 | 3.9.3. Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 1. Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 40 | Ус хангамжийн эх үүсвэрт шинээр гүний худаг гаргах ажлыг Засаг даргын нөөц хөрөнгө болон НҮБ-ын хүүхдийн сангийн хөрөнгөөр "Баянзаг Дриллинг" ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Шинэ суурьшлын бүсийн 9000 метр HDPE маркын хоолойн угсралтын ажил, 500м3 усан сангийн байгуулалтын барилгын болон шугам сүлжээ, тоноглолын угсралт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Шинэ суурьшлын бүсийн шугам хоолой тоног төхөөрөмжийг "Базардарь" ХХК нийлүүлж, шугам хоолойн угсралтын ажлыг "Чандмань-Баянхонгор" ХК гүйцэтгэн тус тус ашиглалтад оруулсан. Мөн Шинэ суурьшлын бүсэд 128м3 хүчин чадалтай цэвэрлэх байгууламж барьж ашиглалтад оруулж 640 хүүхдийн сургуулийн 100 айлын 2 нийтийн орон сууцны барилга байгууламжийг тус тус холбосон. Мөн "Б софт" ХХК Баянхонгор сумын гэр хороололд 2,7,9-р багт: цэвэр усны Ф50, Ф75мм-ийн шугам – 2940м, 6-р багт: гэр хороололд Ф160мм-200мм –ийн ариутгах татуургын шугам – 450м, Ф50-Ф133мм-ийн дулаан, цэвэр ус-480м Дахин төлөвлөлтийн Ф50-Ф273мм, цэвэр усны шугам -1400м, 3-р багт: Ариутгах татуургын Ф160мм- 1320м, 4,5-р багт цэвэр усны шугам Ф50-Ф75мм-1736м, Ариутгах татуугын шугам Ф160мм-1792м, Ф200мм- 410м Дулааны шугам – Ф159-Ф25мм – 5500м Ариутгах татуургын шугам Ф159мм-Ф400-3000м, Цэвэр усны шугам - Ф160мм 3000м Шинэ төгөл : Дулаан хэрэглээний халуун ус Ф133-Ф219 мм – 1630м Нийт цэвэр усны шугам – 8156м, Нийт бохир усны шугам – 6972м шугам сүлжээний ажлуудыг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулаад байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 151 | 3.9.4. Үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 1. Баянхонгор сумын үерийн далан суваг, борооны болон хөрсний зайлуулах хоолой хийх | 2021 - 2024 | | 40 | Баянхонгор хотын үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлын зураг төслийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгүүлэн хүлээн авсан. Тус ажил нь 2024 оны улсын төсөвт тусгагдаагүй болно. | |
| 152 | 3.9.5. Ашиглалтын шаардлага хангахгүй барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөж, оршин суугчдын аяа тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ. | 1. Ашиглалтын шаардлага хангахгүй барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөх | 2021 - 2024 | | 1 | Баянхонгор сумын Номгон 1-р багийн 10-р байрыг буулган шинээр 125 айлын орон сууц барихаар барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Зүүн шанд” ХХК, "РМБ" ХХК тус тус шалгаран барилга угсралтын ажлыг 2022 онд эхлүүлэн 2023 оны 07 сард байнгын ашиглалтад оруулсан. Рашаант 10-р багийн 1-р байрны дахин төлөвлөлтийн ажлын гүйцэтгэгчээр "Би ай эм би" ХХК шалгарч Аймгийн засаг дарга, оршин суугчид, гүйцэтгэгч 3 талт гэрээ байгуулсан бөгөөд 2023 оны 2 сард улсын комисс ажиллаж ашиглалтад оруулсан. Мөн Рашаант 10-р багт 2,7,9 дүгээр байрны дахин төлөвлөлтийн ажлыг эхлүүлсэн. 7 давхар 4 блок орон сууцны хотхоны барилга угсралтын гүйцэтгэгчээр "Хаш гоёо" ХХК ажиллаж 1-р ээлжийн 2 блок 98 айлын орон сууцны барилгыг 2023 оны 8 сард ашиглалтад оруулсан. | |
| 153 | | 2. Хуучин байрнуудын өнгө үзэмжийг сайжруулах, гадна тохижилтын ажлыг хийх, инженерийн шугам сүлжээг шинэчлэх | 2021 - 2022 | | | Баянхонгор сумын Номгон 1 дүгээр багийн 514 дүгээр байрны засварын ажлыг Алегротовер ХХК гүйцэтгэж байна. Уг их засварын ажлыг хүрээнд Бохирын шугам сүлжээ солих, гадна пасад, дээвэр, орцны дотор заслын ажлууд хийсэн. Мөн энэ онд Баянхонгор сумын 128 дугаар байрны их засварын ажлыг "Содон сондор цамхаг" ХХК хийж гүйцэтгэн ашиглалтад оруулаад байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 154 | 3.9.6. Аймаг, сумдын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн хэмжээнд 1000-аас доошгүй айл өрхийг орон сууцаар хангана. | 1. Шинэ суурьшлын бүсэд нийтийн орон сууцны барилга барьж ашиглалтад оруулах | 2021 - 2022 | | 2 | Шинэ суурьшилын бүсэд 98 айлын 2 блок орон сууцны барилгын угсралтын ажлыг "Хаш гоёо" ХХК, Баянхонгор эко дулаан ХХК 2021 онд эхлүүлсэн бөгөөд 2022 оны 10 сард улсын комисс ажиллаж ашиглалтад оруулсан. Мөн 2025 онд Шинэ суурьшлын бүсэд амины орон сууцны хороолол байгуулах ажлыг эхлүүлхээр ажиллаж байна. | |
| 155 | | 2. Хонгор-1000 орон сууцны хороолол байгуулах | 2022 - 2024 | | 3 | Хонгор-1000 орон сууцны хороололд 17 байршил дээр нийтийн орон сууцны зориулалтаар газар олголт хийгдсэн. Мөн Баянхонгор хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Хонгор 1000 орон сууцны хорооллын талбайг өргөжүүлэн Ерөнхий төлөвлөгөөний бүсчлэлд өөрчлөлт оруулсан тухай АИТХурлын 2022 _8/12 Тоот тогтоолоор нийтийн орон сууцны газруудыг Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж Баянхонгор сумын Засаг даргын тамгын газарт эзэмшүүлж 2022- 2024 онуудад төсөл сонгон шалгаруулалт зарласан боловч гүйцэтгэгч сонгон шалгараагүй байна. | |
| 156 | | 3. Хувийн хөрөнгө оруулалтаар аймаг болон сумдад нийтийн орон сууцны барилга барьж ашиглалтад оруулах | 2021 - 2024 | | 250 | Аймгийн төвд 691 айлын 15 орон сууцны барилга баригдаж байна. 2021 оны А-01 тушаалаар баталсан “Ашиглалтад орсон нийтийн болон амины орон сууцны байшингийн /А-ОС-01/ тайланг батлагдсан загварын дагуу гарган эхний улирлын тайланг 2024.03.05 өдөр, эхний хагас жилийн тайлан мэдээг өссөн дүнгээр гарган 2024.05.27 өдрийн 255 тоот албан бичгээр, 3-р улирлын тайланг 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 502 тоот албан бичгээр, жилийн эцсийн тайланг 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 808 тоот албан бичгээр болон d.undram@barilga.gov.mn цахим хаягаар хугацаанд нь тус тус хүргүүлсэн. Тайлант онд хувийн хөрөнгө оруулалтаар 303 айлын таван орон сууцны барилгад улсын комисс ажиллаж ашиглалтад оруулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 157 | 3.9.7. Аймаг, сумын төвүүдийн 380/04кВ-ын шугамын өргөтгөлийг нэмэгдүүлж, аймгийн төвд 35/10кВ-ын дэд станцыг шинэчилнэ. | 1. Баянхонгор аймгийн төвд 110/35/6кВ-ын дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийн ажил хийх | 2022 - 2024 | | 100 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 110/35/10кВ-ын Баянхонгор дэд станцын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг "ДМТМ" ХХК хийж гүйцэтгэн 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр ашиглалтад оруулаад байна. Тус ажлын хүрээнд 110кВ-ын ХХБ-ийн барилгын ажил, 16 МВТ-ын трансформатор секц 1-ийг 10 кВ руу шилжүүлж ажил, 5 МВАр SVG-1 тоног төхөөрөмж угсарч суурилуулах ажил, 10кВ-ын тулгуур солих, трансформаторын хайрга солих, 10кВ-ын гаргалгааны кабелийн ажил, 110 кВ-ын Т-1 трансформаторын саармаг цэг дээр NGP-110 маркийн саармаг цэгийн салгуур шинээр суурилуулах, 110 кВ-ын Т-1 талын LCWB6, 50/5 гүйдлийн трансформаторыг LB7-110/W3, 150/5 гүйдлийн трансформатороор солих ажлууд тус тус хийгдээд байна. | |
| 158 | 3.9.8. Үүрэн телефонуудын сүлжээний хамрах хүрээг өргөтгөнө. | 1. Шаардлагатай сум, багийн үүрэн холбооны 2G, 3G, 4G, 5G сүлжээний хамрах хүрээг нэмэгдүүлэх | 2022 - 2023 | | | Улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгөөр Эрдэнэцогт, Өлзийт, Баянлиг, Гурванбулаг, Хүрээмарал, Баянцагаан сумдад үүрэн холбооны цамхагийн ажлыг хийж гүйцэтгэн 2023 оны 11 дүгээр сард ашиглалтад орсон. Мөн энэ онд Баян-Өндөр, Жинст, Баацагаан, Шинэжинст сумдад 3 цэгт үүрэн холбооны цамхаг барих ажлыг "Industry" ХХК гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна. Тус ажил нь 2025 оны 04 дүгээр улиралд ашиглалтад орно. | |
| 159 | 3.9.9. Аймгийн суурьшлын бүсүүдийг хамарсан утасгүй сүлжээний дэд бүтэц байгуулна. | 1. Утасгүй сүлжээний орчинг бий болгож, төрийн цахим үйлчилгээг авах нөхцлийг бүрдүүлэх | 2022 - 2024 | | 4 , 0 | 2019 оноос хэрэгжүүлж буй "Ухаалаг цамхаг" төслийг нийт 270 сая төгрөгөөр Баянхонгор сумын 2,3,7,9-р багийн нутаг дэвсгэрт утасгүй сүлжээний орчин бий болгохоор ажиллаж байна. Ажлыг хүлээж авахаар Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж байна. | |
| 4. ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | | | | | |
| 160 | 4.1.1. "Төрийн мэргэшсэн албан | 1. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2022 - 2024 | | 40 | Төрийн аудитын газраас 2024 оны 09-11 дүгээр сар хүртэл 2 сарын хугацаанд хүний нөөцийн аудит | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хаагч" 2022-2026 онд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | | | | | хийгдэж хүний нөөцийн бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зөвлөмж ирүүлсэн. Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгаа, хүний нөөцийн стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулан байгууллагын “Удирдлагын баг”-т танилцуулж сайжруулалт хийж байна. Аймгийн хэмжээний дутагдалтай орон тоог нөхөх, нэн шаардлагатай мэргэжлээр хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр Боловсролын яаманд хүсэлт гарган Баянхонгор аймгаас их дээд сургуульд суралцаж байгаа нийт оюутнуудын судалгааг авч мэдээллийн бааз бүрдүүлэн ажиллаж байна. Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгаа, хүний нөөцийн стратеги төлөвлөгөөг боловсруулж, чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд 2025 оны аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний 186 дах заалт /60 сая төгрөгийн төсөвтэй/, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.14.2 заалтаар тус тус тусгасан. Мөн цахим системд 53 байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган тайлагнаж байна. | |
| 161 | 4.2.1. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулна. | 1. Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, сахилга хариуцлагыг чангатгах | 2021 - 2024 | | 130 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 14 дүгээр удирдамжийн дагуу Хууль сурталчлах хянан шалгах, зөвлөн туслах ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 25-наас 05 дугаар сарын 01-ний өдрийн хооронд 5 суманд зохион байгуулсан. Сургалтад Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж сурталчлах, Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ойлголт хандлагыг бий болгох,Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах сургалтыг сумдын Төрийн албан хаагчид, иргэд болон ерөнхий боловсролын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургуулийн ахлах ангийн сурагчдыг хамруулан ажилласан. Сургалтад иргэд 303, төрийн албан хаагч 290, сурагч-123, нийт 716 хүн хамрагдсан байна. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын шинэчлэлийн дагуу албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэх аяныг байгууллагууд зохион байгуулж журмын хэрэгжилтийг ханган ажилласан байна. Мөн Төрийн албаны ёс зүйн тухай хууль 2023 оноос шинэчлэн батлагдаж, түүнийг дагаж Засгийн газрын “Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай” 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 тогтоол, Ёс зүйн хорооны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтийг хангаж байгууллагуудад 2024 оны 10 сарын 25-ны 2/1371 дугаар албан бичгээр чиглэл хүргүүлж ажилласан. Тус албан бичгийн хүрээнд 25 сум байгууллагын ёс зүйн зөрчлийн мэдээг ирүүлээд байна. Төрийн албан хаагчидтай холбоотой Засгийн газрын Өргөдөл, гомдол хүлээн авах 1111 төвд ирсэн төрийн албан хаагчдад ирүүлсэн өргөдөл гомдлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. | |
| 162 | 4.3.1. Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн хэрэгцээг тодорхойлох. | 1. Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгаа авах | 2021 - 2024 | | 100 | Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн хангалт, мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдын мэргэшүүлэх судалгаанд 40 агентлаг, байгууллагын 265 албан хаагчийн хамруулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон. Энэхүү судалгаанаас харахад төрийн байгууллагад ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутмаг, тэр тусмаа сумд ажиллах мэдээллийн технологийн мэргэжилтэн олддоггүй нь тухайн чиглэлийн үйл ажиллагаа сумдад доголддог байна. Улсын хэмжээнд Цахим хөгжил харилцаа холбооны яам, И-Монгол академиас зохион байгуулж байгаа Төрийн албан хаагчдын цахим ур чадварын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаанд 1124 албан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагчийг идэвхтэй хамруулав. Тус судалгааны нэгдсэн дүнг И-Монгол академи танилцуулна. Судалгааны линк: https://forms.office.com/r/TrveuCXa3d ЦХИХХ яамнаас 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан "Цахимд хэвшье" арга хэмжээний үеэр зохион байгуулсан мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах сургалт, арга хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 45 албан хаагчийг хамруулж мэдээлэл зөвлөгөө өгөн цахим ур чадвар олгох сургалтыг зохион байгууллаа. Мэдээллийн технологийн үнэлгээ төрийн байгууллагын албан хаагчдын цахим ур чадвар, техник тоног төхөөрөмжийн хангалтаас шалтгаалж үнэлгээ 30 хувьтай байна. | |
| 163 | | 2. Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг нэгдсэн бодлого, зохион байгуулалтаар хангах | 2022 - 2024 | | 80 | Аймгийн төрийн байгууллагуудын мэдээллийн технологи хариуцсан ажилтнуудыг 2020 оноос хойш "ДИЖИТАЛ БАЯНХОНГОР" арга хэмжээний хүрээнд тогтмол чадавхжуулан ажиллаж байна. 2023 онд аймаг сумдын 80 гаруй байгууллагын IT нарт , SUPER ADMIN (http://empasoft.mn:5000/trainingView/2/content), Цахим хөгжлийн багц хуулиуд, Цахим жишиг аймаг хөтөлбөр хэрэгжүүлэх аргазүйн зөвлөгөө, Цахим ур чадвар олгох сургалт (I,II,III багц) сургалтуудад бүрэн хамруулж нэгдсэн зохион байгуулалтаар ханган ажилласан бол энэ оны хагас жилийн байдлаар төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 45 мэдээллийн технологи хариуцсан албан хаагчийг сургалтад хамруулан мэдээлэл зөвлөгөө өгч, тэдний цахим ур чадварыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсан бол 2024 онд Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-тай хамтран төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, сумдын мэдээлэл технологи хариуцсан нийт 280 гаруй албан хаагчийг кибер аюулгүй байдлын чадавхыг нэмэгдүүлэх сургалтад хамруулан ажиллаж гүйцэтгэл 80 хувьтай байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 164 | 4.3.2. E-Mongolia хөтөлбөрийн хүрээнд “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”–ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлж, чанар хүртээмжийг сайжруулна. | 1. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, цахим платформын ашиглалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 150 2500 | Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлж буй цахим платформын ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор "ХУРДАН" цэгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн байр, Баруун бүсийн худалдааны төв, Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн байр зэрэг газруудад 3 цэг шинээр байгуулан ажиллаж байна. Тус цэгүүдээр дамжуулан 2024 оны байдлаар 32166 үйлчилгээг иргэдэд операторын горимоор хүргэн ажилласан байна. Мөн ХУРДАН цэгийг Өлзийт, Баян-овоо, Баянговь, Эрдэнэцогт, Бууцагаан, Гурванбулаг. Шинэжинст, Галуут сумдад нээн, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна. | |
| 165 | 4.3.3. Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх, бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ. | 1. Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, тоон бичиг үсгийн ур чадварыг дээшлүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах | 2022 - 2024 | | 60 | Салбарын үйл ажиллагааг орон нутагт сурталчлах, бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, тоон бичиг үсгийн ур чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас "DIJITAL FIRST D1" арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Тус арга хэмжээнд нийт 600 гаруй иргэд, төрийн албан хаагчдыг хамруулж, тэдэнд цахим ур чадварыг нэмэгдүүлэх мэдлэг олгож, цахимд туршилт хийлгэж дадлагажуулсан. Мөн 19 суманд цахим ур чадвар олгох сургалтыг 2024 оны 1 дүгээр улиралд зохион байгуулж, 2700 гаруй иргэнийг хамруулан ажиллав. | |
| 166 | | 2. Бүх төрлийн өргөдөл гомдлын шийдвэрлэлт, тусгай зөвшөөрөл олголтыг цахимжуулах | 2022 - 2024 | | 90 70 | Баянхонгор аймаг нь 2021 оноос тусгай зөвшөөрлүүдийн олголтыг цахимжуулж эхэлсэн бөгөөд 2024 оны байдлаар 37 төрлийн тусгай зөвшөөрлийг цахимаар иргэн хуулийн этгээдэд олгож байна. Цаашид орон нутгийн онцлогтой тусгай зөвшөөрлүүдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 1 дүгээр улиралд И МОНГОЛ УТҮГ-ын баг Баянхонгор | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аймагт ажиллаж 128 төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээг цахим шилжүүлэх боломжтой гэж үзсэний дагуу үйлчилгээний тоог нэмэгдүүлэхээр хамтран ажиллаж байна. | |
| 167 | | 3. "Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем"-ийн нэмэлт хөгжүүлэлтийг хийх | 2022 - 2024 | | 100 | | "Цахим аймаг" бодлогын хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагуудын цахим хяналт, мэдээллийн нэгдсэн ДАШБОАРД-ыг үндэсний ДАТА төвд шилжүүлэн хөгжүүлэлт хийгдэж байна. Иргэдийн санал, гомдол хүлээн авах irgen.bayanhongor.gov.mn цахим системийг 20.0 сая төгрөгөөр "Анар системс" ххк хийж дууссан бөгөөд ашиглалтад 100 хувь орсон. | |
| 168 | 4.3.4. Бүс нутгийн аялал жуулчлал, бизнесийг дэмжих технологийн шийдлүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 1. Виртуал аялал хийх боломжтой "VR-Bayankhongor" төвийг байгуулж, контентийг нэмэгдүүлэх | 2022 - 2024 | | 700 | | 2024 онд аялал жуулчлалын ""Баянхонгор аяллын хөтөч"" гар утасны апп-ыг нэвтрүүлэх бөгөөд 2023 онд зураг, ажлын даалгавар боловсруулагдаж дууссан байна. Мөн Баянхонгор сумд ""Виртуал Баянхонгор"" төвийг байгуулж тус төв нь VR технологи ашиглаж Баянхонгор аймгийн үзэсгэлэнт 7 газраар аялал хийх зориулалт бүхий төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Баянхонгор аймгийн Аймгийн ОНӨГ-с энэхүү төвийг хувийн хэвшилд төсөл сонгон шалгаруулах замаар хувьчлах үйл ажиллагаа явуулж ""Айети Юнипикэшн"" ХХК-ний төсөл шалгарч гэрээ байгуулсан. ""Баянхонгор аялал жуулчлал"" facebook хуудсаар аймгийн хэмжээний аялал жуулчлалын мэдээллийг нээлттэй мэдээлж байна. | |
| 169 | | 2. 20 сумын төвийн нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллыг заасан 360, VR, зураг, дүрсний танилцуулгыг | 2021 - 2023 | | | | "Ухаалга Баянхонгор" хөтөлбөрийн хэрэгжилт дуусаж, “Цахим аймаг” хөтөлбөрийг боловсруулж, АПП хөгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Хөрөнгө санхүүжилт шийдэгдээгүйн улмаас удаашралтай байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөгжүүлж Google street-д байршуулах | | | | | |
| 170 | 4.3.5. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ. | 1. Авлигын гэмт хэргийн гаралтын тоог бууруулж, шударга байдлын төвшинг нэмэгдүүлэн, цахим хуудасны ил тод байдлын төвшинг ахиулах | 2021 - 2024 | | 1 0 49 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2024 оны А/49 дүгээр захирамжаар баталж, төлөвлөгөө 100 хувьтай хэрэгжүүлсэн. Тайлант онд аймгийн хэмжээнд шинээр авлигын гэмт хэрэг 17 бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна. Цахим хуудасны ил тод байдал 100 хувьтай. Шударга байдлын 2023 оны үнэлгээ 75.2 хувь болж өмнөх оноос 6.7 хувиар өссөн байна. | |
| 171 | 4.4.1. Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох замаар түүнээс урьдчилан сэргийлэх, гаралтыг бууруулна. | 1. Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийн тоог бууруулах | 2021 - 2024 | | 123 , 1720 | Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг, архинд донтох эмгэгтэй 88 иргэнд үзлэг хийж, 71 иргэнийг 6 ээлжээр хүлээн авч, архины сайн дурын эмчилгээнд хамруулсан. Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2309 иргэн, 96 хүүхдэд сургалт зохион байгуулж, орон гэргүй тэнэмэл амьдралтай, архины хамаарал бүхий иргэдийг бүртгэлжүүлэх чиглэлээр “Тэнэмэл” хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, 16 иргэнийг бүртгэлжүүлэн, архидан согтуурч, удаа дараа зөрчилд холбогдсон 1 этгээдийг архины албадан эмчилгээнд хамруулсан.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ГХУСАЗСЗ-өөс 1.0 сая/төг-ийг шийдвэрүүлж, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 380 гаруй аж ахуйн нэгжид цахимаар болон танхимаар 4 удаагийн сургалт зохион байгуулж ажилласан. Согтууруулах ундаагаар үйлчлэх үүрэг бүхий ажилтнуудын хариуцлагатай үйлчилгээний сургалтад 21 аж ахуйн нэгжийн 92 ажилтныг хамруулсан. Согтууруулах ундааны тусгай зөвшөөрлийг сунгуулах, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинээр авах 146 аж ахуйн нэгжийн хүсэлтийг цаасан болон цахимаар хүлээн авч, ажлын хэсгийн хурлыг 43 удаа хуралдуулж, 46 дүгнэлт гарган шийдвэрлэж, тусгай зөвшөөрөл олгон ажиллалаа. Байгууллагад суурилсан нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх дэмжих бүлгийг эхлүүлж, нийт 50 иргэн хамрагдсан. АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Аймгийн ГХУСАЗСЗ-ий дэмжлэгтэй “Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад Сэтгэл зүй нийгэм, хууль эрх зүйн үйлчилгээний мэдээллээр ханах сургалт зохион байгуулж нийт 83 байгууллагын 3266 ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгуулахаар төлөвлөж, 69 байгууллагын 1832 ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгуулж, төлөвлөсөн байгууллагуудын 83%-д сургалтаа зохион байгуулж, нийт ажилтан албан хаагчдын 56%-ыг сургалтад хамруулллаа. согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 166 бүртгэгдэж 32.1 хувиар өссөн, Согтуугаар үйлдэгдсэн зөрчил 1268 бүртгэгдэж 30.5 хувиар буурсан байна. | |
| 172 | | 2. Гэр бүлийн хүчирхийлллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах | 2021 - 2024 | | 40 , 152 | Орон нутгийн төсвөөс 8.5 сая/төг-ийг шийдвэрлэж, гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөж хохирсон хүүхэд, эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг хангах, зөвлөгөө мэдээлэл өгөх зориулалтын 3 өрөөг тохижуулж, ашиглалтад оруулан, хүүхэд эмэгтэйчүүдийн аюулгүй байх нөхцөл хангагдсан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, энэ төрлийн зөрчил, гэмт хэргийг бууруулах чиглэлээр 15 нэгдсэн арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, 850 гаруй иргэнийг хамруулж, Авто радио 96.3-тай хамтран Гэр бүлийн хүчирхийлллээс, урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай ярилцлага, мэдээллийг өгч ажиллав. Гэр бүлийн хүчирхийлллийн улмаас 25 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 нэгжээр буурсан. Гэр бүлийн хүчирхийлллийн улмаас үйлдэгдсэн зөрчил 244 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | |
| 173 | | 3. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоог бууруулах | 2021 - 2024 | | 20 | Аймгийн Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөлийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2024 оны А/195 дугаар захирамжаар баталж, орон нутгийн төсвөөс 2.0 сая/төг-ийн санхүүжилтийг шийдвэрлэж, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг 23 удаа зохион байгуулан ажиллаж, төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай хэрэгжсэн. | |
| 174 | | 4. Мал хулгайлах гэмт хэргийн тоог бууруулах | 2021 - 2024 | | 62 | Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн санаачилга, малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр 17 сумын 2500 гаруй иргэдэд сургалт зохион байгуулж, 6 төрлийн 6000 гаруй гарын авлага түгээн ажилласан. Мал хулгайлах гэмт хэрэг 18 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10 нэгжээр буюу 35.7 хувиар буурсан үзүүлэлтэй байна. | |
| 175 | | 5. Цагдаагийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | 2021 - 2024 | | 58,1 | Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 61.7 сая/төг-ийг, Орон нутгийн төсвөөс 874.0 сая/төг-ийг тус тус шийдвэрлэн, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 81 удаагийн нэгдсэн, 46 удаагийн хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, 110 удаагийн сургалтад 8500 гаруй иргэдийг хамруулсан. Эрүүжлүүлэх, саатуулах, баривчлах байрны орчин, нөхцөлийг сайжруулах, стандартад нийцүүлэх чиглэлээр 2023-2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 295.0 сая/төг-ийг шийдвэрлэж, гүйцэтгэгчээр "Буян-Арвижих-Од" ХХК шалгарч, өргөтгөлийн барилгын ажил 100 хувьтай хийгдэж, баривлагдсан иргэдийн эрх хангагдсан. Эрдэнэцогт сумын цагдаагийн хэсгийн барилгын урсгал засварын ажлыг гүйцэтгэхээр иргэн Д.Батсайхан, Г.Дондог нартай гэрээ байгуулан, гүйцэтгэл 100 хувьтай хийгдэж, албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирсан Гурванбулаг, Жаргалант | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сумын цагдаагийн хэсгийн байранд урсгал засварын ажлын гүйцэтгэгчээр “Буянт зэндмэнэ өргөө” ХХК шалгарч, гэрээ байгуулан, гүйцэтгэл 100 хувьтай хийгдэж, албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирсан. | |
| 176 | | 6. 1,4,5,6,10-р багийн нутаг дэвсгэрт Гамшгийн үеийн зарлан мэдээлэх, утасгүй сүлжээний орчинг бий болгох | 2022 | | | 2019 оноос хэрэгжүүлж буй "Ухаалаг цамхаг" төслийг нийт 270 сая төгрөгөөр Баянхонгор сумын 2,3,7,9-р багийн нутаг дэвсгэрт утасгүй сүлжээний орчин бий болгохоор ажиллаж байна. Ажлыг хүлээж авахаар Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж ажлын гүйцэтгэл 70 хувьтай. | |
| 177 | | 7. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 50 | 2021 онд Баянхонгор аймгийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг танилцуулсан "Аймгийн хөгжлийн зөвлөгөөн"-д Баянхонгор сумын Хяналтын камерын ухаалаг системийн төслийн дагуу 2022 онд Баянхонгор сумд 190.0 сая, Бөмбөгөр сумд 40 сая, Галуут сумд 40 сая, Жинст сумд 40 сая төгрөгийн өртөг бүхий хяналтын камерын системийн ажил хийгдсэн. Баянхонгор аймгийн хэмжээнд 63 ширхэг өдөр шөнө өнгөтөөр харах камер, 19 ширхэг хөдөлгөөнт камер, 4 ширхэг дугаар илрүүлэгчтэй камер суурилуулагдсан. Мөн Баянхонгор сумыг бүрэн хянах боломжтой шуурхай удирдлагын дэд төвийг 2024 оны 11 сард байгуулан үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. | |
| 178 | 4.5.1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлж, иргэдэд эрх зүйн харилцаанд | 1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, иргэдийн эрх зүйн харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 1800 | Шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжоор 20 сум, 59 байгууллагын 9211 иргэд, төрийн албан хаагч, оюутан, сурагчдад төлөвлөгөөт 23, төлөвлөгөөт бус 14, захиалгат 22 сургалтыг 147 сэдвээр зохион байгуулж, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэн ажиллалаа. Аймгийн хэмжээнд Хууль зүйн анхан шатны зөвлөгөө мэдээллийг 872 гаруй иргэд, төрийн албан хаагчдад өгч, 21 хууль тогтоомжоор 40 гаруй төрлийн постер бэлтгэж орон нутгийн телевиз, аймгийн www.bayanhongor.gov.mn цахим хуудас, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оролцох чадварыг нэмэгдүүлнэ. | | | | | хэлтсийн PAGE хуудас болон мэдээллийн самбараар тогтмол сурталчлан, иргэд, төрийн байгууллагуудад түгээн ажиллалаа. Мөн шинэчлэн найруулга хийгдэх 1 хууль, 18 журмын төсөлд санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулж, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан. | |
| 179 | 4.6.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэн, мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, архивын баримтын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг сайжруулна. | 1. Төрийн архивын лавлагаа мэдээллийн үйлчилгээнд тоон гарын үсгийг бүрэн нэвтрүүлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах. | 2021 - 2024 | | 80 | Төрийн архив нь 2024 онд бусад аймгийн иргэдээс онлайн дотоод сүлжээгээр захиалсан нийт 254 лавлагаа үзэх хүсэлт хүлээн авч шийдвэрлэн, тоон гарын үсгээр илгээж, мөн тус аймгийн иргэдээс бусад аймаг, хотоос онлайн дотоод сүлжээгээр захиалсан нийт 350 лавлагаа мэдээллийг олгож ажилласан нь урьд оны мөн үеэс 32 хувиар өссөн байна. Тоон гарын үсэг олголтын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, аймгийн хэмжээний төрийн болон төрийн бус байгууллагуудад Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг хүргүүлж, давхардсан тоогоор 77762 иргэнд буюу 75.8 хувьд олгосон байна. | |
| 180 | | 2. Төрийн болон байгууллагын архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулах. | 2021 - 2023 | | | Төрийн архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвөөс 60.0 сая/төг шийдвэрлэж, тендер сонгон шалгаруулалт зарлаж, “Санаамед трейд” ХХК шалгарч, 72 нягтруулсан шүүгээг нийлүүлж, сан хөмрөгт байршуулан архивын 5200 нэгж хадгалж хамгаалах нөхцөлийг сайжрууллаа. | |
| 181 | | 3 . Төрийн болон байгууллагын архивын баримтын цахим санд шилжилтийг эрчимжүүлэх. | 2021 - 2024 | | 89 | Төрийн архивын баримтыг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх “Цахим архив-Баянхонгор” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Цахим сангийн 5 ажилтныг орон нутгийн төсвөөс санхүүжилтийг олгон ажиллуулж, 78 хөмрөгийн 2094 хадгаламжийн нэгж буюу 112134 хуудас баримтад цахим хувь үүсгэн 158100 мэдээллийг программд өгөгдлөөр холбож бэлтгэн ажиллалаа. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 182 | | 4. Төрийн болон байгууллагын архивын баримтыг сэлбэн засах. | 2021 - 2024 | | 1,29 | Архивын үнэ цэнтэй, насжилт өндөртэй, муудсан цаастай баримтад цахим, нөөц хувь бий болгох, сэлбэн засах ажлыг 15 хадгаламжийн нэгж баримтанд хийж ажилласанаар хадгалалт хамгаалалт, насжилтийг уртасгах арга хэмжээ авч ажиллалаа. Төрийн архивд хадгалагдаж байгаа дуу дүрсний баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор Орон нутгийн төсвөөс 20.0 сая/төг-ийг шийдвэрлүүлэн дуу дүрсний 10689 баримтыг шинэчлэн сэргээн хуулбарлаж, үндсэн болон нөөц сервер, ашиглалтын хардуудад хуулбарлаж ажилласны үр дүнд баримтуудын насжилт чанарыг сайжрууллаа. | |
| 5. ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | |
| 183 | 5.1.1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлнэ. | 1. Цөлжилтөөс сэргийлэх, элсний нүүлтээс хамгаалах зорилгоор 50га хамгаалалтын зурвас байгуулах | 2021 - 2022 | | | Цөлжилт газрын доройтлыг бууруулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 16 сумын нутаг дэвсгэрт 18 байршилд 141,96 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулж 128148 ширхэг мод тарьж ургуулсан. Үүнд: Баянговь 3.3 га талбайд 2360 ширхэг мод Жинст 13 га талбайд 19066 ширхэг мод Баянцагаан 3,5 га талбайд 1513 ширхэг мод Шинэжинст 3 га талбайд 6400 ширхэг мод Эрдэнэцогт 1,56 га талбайд 2280 ширхэг мод Баянхонгор 51 га талбайд 48947 ширхэг мод Баацагаан 8 га талбайд 5578 ширхэг мод Өлзийт 18 га талбайд 13950 ширхэг мод Богд 13,9 га талбайд 11540 ширхэг мод Бууцагаан 2,5 га талбайд 2939 ширхэг мод Баян-Өндөр 1 га талбайд 500 ширхэг мод Баян-Овоо 0,9 га талбайд 300 ширхэг мод Баянбулаг 4 га талбайд 4305 ширхэг мод Бөмбөгөр 7,3 га талбайд 3950 ширхэг мод Заг 3,5 га талбайд 2480 ширхэг мод Жаргалант 2 га талбайд 1840 ширхэг мод тус тус тарьж усалгаа арчилгаа хийж байна. | |
| 184 | | 2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний | 2021 - 2024 | | 50000,50 | "Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 3387 айл өрх, 1153 ААН, байгууллага, 22808 иргэн бүх нийтээр мод тарих үйл ажиллагаанд оролцож | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүрээнд 20 сая мод тарих | | | | 475,61 га талбайд 20 гаруй төрөл зүйлийн 531898 ширхэг мод тарьсан. Нийт тарьсан мод 61,9 хувийн ургалттай байна. | |
| 185 | | 3. Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах | 2021 - 2024 | | 30 | Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг 2022 онд ШУТИС-ийн харьяа Ой модны сургалт, судалгааны хүрээлэн боловсруулсан. Ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны 07 дугаар сарын 01-28-ны өдрийг хүртэлх хугацаанд үүргийн шүршигч багаж ашиглан ойн хөнөөлт шавж голомтлон тархсан 7000 га газарт микробиологийн аргаар ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажлыг "Сайхан ойн төлөө" ХХК хийж гүйцэтгэсэн. “Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь” төсөлтэй хамтран байгалийн сэргэн ургалтыг дэмжих зорилгоор Шинэжинст сумын нутаг дэвсгэрт 1000 га талбайд заг бүхий талбайг хашиж хамгаалах судалгааны ажлыг ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн эрдэмтэдтэй хамтран хийж гүйцэтгэн, 2024 оны 09 дүгээр сарын 01-19-ний өдрүүдэд Баянбулагийн хаяа 50 га, Тугал хашаат 50 га, Улаан эрэг 100 га, Хиагтын нахуу 100 га нийт 4 байршилд 300 га талбайд заган ойг хашиж хамгаалсан. "Эрдэнэ монгол" ХХК-тай хамтран говийн Баянбүрдийг ойжуулах зорилгоор эхийн голд 7 га талбайд навчит модоор ойжуулалт хийж 6800 ширхэг мод тарьсан. Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар, "Сум дундын ойн анги" ОНӨТҮГ хамтран Түйн голын Цагаан бургасыг өргөжүүлэн ойжуулах ажлын хүрээнд 3 га талбайд 3750 ширхэг цагаан бургас тарьж ойжуулалт хийсэн | |
| 186 | | 4. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадасны | 2021 - 2024 | | 35 | Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг Баян-Бороо -1,2 экспедици 24 удаа зохион байгуулсан. Үр дүнд нь: - 2022 оны 05,07,09 дүгээр саруудад хур тунадасны хэмжээг Жинст, Богд, Баянцагаан, Галуут сумдын нутгаар олон жилийн дунджаас 3.0-12.0 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээг нэмэгдүүлэх | | | | миллиметрээр нэмэгдүүлсэн ба бусад нутгаар олон жилийн дунджийн орчим буюу бага хур тунадас орсон. 2023 онд эхний цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаагаар 8 сумын нутагт 0.0-4.0 мм хүртэлх цас, хоёр дахь удаа 12 сумын нутагт 0.0-3.0 мм цас орсон бол гурав дахь удаа 9 сумын нутгаар олон жилийн дунджаас 4.1-25.3 миллиметрээр их хур тунадас орсон. Энэ цаг агаарт нөлөөлөх ажлын үр дүнд 5 дугаар сард аймгийн нийт нутгийн 80-90 хувьд хамруулж хур тунадас нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийн тооцвол 161,7 сая төгрөгт хүрсэн. - Хангайн уулархаг нутаг, Алтайн салбар уулс, говийн бүсийн Байдраг, Баянбулаг, Гурванбулаг, Галуут, Богд, Бодь, Баян-Өндөр, Баацагаан сумдаар 2024 оны 06 дугаар сард 1.1-28.2 мм-ээр хур тунадас нэмэгдсэн.Хангайн уулархаг нутаг, Алтайн салбар уулс, говийн бүсийн Байдраг, Гурванбулаг, Хүрээмарал, Шаргалжуут, Эрдэнэцогт, Бөмбөгөр, Шинэжинст, Баянхонгор, Баянцагаан, Баян-Өндөр, Баянговь Баянлиг, Богд, Бодь, Баацагаан, Эхийнгол сумдаар 2024 оны 08 дугаар сард 2.5-114.3 мм-ээр хур тунадас нэмэгдсэн. Аймгийн нутгаар нэмэгдүүлсэн хур тунадасны Эдийн засгийн үр ашгийн тооцвол үнэ 80,855,000 төгрөгт хүрч, хур тунадас нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд 0.4 миллиметрээр нэмэгдсэн. | |
| 187 | 5.2.1. Булгийн эхийг хамгаалах, ундаргыг сэргээх, хөв байгуулах ажлыг зохион байгуулж, иргэдийн | 1. Булгийн эхийг хамгаалж, ундаргыг сэргээх, хөв байгуулах | 2021 - 2024 | | 3 | Үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд аймаг, сумын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Бөмбөгөр сумын Хотын булангийн булаг, Бүүрэг булаг, Галуут сум Их булгийн эх, Баруун шандны булаг, Тээлийн рашааны харз, Цохиотын харзны эх, Бууцагаан сумын Бөөрийн булаг, Өлзийт сум Бийрийн булаг, Цагаан хавцгайн булаг, Баацагаан сумын Арын урд булаг, Хүрээмарал сумын "Ацын гол"-ын булгийн дээд эх, Эрдэнэцогт сумын Сонгинотын хар зэрэг нийт 11 булгийн эхийг нутгийн иргэд, малчдын оролцоотойгоор хамгаалж, ундаргыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оролцоог нэмэгдүүлэх. | | | | | сэргээх ажлыг хийж гүйцэтгэлээ. “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтийг хангах нь” төслийн хүрээнд Баянцагаан сумын Хужирын булаг, Бага амны булаг, Баянбулаг, Баян-Өндөр сумын 1-р багийн Цагаан толгойн булаг, Шинэжинст сумын Задгайн булаг, Хаяа булаг, Баацагаан сум Шуудуугийн булгийн эхийг хамгаалж, Баацагаан сумын Товгор багт Хулсан амны шандны эх, Шинэжинст сумын Цагаан сайр нэртэй газар хуучин цооног, Баян-Өндөр сумын Идрэн багт шинээр худаг гарган нарны өргүүртэй болгон тус тус тохижуулсан. Заг сумын Халиутын рашаан, Шинэжинст сумын Эхийн гол, Баянлиг сумын Янгирын шанд, Жаргалант суманд Морин толгойн хөв, Баянбулаг суманд Ногоон дугуйн хөв, Богд суманд Хангинахын аманд тус тус хөв байгуулсан байна. Мөн Өлзийт сумын Бийрийн гол, Бууцагаан сумын Нуур намагт, Богд сумын Битүүтийн гол зэрэг 3 байршилд хөв цөөрөм байгуулах ажлын зураг төсвийг “Хайдродизайн прожект” ХХК хийж гүйцэтгэсэн. Ингэснээр улс, орон нутгийн төсөв болон олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр 3 байршилд хөв цөөрөм байгуулах зураг төсвийг бэлэн болгосон. | |
| 188 | | 2. Малчид, нөхөрлөлүүдтэй хамтран байгаль орчноо хамгаалах нөлөөллийн олон талт ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | | 200 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 50,0 сая төгрөгийн санхүүжилтээр "Номгоны андууд" ХХК 4 сумын 5 булгийн эхийг хашиж, хамгаалах ажлыг сумын байгаль хамгаалах нөхөрлөлүүдтэй хамтран хийж гүйцэтгэсэн. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвөөс хамтран хэрэгжүүлж буй “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги төлөвлөлтийг боловсронгуй болгох, орон нутгийн иргэдийн байгаль орчин болон байгалийн нөөцийн салбарт дасан зохицох чадавхыг бэхжүүлэх” төслийн 2 удаагийн сургалтад байгалийн нөөцийн хамтын менежментийн 10 нөхөрлөлийн төлөөлөл оролцсон. Мөн “Тэрбум мод” үндэсний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөлгөөний хүрээнд 1000 сургагч багш бэлтгэх хөтөлбөрт 17 нөхөрлөлийн гишүүн хамрагдсан. Баацагаан, Баянцагаан, Жаргалант, Өлзийт сумдын нөхөрлөл хууль бус ан агнуур, тусгай зориулалтын агнуурын үйл ажиллагаанд хяналт тавих, Богд, Шинэжинст, Бууцагаан сумдын нөхөрлөл мод тарих, Баян-Өндөр, Хүрээмарал сумдын нөхөрлөл булгийн эхийг хамгаалах, Эрдэнэцогт сумын нөхөрлөл аялал жуулчлалын чиглэлээр тус тус үйл ажиллагаа явуулж, сумдын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч нартай хамтран 1138 иргэнд сургалт, мэдээлэл өгсөн байна. | |
| 189 | 5.2.2. Зэрлэг амьтдыг хамгаалах өвс тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулна. | 1. Зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах | 2021 - 2024 | | 3 | Жил бүрийн 01-05 дугаар сарын хооронд зэрлэг амьтдын байршил бүхий 120 гаруй байршилд амьтдыг хамгаалах, өвс тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх биотехникийн арга хэмжээг авч ажиллалаа. Нийт 152 удаагийн давтамжтайгаар 49,68 тонн хужир, 9246 боодол өвс, 65 кг Жамц давс, 5,41 тн тэжээл байршуулсан. Биотехникийн арга хэмжээ авах үед Янгир ямаа-393, Аргаль угалз-96, Буга, согоо-56 тоо толгойг нүдээр үзэж тоолсон ба Мазаалай, Хар сүүлт, Аргаль, хонь, янгир ямаа, цагаан зээрийн бүс нутгуудад идэш тэжээлийг нэмэгдүүлсэн. | |
| 190 | 5.2.3. Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангана. | 1. Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 90 | Орог нуур-Түйн голын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний 2022-2025 онд хийгдэх ажлын II-дугаар үе шатны хүрээнд 17 зорилт, 27 арга хэмжээ, 105 ажил арга хэмжээ хэрэгжүүлэхээс 80 ажил, арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилтийн хувь 81 хувьтай байна. Бөөнцагаан нуур-Байдраг голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг “Монхидроконстракшн” ХХК-тай хамтран 4 стратеги зорилт, 18 зорилт, 24 арга хэмжээний хүрээнд 109 ажлыг хэрэгжүүлэхээр боловсруулсан. Тус төлөвлөгөөг Бөөнцагаан нуур-Байдраг голын сав газрын талуудын оролцооны зөвлөл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Байгаль орчин, хүнс, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөө аж ахуйн хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Усны газарт хүргүүлсэн хүлээгдэж байна. | |
| 191 | | 2. Зарим сумдад цэвэршүүлэх усан сан барих | 2021 - 2022 | | | Тайлант онд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 350,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянбулаг, Гурванбулаг сумдын усан сан бүхий цэвэршүүлэх төхөөрөмж, барилга угсралтын ажлыг "Гал гэрэл констракшн" ХХК хийж гүйцэтгэн улсын комиссоор хүлээлгэн өгөөд байна. | |
| 192 | 5.3.1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. | 1. Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 70 | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 131 дүгээр тогтоолоор "Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр"-ийг хэлэлцэн баталсан. Хөтөлбөрийг 2022 онд 78,5 2023 онд 79,6, 2024 онд 90,1 хувьтай хэрэгжүүлж ажилласан. Аймгийн төв болон 19 сумын хог хаягдлын цэгийн талбайг хумих, түрж булшлах, хашаа хамгаалалтыг сайжруулах ажлыг 3 жилийн хугацаанд зохион байгуулж хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайг 22 га талбайгаар багасгасан. Аймгийн хэмжээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах боломжтой 543 хогийн савыг байршуулж, булж устгах хог хаягдлын хэмжээг багасгаж, эдийн засгийн эргэлтэд оруулах дахивар, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэгч аймаг болохыг зорин ажиллаж байна. Уг ажлын хүрээнд Баянхонгор сумаас эхлэн Галуут, Баянлиг, Баянговь, Шинэжинст, Өлзийт, Заг, Хүрээмарал, Баян-Өндөр, Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан зэрэг нийт 11 сумдад хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг үе шаттайгаар нэвтрүүлж байна. Баянхонгор аймаг 2022 онд 1080,04 тн 2023 онд 8552,63 тн хог хаягдлыг ангилан эдийн засгийн эргэлтэд оруулсан байна. Мөн тээвэрлэсэн энгийн хатуу хог хаягдлын хэмжээг өмнөх оны мөн үетэй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | харьцуулахад 8657,72 тн-оор буурсан эерэг үзүүлэлттэй байна. | |
| 193 | 5.3.2. Баянхонгор сумын гэр хорооллыг цэвэр усны болон дулааны шугамд шат дараатайгаар холбоно. | 1. Баянхонгор сумын 4, 5 дугаар багийн гэр хорооллын айл өрхүүдийг цэвэр ус, дулааны шугам сүлжээнд холбох | 2022 - 2024 | | 100 | Баянхонгор сумын "Гэр хороолын гадна инженерийн шугам сүлжээ"-ний ажилд нэмэлтээр Баянхонгор сумын Угалз 4, Цагаанчулуут 5 дугаар багийн гэр хорооллын айл өрхүүдийг цэвэр ус, ариутгах татуурга, дулааны шугам сүлжээнд холбох ажил нь 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 345/2024 дүгээр магадлалын дүгнэлт гарснаар энэ онд барилга усралтын ажил хийгдсэн. Тус ажлын хүрээнд 4,5 дугаар багийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ ф50-ийн цэвэр усны нийт 1736м урт, ф75-ийн цэвэр усны нийт 1736м урт, ариутгах татуургын ф160-ийн шугам 1792м урт, ариутгах татуургын ф200-ийн шугам 410м урт бөгөөд 9ш ариутгах татуургын худаг, ф2000 худаг 2ш, ф1500 худаг 45ш, ф1000 худаг 53ш хийгдсэн. Энэ ажлын хүрээнд 9 зам сэтэлсэн. Баянхонгор сумын 4,5 дугаар багийн гадна дулаан, цэвэр усны ажил ф50-ф160-ийн дулаан, цэвэр усны нийт 3200м урт шугам төмөр бетон сувагчлалд хийгдэж нийт дулааны 44ш худгийн угсралтын ажлууд хийгдэж улсын комисс хүлээн авсан. | |